



НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,  
ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ХАРХОРИН, ЭРДЭНЭЗУУ ОРЧМЫГ  
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ОРЧИН ҮЕИЙН АРГАЧЛАЛААР  
ЖУУЛЧДЫН ТӨВ ХОТ  
БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ  
ХӨТӨЛБӨР**

**II БОТЬ**  
(ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ)



НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,  
ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭН



ТӨГС ШИЙДЭЛ ТӨВ

**“ХАРХОРИН, ЭРДЭНЭЗУУ ОРЧМЫГ  
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ОРЧИН ҮЕИЙН АРГАЧЛАЛААР  
ЖУУЛЧДЫН ТӨВ ХОТ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ  
ХӨТӨЛБӨР”**

(ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ)

НХТЭШЭТХ-ийн ЗАХИРАЛ

Г.БОЛД

НХТЭШЭТХ-ийн  
ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ГАНБАТ

НХТЭШЭТХ-ийн  
БҮС НУТГИЙН СЕКТОРЫН ЭРХЛЭГЧ

Ш.ТӨМӨРСҮХ

ТӨГС ШИЙДЭЛ ТӨВ-ийн  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

**ЗОХИОГЧДЫН БҮРЭЛДЭХҮҮН**

д/д	Овог нэр	Албан тушаал, мэргэжил	Гүйцэтгэсэн ажлын чиглэл
1.	Г.Болд	НХТЭШЗТХ-ийн захирал	Удирдлага, зохион байгуулалт
2.	Л.Ганбат	НХТЭШЗТХ-ийн Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга	Удирдлага, зохион байгуулалт
3.	Б.Даажав	Архитектурын ухааны доктор /Ph. D/	Архитектур, хот байгуулалтын зөвлөх
4.	Н.Уртнасан	Гүн ухааны доктор /Ph. D/	Түүх, соёл, шинжлэх ухааны зөвлөх
5.	Д.Даш	Газарзүйн ухааны доктор /Ph. D/	Газар зүйн зөвлөх
6.	Л.Ганбаатар	ДӨ-ОХСДГ-ын ХЗ-ны менежер	Дэлхийн Өвийн зөвлөх
6.	П.Мөнхбаяр	Газар зүйч, бүс нутаг судлаач	Газар зүй, бүс нутгийн зөвлөх
7.	Ш.Төмөрсүх	НХТЭШЗТХ-ийн Бүс нутгийн секторын эрхлэгч	Удирдлага зохион байгуулалт, судалгаа, хөтөлбөр боловсруулах
8.	Я.Шархүү	НХТЭШЗТХ-ийн зөвлөх архитектор, Монгол улсын Гавъяат барилгачин	Архитектур, хот байгуулалтын зөвлөх
9.	Б.Туяа	НХТЭШЗТХ-ийн зөвлөх эдийн засагч, Монгол улсын зөвлөх эдийн засагч	Эдийн засгийн зөвлөх
10.	Г.Нарангэрэл	НХТЭШЗТХ-ийн ахлах архитектор, Монгол улсын мэрэгшсэн архитектор	Судалгаа шинжилгээ, хөтөлбөр боловсруулах
11.	Н.Эгиймаа	НХТЭШЗТХ-ийн эдийн засагч	Эдийн засгийн судалгаа
12.	Б.Тунгалаг	НХТЭШЗТХ-ийн байгаль орчны мэргэжилтэн	Судалгаа шинжилгээ, хөтөлбөр боловсруулах (байгаль орчны хэсэг)
13.	Г.Нансалмаа	НХТЭШЗТХ-ийн усны барилгын инженер	Байгаль орчин, гадаргын болон газрын доорх ус
14.	П.Энхбаатар	НХТЭШЗТХ-ийн ахлах архитектор	Дэд бүтэц, зам тээвэр
15.	Д.Цолмон	НХТЭШЗТХ-ийн газар зохион байгуулагч	Газар зохион байгуулалт
16.	Б.Байгаль	НХТЭШЗТХ-ийн архитектор	Зураг, дизайн
17.	О.Амарзаяа	НХТЭШЗТХ-ийн архитектор	Зураг, дизайн
18.	Н.Наранбат	НХТЭШЗТХ-ийн архитектор	Зураг, дизайн
19.	О.Эрдэнэ-Өрнөх	"Төгс Шийдэл" төвийн гүйцэтгэх захирал	Удирдлага зохион байгуулалт, судалгаа, хөтөлбөр боловсруулах
20.	С.Буяндэлгэр	"Төгс Шийдэл" төвийн стратеги судлаач	Судалгаа шинжилгээ, хөтөлбөр боловсруулах
21.	М.Чимэддорж	"Төгс Шийдэл" төвийн зах зээл судлаач	Судалгаа шинжилгээ
22.	Б.Дөлгөөн	"Төгс Шийдэл" төвийн олон улсын зах зээл судлаач	Судалгаа шинжилгээ

## ГАРЧИГ

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ .....</b>	<b>6</b>
<b>ОРШИЛ .....</b>	<b>7</b>
<b>НЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХӨТӨЛБӨРИЙН ТОМЪЁОЛОЛ .....</b>	<b>11</b>
<b>1.1. Хөтөлбөрийн үндэслэл .....</b>	<b>11</b>
1.1.1. Хууль эрх зүйн зохицуулалт .....	11
1.1.2. Бодлогын баримт бичгүүд .....	11
<i>Үндэсний хөгжлийн цогц бодлого .....</i>	<i>11</i>
<i>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал .....</i>	<i>12</i>
<i>Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр .....</i>	<i>12</i>
<i>Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө .....</i>	<i>13</i>
<i>Хархорин хотын ерөнхий төлөвлөгөө .....</i>	<i>14</i>
<i>Аймаг, орон нутгийн бодлого чиглэл .....</i>	<i>14</i>
1.1.3. Хэрэгцээ шаардлага .....	15
<i>Хархорины аялал жуулчлалын бүсийн нийгэм, соёл, эдийн засгийн одоогийн байдал .....</i>	<i>15</i>
<i>Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын нөхцөл, нөөц ...</i>	<i>16</i>
<i>Хархорины аялал жуулчлалын бүсийн байгаль орчны өөрчлөлт .....</i>	<i>21</i>
<b>1.2. Хөтөлбөрийн бодлого, стратегийн томъёолол .....</b>	<b>22</b>
1.2.1. Дэлхийн болон бүс нутгийн аялал жуулчлалын сүлжээнд холбогдох стратегийн томъёолол .....	23
<i>Дутуу талаа ашиглахдаа боломжоо бодитой болгох буюу довтлох .....</i>	<i>24</i>
<i>Сул талаа арилгахдаа аюулаас зайлсхийх буюу хамгаалах .....</i>	<i>24</i>
1.2.2. Хархорины бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратегийн томъёолол .....	25
<i>Давуу талаа ашиглах, боломжоо бодит болгох буюу довтлох: .....</i>	<i>26</i>
<i>Сул талаа арилгах, аюулаас зайлсхийх буюу хамгаалах .....</i>	<i>26</i>
<b>1.3. Хөтөлбөрийн зорилго, зорилтуудын томъёолол .....</b>	<b>27</b>
1.3.1. Аялал жуулчлалын бүс .....	27
<i>Хархорины бүсийн аялал жуулчлалын эрх зүйн байдал .....</i>	<i>27</i>
<i>Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалт .....</i>	<i>27</i>
<i>Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын салбарын жолоодогч хүчний хөгжлийг хангах .....</i>	<i>29</i>
<i>Хархорины аялал жуулчлалын бүсийн бүсчлэл, дэд бүс, тэдгээрийн дээглэм .....</i>	<i>30</i>
1.3.2. Хархорины аялал жуулчлалын бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратегийн томъёолол .....	34
<i>Хархорины аялал жуулчлалын бүс дэх хот суурингууд, тэдгээрийн хөгжлийн уялдаа .....</i>	<i>34</i>
<i>Бат-Өлзий сум .....</i>	<i>35</i>
<i>Хужирт сум .....</i>	<i>35</i>
<i>Хашаат сум .....</i>	<i>36</i>
<i>Өгийнуур сум .....</i>	<i>36</i>
<i>Хотонт сум .....</i>	<i>37</i>
<i>Хархорин сум .....</i>	<i>37</i>

1.3.3. Хархорины аялал жуулчлалын бүсийн нийгэм, эдийн засгийг аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх ба байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах стратегийн томъёолол .....	39
<i>Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах</i> .....	39
<i>Нийгэм, эдийн засгийг аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх</i> .....	40
1.3.4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн .....	41
<i>Жуулчдын зорих газар, татах чадвар бүхий нөөц</i> .....	41
<i>Үйлчилгээ</i> .....	46
<i>Аялал жуулчлалын маршрут</i> .....	48
1.3.5. Аялал жуулчлалын бүсийн байгаль хамгаалал .....	54
<i>Байгаль орчинд халгүй хөгжил</i> .....	54
<b>1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг арга, хэрэгсэл</b> .....	<b>56</b>
1.4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл .....	56
1.4.2. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл.....	57
1.4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр.....	57
1.4.4. Олон нийтийн оролцоо .....	58
<b>ХОЁР. ХАРХОРИН, ЭРДЭНЭЗУУ ОРЧМЫГ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ОРЧИН ҮЕИЙН АРГАЧЛАЛААР ЖУУЛЧДЫН ТӨВ ХОТ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР</b> .....	<b>59</b>
<b>2.1. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл</b> .....	<b>59</b>
<b>2.2. Хөтөлбөрийн үндэслэл</b> .....	<b>59</b>
<b>2.3. Хөтөлбөрийн зорилго, зорилт</b> .....	<b>61</b>
2.3.1. Хөтөлбөрийн зорилго .....	61
2.3.2. Хөтөлбөрийн зорилтууд .....	61
<b>2.4. Хэрэгжүүлэх арга зам</b> .....	<b>62</b>
2.4.1. Хархорины аялал жуулчлалын бүсийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоо, хот суурингуудийг хөгжүүлэх талаар .....	62
2.4.2. Аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар .....	62
2.4.3. Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх талаар .....	62
2.4.4. Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих.....	62
<b>2.5. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</b> .....	<b>63</b>
<b>2.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа</b> .....	<b>63</b>
<b>2.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт</b> .....	<b>63</b>
<b>2.8. Хөтөлбөрийн үр дүн</b> .....	<b>64</b>
<b>2.9. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт</b> .....	<b>64</b>
<b>2.10. Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгох хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө</b> .....	<b>66</b>
<i>Нэгдүгээр үе шат (2009-2018 он)</i> .....	66
<i>Хоёрдугаар үе шат (2019-2028 он)</i> .....	77
<b>2.11. Хавсралт зургууд</b> .....	<b>84</b>

<b>ГУРАВ. ХАВСРАЛТ</b> .....	<b>101</b>
<b>3.1. Судалгаа, үнэлгээ</b> .....	<b>101</b>
3.1.1. Дэлхийн хандлага .....	101
3.1.2. Салбарын бүтэц .....	101
3.1.3. Салбарын SWOT шинжилгээ .....	102
3.1.4. Тур операторуудын үйл ажиллагааны талаарх шинжилгээ .....	103
<i>Зорих газар</i> .....	104
<i>Татах чадвар бүхийн аялал жуулчлалын нөөц</i> .....	104
<i>Жуулчны бааз</i> .....	104
3.1.5. Хархорины аялал жуулчлалын бүсийн жуулчдын зорих газруудын үнэлгээ .....	105
3.1.6. Хархорины аялал жуулчлалын бүсийн татах чадвар бүхий нөөцүүдийн үнэлгээ .....	106
3.1.7. Хархорины аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазуудын үзүүлэлт.....	107
3.1.8. Бүтээгдэхүүний таталцах байдлын шинжилгээ .....	108
<i>Зорих газар болон түүний эргэн тойрон дахь татах чадвар бүхий нөөцүүд тэдгээрийн таталцалд хийсэн шинжилгээ</i> .....	109
<i>Зорих газрууд болон таталцлын үнэлгээ</i> .....	110
<i>Соёлын аялал жуулчлалын нөөцийн байдал</i> .....	111
3.1.9. Дүгнэлт .....	116
3.1.10. Хархорины аялал жуулчлалын бүсийн зорих газрууд, татах чадвар бүхий нөөцүүдийн үнэлгээний зургууд .....	116

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ**

<b>ААНБ</b>	Аж ахуйн нэгж, байгууллага
<b>АХ</b>	Археологийн хүрээлэн
<b>БНХАУ</b>	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
<b>БОАЖЯ</b>	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
<b>БСШУЯ</b>	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
<b>ДӨ-ОХСДГХЗ</b>	Дэлхийн Өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа
<b>ЗТБХБЯ</b>	Зам Тээвэр, Барилга, Хот Байгуулалтын Яам
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчийн хурал
<b>МГХҮТ</b>	Монгол гэрийг хөгжүүлэх үндэсний төв
<b>ОХБЦГ</b>	Орхоны хөндийн байгалийн цогцолбор газар
<b>ОХБЦГХЗ</b>	Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа
<b>ОХСДГ</b>	Орхоны хөндийн соёлын дурсгалт газар
<b>ОХУ</b>	Оросын Холбооны Улс
<b>ӨМӨЗО</b>	Өвөр Монголын Өөртөө засах Орон
<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>ТӨҮГ</b>	Төрийн өмчит үйлдвэрийн газар
<b>УБЗТИ</b>	Улсын барилгын зургийн төв институт
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ХАА</b>	Хөдөө аж ахуй
<b>ХАЖБЗ</b>	Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргаа
<b>ХНБЦГ</b>	Хангайн нурууны байгалийн цогцолбор газар
<b>ХХААХҮЯ</b>	Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам
<b>ЦШСГ</b>	Цахилгаан шугам сүлжээний газар
<b>ШТС</b>	Шатахуун түгээх станц
<b>ЭБЭХЯ</b>	Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам
<b>ЈICA</b>	Japan International Cooperation Agency (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг)
<b>UNESCO</b>	United Nations Educational, Scientific and Cultural Organization (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага)

## ОРШИЛ

Барилга Хот Байгуулалтын Яамны Сайдын 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдөр баталсан 02 дугаар зургийн даалгавар, мөн яамны Барилгын захиалагчийн албатай 2007 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан 68/2007 тоот гэрээг үндэслэн “Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах ажлыг Нийслэлийн Хот Төлөвлөлт, Эрдэм Шинжилгээ, Зураг Төслийн Хүрээлэнд (туслан гүйцэтгэгч Төлөвлөлт судалгааны “Төгс Шийдэл” төвтэй хамтран) хийж, гүйцэтгэлээ. Хөтөлбөрийг боловсруулахдаа бүс нутгийн түвшинд нийгэм эдийн засгийн, байгаль экологийн, хот байгуулалт, дэд бүтцийн болон аялал жуулчлалын талаархи иж бүрэн судалгаа явуулсны үндсэн дээр дүн шинжилгээ хийн, хөтөлбөрийн томъёоллыг боловсруулах, улсын болон орон нутгийн төр захиргаа, хувийн хэвшил, орон нутгийн иргэд ба сонирхогч, оролцогч гэсэн бүх талуудыг оролцуулах, бүсийн газар нутагт үүрэг зориулалтын дагуу байгаль-экологийн хамгаалалтын бүс, аялал жуулчлалын үндсэн болоод дэд бүсүүдийг тогтоох зэрэг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалыг хэрэглэсэн.

Дэлхий нийтээр тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдэд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэн ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх хандлага улам бүр нэмэгдэж байна. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын 2007 онд гаргасан тайланд тусгагадсанаар дэлхийн аялагчид, аяллын шинэ зорих газруудыг хайж байгаа тухай дурьдаад энэ хэрэгцээг нь орон бүрийн өвөрмөц соёлууд ихээхэн хангаж буй талаар дурьджээ. Энэ нь нүүдэлчдийн өвөрмөц соёл бүхий Монгол улс нь дэлхийн жуулчдын сонирхол татахуйц зорих газруудын тоонд багтах боломжтойг харуулж буй юм.

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод "Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно" гэж заасан нь аялал жуулчлалын салбарт төрөөс ихээхэн өндөр ач холбогдол өгч байгааг илтгэж байна.

Хархорин, Эрдэнэзуу болон энэхүү хөтөлбөрт хамрагдаж байгаа зургаан сум (Хужирт, Хархорин, Бат-Өлзий, Хотонт, Хашаат, Өгийнуур)-ын аялал жуулчлалын хөгжил нь Монгол орны бусад бүс нутгуудтай харьцуулахад илүү байна. Дэд бүтэц, жуулчдад үзүүлж буй үйлчилгээ, жуулчин хүлээн авах хүчин чадал, жуулчдын тоо, тус бүс нутагт аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж байгаа компаниудын тоо зэргээрээ бусад аймаг, бүс нутгуудаас харьцангуй өндөр байна. Энэ нь тус бүс нутагт дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдсөн Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар багтаж байгаа болон бага зайд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, жуулчдын сонирхлыг татах байгалийн үзэсгэлэнт газар, нүүдлийн соёлын өв нэгэн дор байгаа нь тус бүс нутгийг дотоодын өрсөлдөөнд төдийгүй олон улсын түвшинд илүү давуутай нөхцлийг олгож байна.

Хархорин орчмын бүс нутаг нь олон төрлийн тусгай хамгаалалттай газрын огтлолцол дээр байрладаг. Тухайлбал UNESCO-ийн Дэлхийн Өвд бүртгэсэн газар



нутаг, Орхоны хөндийн байгалийн цогцолбор газар зэргийг дурдаж болох юм. Мөн Монгол улсын аялал жуулчлалын “Босоо тэнхлэг” буюу Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл гэсэн байгалийн бүс бүслүүрээрээ говь (жуулчдын хувьд үлэг гүрвэл, археологи, паленталогийн үнэт олдворуудтай бүс), хээр тал (нүд алдам хээр тал энэ нь далайг санагдуулам байдаг талаар олон жуулчдын тэмдэглэлээс харж болно), хангай (халуун хүйтэн рашаан, эртний шашны болон түүхийн дурсгалт газрууд, дэлхийд цэнгэг усны нөөцөөрөө хоёрдугаарт орох Хөвсгөл нуур)-г холбосон энэ тэнхлэгийг БНХАУ (Цагаан хэрэм, ӨМӨЗО-ны Ордос)-д болон ОХУ (Байгаль нуур)-д аялал жуулчлалын хүрэлцэн ирэгсдийн дэд бүтэцтэй холбож чадвал Монгол улс, Хархорины бүсийн аялал жуулчлалын хөгжилд төдийгүй Монгол улсын аялал жуулчлалын хөгжилд ихээхэн чухал нөлөө үзүүлнэ.

Монгол улсын аялал жуулчлалын салбарын нэг томоохон зорих газар нь Хархорин, Эрдэнэзуу хийд байсаар ирсэн билээ. Гэвч Хархорум хотын туурь, Эрдэнэзуу музей зэрэг аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүнүүд нь жуулчдын зорин ирсэн, үзэхийг хүссэн хүлээлтэд хүрдэггүй, сэтгэл ханамжгүй буцдгийг аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аль ч компаний хийсэн судалгаанаас харж болно.

Хархорины бүс нутаг нь эко-аялал жуулчлал, түүх соёлын аялал жуулчлал, рашаан сувиллын аялал жуулчлал болон нүүдлийн өв соёлыг таниулсан ахуйн ба урлагийн тоглолт, бусад арга хэмжээнд тулгуурласан аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлэхэд шаардлагатай аялал жуулчлалын бүтээгдэхүүнээр баялаг хэдий боловч тэдгээр нөөцөд тулгуурлан олон улсын аялал жуулчлалд чиглэсэн менежмент, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт хийх замаар аялал жуулчлалын жинхэнэ бүтээгдэхүүн бий болгох асуудал дутагдалтай байна.

Тус бүсийн аялал жуулчлалын нөөцийн ашиглалтын байдал хангалтгүй байгаагийн зэрэгцээ нэг нөөц дээр хэт төвлөрсөн байдалтай байгаа нь аялал жуулчлалын салбар тогтвортой, үр ашигтай хөгжихөд саад учруулдаг.

Улаан цутгалан, Төвхөн хийд, Хөшөө цайдам, Өгий нуур, Хар балгас, Хархорум хотын туурь, Эрдэнэзуу хийд, Хужиртын халуун рашаан, Хятрууны халуун рашаан, Шанхын баруун хүрээ хийд, Орхон гол гэх мэт гадаад, дотоодын аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн нь экологийн тэнцвэргүй байдалд орох нөхцөл бүрдсэн. Эдгээр бүтээгдэхүүн болон тэдгээрийн хүрээлэн буй орчинд байгаль хамгаалал сул, тогтвортой аялал жуулчлалын зарчмууд хэрэгжихгүй байна. Ийм байдлаар цаашид үргэлжилбэл эко-аялал хөгжих нөхцөлгүй, түүх соёлын үнэт дурсгалууд сүйтэж үгүй болох эрсдэлтэй орчин үүсээд байна.

Монголын нүүдлийн соёлыг танилцуулах тоглолт, наадмуудыг зохион байгуулж байгаа боловч байршлын хувьд зайтай, цаг хугацааны хувьд уялдаагүй зохион байгуулагдахын зэрэгцээ нэгдсэн зохион байгуулалт сул, хоорондоо хамааралтай биш байна. Ийм жижиг хэмжээний олон арга хэмжээнүүд нь жуулчдын сонирхолыг бага татаж байгаа нь судалгаагаар нотлогдсон.

Иймд Хархорин Эрдэнэзуу орчмын бүс нутгийг цогцоор нь аялал жуулчлалын бүс нутаг болгон татах хүчийг нь нэмэгдүүлэх чиглэлд төрөөс болон

хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын зүгээс нэгдмэл үйл ажиллагаа явуулж чадвал хөтөлбөрийн зорилго, зорилтууд биелэх бүрэн бололцоотой юм.

Энэ хөтөлбөрийг боловсруулах ач холбогдол нь энэ чиглэлээр хийгдэж байсан судалгааны ажлуудын үр дүн, одоогийн бодит нөхцөл байдал, хэтийн төлөвийн уялдаа холбоог хангасан цогц баримт бичиг боловсруулан Хархорины аялал жуулчлалын бичил бүс нутгийг урт хугацаанд хөгжүүлэх, хот байгуулалтын болон аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэхэд чухал нөлөөтэй юм.

Тус хөтөлбөрийн судалгааны арга зүй, хөтөлбөр боловсруулах ажлын иж бүрдэл, ажлын график, төлөвлөгөөг эхлэлийн тайланд тусгаж 2008 оны 1 сард захиалагчид хүлээлгэн өгсөн.

Орон нутагт эхний судалгааг 2008 оны 1 дүгээр сарын 16-наас 22-ны хооронд Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хот, Хархорин хот, Архангай аймгийн төв Цэцэрлэг хот гэсэн чиглэлээр явуулж, өнөөгийн нөхцөл байдалтай урьдчилан танилцах, орон нутгийн удирдлагауудтай уулзаж, орон нутгийн удирдлагын зүгээс Хархорин, Эрдэнэзуу орчмыг жуулчлалын төв хот болгон хөгжүүлэх асуудлаар ямар байр суурьтай байгаа талаарх болон бусад шаардлагатай мэдээлэл авч санал солилцон харилцаа холбоо тогтоолоо.

Орон нутагт хийсэн хоёр дахь судалгааг 2008 оны 4 дүгээр сарын 14-нөөс 30-ны хооронд хоёр баг болон хийсэн. Эхний баг нь бүс нутаг дахь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, зорих газруудын татах чадвар, нөөц, аялал жуулчлалын дэд бүтцийг газар дээр нь үзэж танилцан, тодорхойлох зорилгоор, хоёр дахь баг нь хөтөлбөрт хамрагдсан 6 сумдын нийгэм, эдийн засаг, хот суурингийн төлөвлөлт, барилгажилт, газар зохион байгуулалт, зам тээвэр, инженерийн байгууламж, дэд бүтэц, байгаль экологийн байдалтай газар дээр нь танилцах, орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж төсөл хөтөлбөрөө танилцуулан, тодруулга судалгаа болон орон нутгийн саналыг авах, шаардлагатай зураг авалт хийн, схем зурагт тэмдэглэн оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Судалгааны явцад Зам Тээвэр, Барилга Хот Байгуулалтын Яам, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Архангай болон Өвөрхангай аймгуудын Засаг даргын Тамгын газар, Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Хотонт, Хашаат, Өгийнуур сумдын Засаг даргын Тамгын газар, Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, Дэлхийн Өвийн Монголын үндэсний хороо, Дэлхийн Өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа, Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа болон бусад холбогдох газрууд, эрдэмтэн мэргэжилтнүүдээс холбогдох чиглэлээр санал, судалгаа, мэдээлэл авч тусгасан.

Орон нутагт хийсэн судалгаа, Яамд, орон нутгийн засаг захиргааны байгууллагууд, эрдэмтэн мэргэжилтнүүдийн санал дүгнэлтүүд дээр үндэслэн хөтөлбөрийн судалгааны багийнхан Явцын тайланг боловсруулан 2008 оны 5 сард захиалагчид хүлээлгэн өгсөн.

Тус хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд суурин болон орон нутагт хийсэн судалгааны үр дүн болон хөтөлбөрт дэвшүүлж байгаа үзэл баримтлалын

талаар холбогдох салбарын яамдын удирдлага, мэргэжилтнүүд, судлаачид, оролцогч аж ахуйн нэгжүүдийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийг 2008 оны 7 дугаар сарын 16-нд зохион байгуулж санал, хүсэлтийг нь авч хөтөлбөрт тусган сайжруулсан.

Орон нутагт хийсэн гурав дахь судалгааг 2008 оны 7 дүгээр сарын 20-оос 29-ний хооронд явуулж, хөтөлбөрт хамрагдсан 6 сумдын болон Өвөрхангай, Архангай аймгуудын ЗДТГ, орон нутгийн холбогдох байгууллага, мэргэжилтнүүдийг оролцуулан хөтөлбөрийн төслийн талаар танилцуулга хийж, нэмэлт санал хүсэлтийг нь авч хөтөлбөрт тусгасан.

2008 оны 8 дугаар сарын 25-аас 29-нд "Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын үнэт зүйлсийг цогцоор хамгаалах Менежментийн төлөвлөгөөг боловсронгуй болгох, Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрыг хадгалж хамгаалах менежментийн захиргааг байгуулах төсөл"-ийн хүрээнд Хархорин хотод болсон үндэсний семинарт илтгэл тавьж хэлэлцүүлэн гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдын санаа бодлыг энэхүү хөтөлбөрт тусган сайжруулсан.

Энэхүү төгсгөлийн тайлан нь **Судалгааны ажлын дүн, шинжилгээ, хөтөлбөрийн томъёолол, Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр** гэсэн үндсэн хоёр бүлэг, хавсралтаас бүрдэнэ. Судалгааны ажлын дүн, шинжилгээ, хөтөлбөрийн томъёолол гэсэн бүлэгт судалгаан дээрээ үндэслэн боловсруулсан хөтөлбөрийн үндэслэл, хөтөлбөрийн бодлого стратеги, хөтөлбөрийн зорилго зорилтууд, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг арга хэрэгслүүдийг томъёолон орууллаа. "Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр"-ийн төсөл нь Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл, Хөтөлбөрийн үндэслэл, Хөтөлбөрийн зорилго, зорилт, Хэрэгжүүлэх арга зам, Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, Хөтөлбөрийн үр дүн, Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө гэсэн бүлгүүдээс бүрдэж байна.

## **НЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХӨТӨЛБӨРИЙН ТОМЪЁОЛОЛ**

### **1.1. Хөтөлбөрийн үндэслэл**

#### **1.1.1. Хууль эрх зүйн зохицуулалт**

Барилга Хот Байгуулалтын Яамны Сайдын 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдөр баталсан 02 дугаар зургийн даалгаварын дагуу Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөрийг боловсрууллаа.

UNESCO-ийн Дэлхийн Өвийн Хороо Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрыг Дэлхийн соёлын өвийн II, III болон IV шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байна гэж 2004 онд Дэлхийн соёлын өвөөр бүртгэсэн.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай 01 дүгээр тогтоолд заасны дагуу *Хархорин хот нь Хангай бүсийн хоёр тулгуур төв хотын* нэг гэсэн заалт.

“Бүсийн тулгуур төв хотыг тогтоох тухай” Улсын Их Хурлын 2003 оны 1 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 136 дугаар захирамж.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.14-т *“Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна”* гэсэн заалт.

#### **1.1.2. Бодлогын баримт бичгүүд**

Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр нь 2003 онд УИХ-аар батлагдсан *“Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”*, 2004 онд Дэд бүтцийн яамаар батлагдсан *“Хархорин хотын ерөнхий төлөвлөгөө”*, 2006 онд Монгол улсын Засгийн газраар батлагдсан *“Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр”*, 2006 онд Монгол улсын Засгийн газраар батлагдсан *“Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”*, 2001 онд Архангай аймгийн ИТХ-аар батлагдсан *“Архангай аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”*, 2006 онд Өвөрхангай аймгийн ИТХ-аар батлагдсан *“Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр”*, 2008 онд УИХ-аар батлагдсан *“Монгол улсыг 2021 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөгжлийн цогц бодлого”* болон холбогдох бусад эрх зүйн бичиг баримтууд дээр үндэслэгдсэн.

#### **Үндэсний хөгжлийн цогц бодлого**

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтыг эрчимжүүлнэ, “Хотууд” үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно, “Аялал жуулчлал” үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ гэж заасан нь аялал жуулчлалын салбарт төрөөс ихээхэн өндөр ач холбогдол өгч байгааг илтгэж байна.

Аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого чиглэлийг 2021 он хүртэл тодорхойлохдоо, нэгдүгээр шат нь 2007-2015 он, хоёрдугаар шат нь 2016-2021 он хүртэл хоёр үе шаттайгаар цогц бодлого хэрэгжүүлнэ гэж заасан.

Нэгдүгээр үе шат (2007 - 2015)-нд тавьж буй стратегийн зорилтууд

*Зорилт 1.*

Жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулна. Үүнд:

- Аялал жуулчлалын голлох зах зээлийн орнууд руу хийх шууд нислэгийн тоог нэмэгдүүлж, шинэ чиглэлүүд нээнэ.
- Аялал жуулчлалын гол бүс нутгуудын зам, харилцаа холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах ажлыг бусад салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

*Зорилт 2.*

Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ. Үүнд:

- Улирлын хамаарлыг багасгаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулна.
- Салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтэц бий болгож ажиллуулна.
- Монголд ирэх жуулчдын тоог нэг саяд хүргэнэ.

Хоёрдугаар үе шат (2016 – 2021)-нд тавьж буй стратегийн зорилтууд

Аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэж сайжруулна:

- Бүх төрлийн үйлчилгээний стандартыг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна.
- Ажилтнуудын боловсрол, сургалтын түвшинг олон улсын жишигт хүргэж, салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.
- Монголд ирэх жуулчдын тоог хүн амын тоотой тэнцүүлнэ гэж тус тус томъёолсон байна.

**Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал**

Монгол Улсын Их Хуралаар 2001 онд батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Хархорин хотыг Хангайн бүсийн тулгуур төв болгон хөгжүүлэхээр заасан байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. (Зураг 1)

**Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр**

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу “Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна

Тус хөтөлбөрт Хангайн бүсийг түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууддаа түшиглэн дотоод, гадаадын аялал жуулчлалыг хөгжүүлэх маш тохиромжтой нутаг гэж үзэж байгаа бөгөөд үүнээс Архангай, Өвөрхангай

аймагт түүх, соёл иргэншил, байгаль судлал, амралт сувилал, морин аяллыг түлхүү хөгжүүлэх боломжтой гэж үзсэн байна.

Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан аялал жуулчлалыг бүс нутаг бүрт цогцолбороор, төрөлжүүлэн хөгжүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлд анхаарч ажиллана .

Мөн Хангайн бүсийн аймгуудыг хамарсан аялал жуулчлалын сүлжээ байгуулах, уг сүлжээг ОХУ-ын Байгаль нуур болон ӨМӨЗО-ы аялал жуулчлалын сүлжээнд холбох бодлого баримтлан ажиллахаар төлөвлөсөн байна.

Аялал жуулчлалын хөгжлийг хөтөлбөрт хоёр үе шаттайгаар боловсруулж, нэгдүгээр шатанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах замаар бүсийн аялал жуулчлалын сүлжээ байгуулж, стандартыг дээшлүүлэн олон улсын сүлжээнд холбоно (2006-2010), хоёрдугаар үе шатанд аялал жуулчлалын салбарын бүсийн эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, менежментийг олон улсын стандартад хүргэнэ (2011-2015) гэсэн тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна. (Зураг 2, 3)

### ***Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө***

2006 оноос Монгол Улсын аялал жуулчлалын салбарын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Тус мастер төлөвлөгөөнд Аялал жуулчлалын салбарыг тэрүүлэх салбар болгон авч үзсэн бөгөөд аялал жуулчлалын салбарын зорилго зорилтуудыг шинэчлэн боловсруулж оруулсан нь аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудалд төрөөс хандах хандлагыг өөрчилж илүү далайцтай үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангаж байна.

Аялал жуулчлалын салбарын эрхэм зорилгыг ***“Ирсэн зочлогч байгальдаа уялдан уусч, монголын ард түмэн, соёлын найз нөхөр нь болдог нэр хүнд бүхий зорих газар бол Монгол юм”*** гэсэн байдлаар томъёолжээ.

Эрхэм зорилгод Монгол улсыг байгаль, соёлын татах үзмэрүүд голлосон зорих газар болохыг дүрслэн илэрхийлэх шаардлагатай гэж үзээд шалтгааныг нь Монгол бол өөрөө байгаль дэлхий ба нүүдэлчин соёл, ахуй, зан заншил нягт уялдан холбогдсон газар нутаг гэж тайлбарласан байна.

Монголын Аялал жуулчлалын зорилгыг дараах дэд зорилгуудад хуваан авч үзсэн байна. Үүнд:

- Нийгмийн халамж;
- Эдийн засгийн хөгжил;
- Аялал жуулчлалын дэд бүтэц;
- Байгаль орчин ба соёл;
- Аялал жуулчлалын маркетингийн менежмент;
- Хүний нөөцийн хөгжил

Тус мастер төлөвлөгөөнд аялал жуулчлалыг хөгжүүлэх стратегийн талаар ойрын хугацаанд Улаанбаатар, Хархорин, Өмнөговь дахь аялал жуулчлалын төвийг бэхжүүлж, Хөвсгөл, Хэнтий, Өлгий орчимд өвөрмөц сонирхлын жуулчлалыг хөгжүүлэх замаар Монголын аялал жуулчлалын үндэс суурийг бүрдүүлэх, дунд болон урт хугацааны зорилт болгон Улаанбаатар, Хархорин, Өмнөговь гэсэн үндсэн 3 бүс нутгийг цаашид хөгжүүлэхийн зэрэгцээгээр Дорноговь, Ховд, Дорнод,

Баянхонгор, Алтай зэрэг бүс нутагт өвөрмөц сонирхлын аялал жуулчлалыг шинээр хөгжүүлэх саналыг дэвшүүлсэн.

### ***Хархорин хотын ерөнхий төлөвлөгөө***

Тус ерөнхий төлөвлөгөөнд Хархорин хотын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг аялал жуулчлал-үйлдвэрлэл, үйлчилгээ тэргүүлсэн Хангайн бүсийн засаг захиргаа, шинжлэх ухаан мэдээлэл, нийгэм соёлын үйлчилгээний төв байхаар төлөвлөжээ. Аялал жуулчлал, амралт сувиллыг эрчимтэй хөгжүүлснээр аялал жуулчлалын төв болохоос гадна Дэлхийн Өвийн судалгаа шинжилгээний томоохон объектын нэг байхаар тусгажээ.

Хотын төвийн хэсэг нь Хотын шинэ төв, Олон улсын аялал жуулчлалын төв, Их хаадын цогцолбор гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Хотын шинэ төвийн хэсэгт засаг захиргааны ордон, шинжлэх ухаан мэдээлэл-технологийн болон бизнесийн төв, банк, театр зэрэг цогцолборууд, аялал жуулчлалын төвийн хэсэгт өндөр зэрэглэлийн зочид буудал, үзэсгэлэн, үзвэрийн танхим, холбоо мэдээллийн болон худалдаа үйлчилгээний цогцолборууд, Их хаадын цогцолборт хүндэтгэл ёслолын өргөө бүхий их хаадын үзэсгэлэнгийн танхимууд, Монгол судлал, Угсаатны зүйн судалгаа шинжилгээний төв, нүүдлийн соёл иргэншил, угсаатны зүйн музей, үзвэр үйлчилгээний цогцолборууд байхаар төлөвлөжээ. Спорт амралт зугаалгын бүсэд цэнгэлдэх хүрээлэн, спортын ордон, соёл амралтын хүрээлэн, усан спортын комплекс, гольфын талбай шинээр байгуулахаар тусгажээ. Энэхүү “Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г 2004 онд “Хот байгуулалт” ТӨҮГазар боловсруулан Засгийн газар баталсан боловч түүнийг хэрэгжүүлэх ажил өнөөг хүртэл хийгдэж эхлээгүй байна.

Ерөнхий төлөвлөгөөг Орхоны хөндийг Дэлхийн Өвд бүртгэн авахаас өмнө боловсруулсан учраас дулааны цахилгаан станц, цэвэрлэх байгууламж, цахилгааны Хархорин дэд станц, 110 кв-ийн цахилгаан дамжуулах шугам зэрэг хотын дэд бүтцийн үндсэн байгууламжууд нь Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсэд орсон байна. Иймд Дэлхийн Өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалтын шаардлагатай уялдуулан Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

### ***Аймаг, орон нутгийн бодлого чиглэл***

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 4-р сарын 14 өдрийн 31-р тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан Өвөрхангай аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрт дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- “Монгол улсын түүх соёлын өв, газар нутгийн төв, цутгуурын урлагын дэлхийн хаан, Монголын шашны анхдугаар тэргүүн Чингис хааны алтан ураг их Богд өндөр гэгээн Занабазарын төрсөн өлгий, хангай, говь, тал, хээр хосолсон үзэсгэлэнт Өвөрийн сайхан хангайгаар зочлон ирж тухлан амарна уу” гэсэн уриан дор аялал жуулчлал хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх;
- Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзүүлэх үзүүлбэрийг гарган хэрэгжүүлэх;
- Байгаль экологи, түүх, соёл, урлаг, спортын аялал жуулчлалыг хөгжүүлэх;

- Амралт-сувиллын болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Татварын тогтолцоог боловсронгуй болгож төсвийн орлогод аялал жуулчлалын салбарын оруулах хэмжээг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлал эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, аялал жуулчлалын салбарт иргэдийн оролцоог өргөжүүлэх;
- Аялал жуулчлал эрхлэх боломж нөхцлийг бүрдүүлэх. (Дэд бүтцийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, мэрэгшиж сурах нөхцлийг бий болгох);
- Жуулчдын тээвэр, байр, хоол хүнсний үйлчилгээний чанарыг сайжруулан аюулгүй байдлаар хангах, үйлчилгээний болон харьцааны соёлыг сайжруулах;
- Аялал жуулчлалын мэдээллийн төвийг бий болгох.

### 1.1.3. Хэрэгцээ шаардлага

#### **Хархорины аялал жуулчлалын бүсийн нийгэм, соёл, эдийн засгийн одоогийн байдал**

Хархорины аялал жуулчлалын бүс буюу хөтөлбөрийн хамрах хүрээ нь Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Архангай аймгийн Хашаат, Хотонт, Өгийнуур сумд буюу нийт 2 аймгийн 6 сумын нутаг дэвсгэрийг хамарна. (Зураг 4)

*Хүснэгт 1. Хөтөлбөрт хамрагдаж байгаа сумдын нийгэм, эдийн засгийн одоогийн байдал /2007 оны байдлаар/*

№	Үзүүлэлтүүд	Хотонт	Хашаат	Өгийнуур	Хархорин	Хужирт	Бат-Өлзий	Нийт
1.	Өрхийн тоо	1312	888	801	3422	1901	1820	10144
2.	Хүн амын тоо	4874	3395	3047	12533	6496	6077	36422
3.	Малын тоо	208.74	208.9	157.8	190.6	168.7	116.0	1050.7
4.	Малчин өрхийн тоо	1067	719	654	1085	1118	1061	5704 /55.7%/
5.	Багийн тоо	6	5	5	8	5	4	33
6.	Төсвийн орлого (мян. төг)	51392.2	-	18908.6	334143.6	64209.5	75066.3	
7.	Төсвийн зарлага (мян. төг)	51392.2	-	89254.5	1643320.2	675447.0	585824.4	
8.	Ажил эрхлэлт	2376	1541	1340	4451	2641	3112	15461
9.	ААНБ-н тоо	40	51	40	167	56	74	428

Хархорины аялал жуулчлалын бүсэд хамрагдах нэр бүхий зургаан сумын төсөвт аялал жуулчлалын салбар маш бага орлого бүрдүүлж байна. Сүүлийн 50 гаруй жил Монгол улсын аялал жуулчлал Хархорины бүсэд тулгуурлан хөгжиж ирсэн. Цаашдаа ч энэ нөхцөл байдал хэвээр байх төлөвтэй байна.



Гэтэл орон нутгийн төсөвт тодорхой орлого бүрдүүлэх замаар сумдын эдийн засагт бодитой нөлөөлөл үзүүлэхүйц бодлого боловсруулж хэрэгжүүлэхгүй байгаа нь аялал жуулчлалын салбар энэ бүсэд урт хугацаанд хөгжихөд саад учруулж байна. Бүсийн эдийн засаг хөгжилгүй, нутгийн иргэд, малчид бага орлоготой ядуу байх нь аялал жуулчлалын аюулгүй байдал болон жуулчид аялагчдын сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлнө.

Хархорины аялал жуулчлалын бүсийн иргэд, малчдын аялал жуулчлалын талаарх хандлага өөрчлөгдөж байна. Тэд аялал жуулчлалыг өөрөөсөө ангид, тусдаа зүйл гэж ойлгож байсан бол өнөөдөр жуулчлалаас орлого олж болдог, орлогын нэг эх үүсвэр гэдэг ойлголттой болоод байна. Цаашдаа Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалыг нутгийн иргэдэд суурилсан, тэдэнд орлогын эх үүсвэр болгох талаас бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хэдийгээр энэхүү хандлага зөв боловч нүүдлийн соёлын биет бус өвийн хадгалалт, олон үе дамжин залгамжилж ирсэн өв уламжлал алдагдахад хүрч байна. Иргэд, малчид жуулчид, зочин гийчдыг хүндэтгэн харилцах зан уламжлал алдагдаж зөвхөн арилжаа наймааны нүдээр харах явдал их болсон. Түүнчлэн тэдний ахуйн соёл ихээхэн өөрчлөгдөж малын гаралтай эдлэл хэрэгслэл ховордон, морь малаа техникээр хариулах явдал их болжээ. Нүүдлийн соёлын биет ба биет бус өвийг хадгалах, унаган төрхөөр нь хойч үедээ дамжуулах замаар урт хугацаанд тасралтгүй хөгжих аялал жуулчлалын хөрс суурийг бүрдүүлэх ёстой юм.

Нутгийн иргэд, малчдын аялал жуулчлалаас олох орлогын нэмэгдүүлэхийн хамт тэдний ахуйн соёлын буруу өөрчлөлтийг хязгаарлаж нүүдлийн соёлын биет бус өвийг хадгалан үлдэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулан хэрэгжүүлэх асуудал тулгамдаж байна.

Сумдын эдийн засгийг аялал жуулчлалаар дамжуулан хөгжүүлэх, тэдний тулгуур салбарт аялал жуулчлалыг жинхэнэ утгаар нь байлгахын тулд шат дараалсан олон төрлийн ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Хархорины бүсэд өнөөдөр аялал жуулчлалын дайвар ба хавсарга үйлчилгээ маш сул хөгжилтэй байна. Үүний шалтгаан нь бүсийн аялал жуулчлалыг системтэй, хөдөлмөрийн хуваарьтайгаар хөгжүүлээгүйтэй холбоотой. Цаашдаа энэ асуудлыг шийдвэрлэхгүйгээр аялал жуулчлалын хөгжлийг томъёолох, төлөвлөх бололцоогүй юм.

### ***Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын нөхцөл, нөөц***

Хархорины аялал жуулчлалын бүс нь аялал жуулчлалын нөхцөл, нөөцийн хувьд харьцангуй бага нутгийг хамардаг боловч өргөн агууламжтай, байгалийн үзэсгэлэн, түүх соёлын дурсгал, нүүдлийн соёлын биет ба биет бус өвийн хувьд жуулчдын сонирхолыг татахуйц ач холбогдол, нөөцтэй юм.

Хархорины аялал жуулчлалын бүс нутагт UNESCO-гийн Дэлхийн Соёлын Өвд 2004 онд бүртгэгдсэн 120 гаруй мянган га газар хамрагдаж байна. Дэлхийн соёлын Өвд бүртгэгдсэн явдал нь Орхоны хөндийг дэлхий нийтийн аялал жуулчлалын сүлжээнд хамрагдах өргөн боломжийг нээсэн.

Ийм өргөн боломжийг нээхийн хамт нүүдлийн соёлын үнэт зүйлийг хадгалж тэтгэсэн, дэвшилтэт уламжлалыг өвлөн хөгжүүлсэн, байгаль, нүүдлийн соёлд хор нөлөөгүй орчин үеийн авсаархан үйлдвэрлэл хөгжсөн, уян хатан дэд бүтэцтэй, үйлчилгээний салбар хөгжсөн, орчин үеийн хөдөлгөөнт өндөр технологийг ашигласан, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын амьд сүлжээ хөгжсөн нүүдлийн соёлын орчин үеийн тогтвортой хөгжлийн бүс нутаг байхыг шаардаж байна.

Хэдийгээр Дэлхийн соёлын Өвд бүртгэгдэн аялал жуулчлалын дэлхий нийтийн өргөн сүлжээнд хамрагдсан нь давуу тал боловч жуулчдыг хүлээн авах дэд бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээ хангалттай сайн биш байна. Тус бүс нутгийн аялал жуулчлалын салбарт өрсөлдөөн бодит утгаараа бий болж чадаагүй байна.

Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын нийт нөхцөл, нөөцийн 40 орчим хувийг байгалийн үзэсгэлэн, амралт зугаалга, 40 орчим хувийг түүх, соёл, шашины зан үйл, нүүдэлчдийн ахуй амьдрал, үлдсэн 20 орчим хувийг рашаан эмчилгээний аялал жуулчлалыг хөгжүүлэх бололцоотой гэж томъёолж болно.

Жуулчдын зорих газар, жуулчдын татах чадвар бүхий нөөц гэсэн үндсэн хоёр ангилалд 50 орчим нөөцүүд байна. Цаашдаа аялал жуулчлалын нөөцөд хамруулан жуулчны үндсэн маршрутад оруулж болох 15 орчим нөөц газар байна.

Түүх, соёлын чиглэлийн аялал жуулчлалын нөөцийн ашиглалт хангалтгүй, хамгаалалт сул, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр түүх соёлын үнэт өв сан устах, төрхөө алдах, дахин сэргээгдэхгүй гэмтэлд орох зэрэг байдал улам даамжирах болсон. Энэ нь аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын нөөцийн хамгаалалтыг иж бүрэн хэмжээнд хийхэд чиглэсэн цогц хамгаалалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх асуудал тулгамдаж буй юм.

Хархорины аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлал хөгжүүлэх тулгуур нөхцөл нь аялал жуулчлалын нөхцөл нөөцийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, тэнцвэрт байдлыг хангах, ирээдүйд ирэх аялал жуулчлалын даацад суурилсан бүтээн байгуулалтыг хийх зэргээс шууд хамаарна.

Хөтөлбөр хэрэгжих бүс нутгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал нь тогтвортой бус аялал жуулчлалын бүс гэж тодорхойлогдож байна. Аялал жуулчлалаас байгаль орчин, нийгэм соёлд үзүүлэх сөрөг нөлөөлөл өндөртэй ангилалд Хархорины аялал жуулчлалын бүс багтаж буй юм.

Монгол улсад орчин үеийн аялал жуулчлал хөгжиж эхэлсэн 1960-аад оноос хойш Хархорин, Эрдэнэзуу, Орхоны хөндийн байгалийн болоод түүхийн дурсгалуудыг үзэж сонирхох гадаад, дотоодын жуулчдын тоо өсөн нэмэгдсээр ирсэн. Энэ утгаараа Хархорины аялал жуулчлалын бүс нутаг нь аялал жуулчлалын хөгжилтэй уялдан гардаг эерэг ба сөрөг үр дагваруудыг өөртөө агуулж байгаа Монгол улсын гурван бүс нутгийн нэг юм.

Аялал жуулчлал, амралт зугаалгаас үүдэн байгалийн үзэсгэлэнт газруудын экологийн тэнцвэртэй байдал алдагдан, түүнийг нөхөн сэргээх зардал нь эргээд аялал жуулчлалын салбараас орж ирэхгүй байгаагийн зэрэгцээ аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж буй компаниуд жуулчдын зорих газар, жуулчдыг татах чадвар бүхий нөөцүүдийн хамгаалалт, хадгалалт, тогтвортой байдалд санаа тавихгүй

байна. Аялал жуулчлалын нөөцүүд нь шавхагдашгүй нөөцийн ангилалд ордог боловч хадгалалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, арчилгаа хийхгүй бол устан үгүй болох эрсдэлтэй байдаг. Энэ эрсдэл нь тус бүсэд бодитойгоор нүүрлээд байна.

Хархорины аялал жуулчлалын бүсийн өнөөгийн дэд бүтэц нь жуулчлалыг хөгжүүлэхэд хангалтгүй байна. Хархорины аялал жуулчлалын дэд бүсүүд, үндсэн ба дэд маршрутуудыг нарийвчлан тогтоогоогүйгээс нэг газар луу чиглэсэн олон салаа замууд бий болоод байна. Энэ нь жуулчид төөрөх, маршрутын хугацаа алдах, жуулчид очих ёстой газартаа хүрэхгүй байх, байгалийн сөрөг нөлөө, аюулд өртөх явдлыг нэмэгдүүлж байна.

Хархорины аялал жуулчлалын бүсэд байгаа аялал жуулчлалын нөөцүүдийн ашиглалтыг сайжруулах, жуулчны баазуудын хэт төвлөрлийг сааруулах, нөөцийг шинээр бий болгох, сурталчилах, аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулах, нөөцийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн урт хугацааны иж бүрэн хөтөлбөр боловсруулах шаардлагатай байна.

Японы JICA байгууллагын 2003 онд хийсэн аялал жуулчлалын судалгаанд Орхоны хөндийн аялал жуулчлалын үйл ажиллагааны түвшинг А зэрэглэлд авсан байна. Энэ нь улсын хэмжээнд аялал жуулчлалын үйлчилгээ илүү хөгжсөн Улаанбаатарын Тэрэлж, Говийн бүстэй ижил түвшинд хүрсэн гэсэн утга илэрхийлж байна. Гэвч аялал жуулчлалын үйлчилгээний нэг хэсэг болох жуулчны баазуудад хийсэн судалгаанаас үзэхэд зохих түвшинд хүрэхгүй байгаа нь ажиглагдлаа.

Орхоны хөндийд байрлах жуулчны баазууд нь ихэвчлэн Монгол гэрээр үйлчилдэг бөгөөд нэг гэрт 2-4 хүн хүлээн авдаг нийтлэг дүр төрх байна. Жуулчны баазуудын үзүүлж байгаа үйлчилгээ нь гэр буудал, хоолны үйлчилгээгээр хязгаарлагдаж байна. Цөөн жуулчны баазууд теннис, волейболын талбай, билльярдаар үйлчилдэг ч энэ жуулчдын хувьд тийм ч оновчтой үйлчилгээ болж чадахгүй байна.

Морин аялал, завь зэргээр үйлчилгээ үзүүлдэг жуулчны баазууд байгаа боловч үйлчилгээний хувьд төрөлжөөгүй, нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлаж байна.

Судалгаанд хамрагдаж байгаа 6 сумын нутагт нийт 41 жуулчны бааз 497 гэрээр үйлчилгээ үзүүлж нийт 1501 хүн нэг ээлжиндээ хүлээн авах хүчин чадалтай. Жуулчдад гэр буудлуудын орчин, хэв маяг нь нүүдэлчдийн амьдралын талаар бодит төсөөлөл өгч чаддагаараа онцлог боловч ирээдүйд жуулчны баазуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйлчилгээний стандартыг дэлхийн жишигт хүргэх зайлшгүй шаардлагатай.

### ***Хархорины аялал жуулчлалын бүсийн хот байгуулалтын хөгжлийн өнөөгийн байдал***

#### **Хархорины бүлэг суурингийн тогтолцоо, хот суурингуудын одоогийн байдалд хийсэн шинжилгээ**

Тус бүс нутгийн хот, суурингуудын өнөөгийн ерөнхий байдлыг дүгнэж үзэхэд, Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотоос бусад 5 сумын төв нь өнөөг хүртэл хот байгуулалтын батлагдсан ерөнхий төлөвлөгөө байхгүй байна. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу 2004 онд боловсруулан, Засгийн Газраар батлуулсан “Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын хөгжлийн

ерөнхий төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх талаар тодорхой ажил өнөөг хүртэл хийгдээгүй байна. (Зураг 5)

Тус аялал жуулчлалын бүсийн хот, суурингуудын өнөөгийн ерөнхий байдлыг дүгнэж үзэхэд, газар ашиглалтын бүсүүд эмх цэгцгүй, барилгажилт багатай, сийрэгдүү, барилгын давхаржилт бага байна.

Хот, суурингуудын нилээд хэсгийг гэр хороолол эзлэх бөгөөд эхнээсээ төлөвлөлтгүйгээр байгуулагдаж, уламжлалт гэр сууц зонхилсон энэ хэсэгт хот, суурингийн хүн амын дийлэнх хэсэг нь оршин сууж байна.

Цахилгаанаас бусад инженерийн шугам сүлжээ байхгүй, хотын үндсэн дэд бүтэц бүрдээгүй, усан хангамжийн төвлөрсөн систем байхгүй, Хархорин хотод нэгэнт бий болсон дэд бүтцийг бүрэн ашиглаж чаддаггүй, дулааны төвлөрсөн системтэй боловч зарим шугамыг нь хөлдөөсөн тул ашиглахгүй байна. Хот, суурины барилга, архитектурын чанар, тохижилтын түвшин доогуур, хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн шаардлагад нийцэхгүй байна. Эдгээр байдал нь аялал жуулчлалын хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байна.

Цаашид Хархорины аялал жуулчлалын бүсэд байгаа хот суурингуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг нэн яаралтай боловсруулан, хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна. Хот суурингуудын одоо байгаа газар нутгийг тэлэхгүйгээр одоо нэгэнт бүрдсэн суурьшлыг нягтруулах, дахин зохион байгуулах замаар хөгжүүлэх нь зүйтэй юм.

Хархорин хотын орчимд хийсэн байгаль-экологийн судалгаагаар тухайн бүс нутгийн хөрсний хэв шинж, өөрчлөгдөж буй шалтгаан, нөхцөл, ирээдүйд гарч болох элсний нүүдэл, цөлжилт тоосжилтийн сөрөг үр дагаварууд зэргийг тооцоолон хот байгуулах экологийн даацын үнэлгээ зэрэгт үндэслэгдсэн ямар хэмжээний хот байж болох тухай дүгнэлт гаргахдаа хот байгуулах экологийн даацад нийцсэн жижиг, дунд хотууд байх нь илүү тохиромжтой гэж үзсэн байна. Хэт олон хүн амтай төвлөрөл ихтэй хот байх нь одоогийн эмзэг экосистемийн хувьд сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөртэй гэж дүгнэсэн байна.

*Хархорины аялал жуулчлалын бүсийн дэвсгэр нутгийн зохион байгуулалт, газар ашиглалтад хийсэн шинжилгээ*

Хөтөлбөр нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Архангай аймгийн Өгийнуур, Хашаат, Хотонт сумдын нутгийг хамарч байгаа бөгөөд нийт талбайн хэмжээ нь 1 307 630 га буюу 13 076.3 км<sup>2</sup>. Энэ нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 0.83 хувь, Архангай, Өвөрхангай аймгуудын нийт нутаг дэвсгэрийн 11.06 хувьтай тэнцэх хэмжээ юм.

Тус зургаан сумдын нийт нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн газар 927 950.79 га буюу 71%-ийг, ойн сан бүхий газар 112153.0 га буюу 8.6%-ийг, усан сан бүхий газар 4 824.0 га буюу 0.3 %, зам, шугам сүлжээний газар 2 807.65 га буюу 0.2%-ийг, хот тосгон бусад суурин газар 5 341.8 га буюу 0.4% хувийг, тусгай хэрэгцээний газар 254 552.8 га буюу 19.5 %-ийг тус тус эзэлж байна.

*Хөдөө аж ахуйн газрын ангилал*

Тус сумдын нийт нутаг дэвсгэрийн 71 хувь буюу 927 950.79 га газрыг хөдөө аж ахуйн газар эзэлдэг ба үүнд бэлчээр, хадлан, тариалан, хөдөө аж ахуйн

барилга байгууламжийн дэвсгэр газар багтаж байна.

*Хот, тосгон, бусад суурины газрын ангилал*

Тус ангиллын нийт талбай 5341.8 га юм. Энэ ангиллын газарт барилга байгууламжийн доорх газар, амралт рашаан сувиллын газар, иргэн, аж ахуй нэгж байгууллагын өмчлөл, эзэмшил ашиглалтын газар, нийтийн эдэлбэрийн газар, үйлдвэр, уурхай, гэр хорооллын газар багтана.

*Хүснэгт 2. Газрын нэгдмэл сан, 2007 он (га-аар)*

д/д	Газрын ангилал	Талбайн хэмжээ /га/		
<b>Нийт нутгийн хэмжээ</b>		<b>1 307 630.00</b>		
<b>1</b>	ХАА-н газар бүгд	<b>927 950.80</b>		
	Үүнээс:	Бэлчээр	862 514.05	
		Хадлан	19 117.00	
		Тариалангийн газар	6 773.00	
		Үүнээс:	Тариалангийн талбай	6 600.00
			Атаршсан газар	39 002.60
ХАА-н барилга	544.10			
<b>2</b>	Хот тосгон бусад суурин газар	<b>5 341.80</b>		
<b>3</b>	Зам, шугам сүлжээний газар	<b>2 807.70</b>		
	Үүнээс:	Эрчим хүчний	688.20	
		Холбооны	546.50	
		Авто зам	1 022.95	
		Төмөр зам		
		Бусад		
<b>4</b>	Ойн сан бүхий газар	<b>112 153.00</b>		
<b>5</b>	Усан сан бүхий газар	<b>4 824.00</b>		
<b>6</b>	Тусгай хэрэгцээний газар	<b>254 552.80</b>		
	Үүнээс:	Байгалийн цогцолборт газарт	254 469.30	
		Байгалийн дурсгалт газарт	20.80	
		Цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	62.70	

*Зам, шугам сүлжээний газар*

Газрын тухай хуулинд “Зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна” гэж заасан байдаг. Зам, шугам, сүлжээний газрыг дараах ангилалд хуваагдана. үүнд:

- төмөр замын газар
- автозамын газар
- агаарын тээврийн газар
- шугам, сүлжээний газар
- усан тээврийн газар

Тус ангиллын газрын нийт хэмжээ 2807.65 га ба нийт нутаг дэвсгэрийн 0.2% ийг эзлэж байна.

### *Ойн сан бүхий газар*

Газрын тухай Монгол Улсын хуулийн 14-р зүйлийн дагуу ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас, ойг өсгөн үржүүлэхэд зориулсан газар, ой тэлэн ургах боломжийг хангахуйц газрууд ойн санд хамрагдана. Ой тэлэн ургах нөөц газарт ойн захаас 100 метр хүртэлх газрыг оруулна.

Дээрхи нөхцлүүдийг харгалзан тус зургаан сумын ойн сангийн газрыг тооцож үзэхэд 112153.0 га буюу нийт нутаг дэвсгэрийн 8.6 хувийг эзэлж байна.

### *Усан сан бүхий газар*

Газрын тухай Монгол Улсын хуулийн 15-р зүйлд зааснаар нуур, цөөрөм, тойром, мөрөн, гол, горхи, булаг шанд, мөнх цас, мөсөн голын эзлэх талбайг усан сан бүхий газарт хамруулан авч үздэг.

Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журамд заасны дагуу 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс байхаар тогтоосон байдаг. Усны гольдрол, усыг бохирдохоос хамгаалах зорилгоор усны эргээс гадагш 50 метр хүртэл зайг усны эрэг орчмын газарт тооцож бүртгэлд авна гэсэн байна. Нийт талбайн хэмжээ нь 4824.0 га болно.

### *Тусгай хэрэгцээний газар*

Хархорины аялал жуулчлалын бүс нутаг нь олон төрлийн тусгай хамгаалалттай газрын огтлол дээр байрладаг. Тухайлбал Хангайн нурууны байгалийн цогцолбор газар зэргийг дурдаж болох юм. Хамгаалалтанд авсан үндсэн шалтгаан нь тухайн бүсэд түүхийн ховор нандин дурсгалууд, нүүдлийн соёлын үнэт өв хадлагдаж байгаагийн зэрэгцээ байгалийн хосгүй сайхан тогтоц бүхий газар нутаг юм. Дээрхи сумдын хувьд UNESCO-ийн Дэлхийн Өвд бүртгэсэн газар нутаг, байгалийн цогцолборт газар, байгалийн дурсгалт газар, цаг агаарын байнгын ажиглалтын талбай зэрэг дэд ангилалд багтах тусгай хэрэгцээний газрууд байна. Эдгээрийн нийт талбайн хэмжээ нь 254 552.8 га юм. (Зураг 13, 14, 15)

Аялал жуулчлалын бүсийг тогтоох, түүний шалтгаан, аялал жуулчлалын бүс дэх дэглэм тогтоох ажил Хархорины бүсэд хийгдэж байгаагүй учир бүсийн нутаг дэвсгэрийн харилцан уялдаа, тавигдах шаардлагуудыг харгалзан аялал жуулчлалын бүсийн хил заагийг тодорхойлсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулах дэглэмийг нь тогтоох шаардлагатай байна.

### ***Хархорины аялал жуулчлалын бүсийн байгаль орчны өөрчлөлт***

Судлаачдын үзэж байгаагаар дэлхийн дулаарлын улмаас Монгол орны нийт нутгийн агаарын температур 0.7 хэмээр өссөн гэсэн мэдээлэл байдаг. Энэхүү уур амьсгалын өөрчлөлтөөс нийт нутаг дэвсгэрийн 25 %-ийг хамарсан ган 2-3 жилд нэг удаа, 50 %-иас дээш нутагт тархсан ган 4-5 жилд нэг удаа тохиолдож, тал хээр, говийн бүс нутгаар шороон шуургатай өдрийн тоо олон болсон, нутаг дэвсгэрийн цөлжилтийн үйл явц газар авч, нуур, гол, булаг шандын ус ширгэх, бэлчээрийн ургамлын гарц муудах, хөрс үржил шимээ алдах, элсний нүүлт ихсэх зэрэг үзэгдэл нэмэгдсэн байна.

Цаг агаарын энэ ерөнхий өөрчлөлт нь Хархорины бүс нутагт ч нөлөөлж байна. Тухайлбал Архангай аймгийн Хашаат, Хотонт, Өгийнуур ба Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт цөлжилт эрчимтэй явагдаж, шороон шуургатай өдөр олон болж, гол горхи, рашаан ширгэх явдал эрс нэмэгдэж байна.

Хархорины аялал жуулчлалын бүс нутагт хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны өөрчлөлт их болсон. Тухайлбал олон салаа зам, үлэмж хэмжээний ой мод тайрах (ихэнх нь залуу ой), рашаан усны эхийг булингартуулах, хог хаягдлаар дүүргэх, уул уурхайн үйл ажиллагаа явуулан экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах, малын тоо толгой (ямаа) нэмэгдэн бэлчээрийн талхлалтийг ихэсгэх зэргээр хүний буруутай үйл ажиллагаа байгаль орчинд үлэмж хэмжээний хор хохирол үзүүлэх боллоо.

Дэлхийн цаг агаарын ерөнхий өөрчлөлт ба хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны доройтол нь Хархорины бүсэд урт хугацаанд аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэхэд бэрхшээл учруулахаар байна. Иймд Хархорины бүсийн байгаль орчныг нөхөн сэргээж, дунд ба урт хугацаанд байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх иж бүрэн төлөвлөгөө багтаасан тогтвортой аялал жуулчлалын хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай.

Тус бүс нутгийн газарзүйн байрлал, газар тариалангийн зориулалтаар их хэмжээний газрыг боловсруулалтанд оруулж байсан ба одоо ихэнх талбайг нь атаршуулсан зэрэг нь мөн цөлжилт, хөрсний элэгдэлд хүчтэй нэрвэгдэх эмзэг байдлыг бий болгож байгаа бөгөөд түүнээс урьдчилан сэргийлэх, ногоон зурвас, хаалт байгуулах, ойжуулах ажлыг өргөн хүрээнд явуулах шаардлагатай юм.

## **1.2. Хөтөлбөрийн бодлого, стратегийн томъёолол**

Стратегийн хэрэгжүүлэлтийг төлөвлөгдсөн хэд хэдэн тактикаар дамжуулан хэрэгжүүлэхээр тусгав. Тактикийн төлөвлөлтийг хийхдээ юун түрүүн асуудлын бодит байдал буюу байршлыг тодруулах, түүнд тохирсон үйлдэл ба гарцыг боловсруулахад анхаарсан.

Энэхүү төлөвлөлт нь цаг хугацааны хувьд хараат бөгөөд энэ байдал өөрийнх нь сул тал болно. Өөрөөр хэлбэл цаг хугацаа өнгөрч бусад өрсөлдөгчид хариу үйлдэл, хамгаалалт, довтолгоо хийж эхлэхэд төлөвлөснийг өөрчлөх шаардлагатай байна.

### **Дэлхийн ба бүс нутгийн аялал жуулчлалын хандлага**

Дэлхий нийтээр “утаагүй үйлдвэрлэл” буюу аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар эдийн засгийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, орон нутгийн иргэдэд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэн ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх хандлага улам бүр нэмэгдэж байна.

Дэлхийн хэмжээнд 2007 онд 898 сая жуулчин бусад орон руу жуулчилсан байна. Судлаачдын үзэж байгаагаар цаашдаа энэ тоо нь жилийн 5.2 хувийн өсөлттэй байх ба 2020 он гэхэд дэлхий даяар нэг тэрбум хүн бусад орон руу аялал жуулчлал хийх тооцоо гарч байна.

Зүүн Азийн бүс нутгийн хэмжээнд аялал жуулчлалын нэгдсэн системд холбогдох, дэлхий нийтийн аялагчдыг бүс нутагт татах зорилгоор нэгдсэн

томоохон маршрут бий болгох хандлага хүчтэй болж байна. Нэг удаагийн аяллаар гурван өөр орны гурван өөр соёл, гурван өөр байгалийн үзэсгэлэнг үзэж сонирхох боломжийг жуулчдад нээснээр Зүүн Хойд Азийн бүс нутаг аялал жуулчлалынхаа орлогыг нэмэгдүүлэх бололцоотой. Энэ ажлын хүрээнд Монгол улсын аялал жуулчлалын сүлжээг ОХУ, БНХАУ-ын томоохон зорих газруудтай дэд бүтэц, маршрутаар холбох, нэгдмэл ивэнт (event), нэгдмэл сурталчилгаатай болгох шаардлагатай байна.

Бүс нутгийн аялал жуулчлалын цаашдын хамтын ажиллагааг бодит ажил хэрэг болгоход Монгол улсын зүгээс аялал жуулчлалын Өмнөговийн бүс, Хархорины бүс, Нөмрөгийн дархан газрын бүс, Хөвсгөл нуурын бүс, Тэрэлж-Улаанбаатарын бүс гэсэн таван бүлэг, зорих газраар дамжуулан Зүүн Азийн бүс нутгийн аялал жуулчлалын сүлжээнд холбогдох бололцоотой. Иймд Хархорины бүс нутгийг урт хугацаанд тогтвортой аялал жуулчлал хөгжсөн, дэлхийн аялагчдын татах жуулчдын томоохон бүс байхаар хөгжүүлэх шаардлагатай байна.

ОХУ-ын Байгаль нуур болон БНХАУ-ын Цагаан хэрэм, Чингисийн онгон (ӨМӨЗО) зэрэг жуулчдыг ихээр татаж байгаа газруудыг хооронд нь холбох гүүр байдлаар Хархорины бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой юм. Нөгөө талаар БНХАУ, ОХУ-ын Байгаль нуурт ирж буй аялагч, жуулчдын хувьд Монгол орноор аялж, тал нутаг, нүүдэлчдийн соёлыг үзэж сонирхох эрэлт их байна. Иймд Зүүн Азийн аялал жуулчлалын тулгын гурван чулууны нэг нь Хархорины бүс нутаг байхаар хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

### 1.2.1. Дэлхийн болон бүс нутгийн аялал жуулчлалын сүлжээнд холбогдох стратегийн томъёолол

Хархорины аялал жуулчлалын бүсийг Азийн аялал жуулчлалын бүсүүд, таталцалын төвүүдтэй холбох. Нэн түрүүнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Чингисийн онгоны цогцолбор, ОХУ-ын Байгаль нуурийн аялал жуулчлалын бүсүүдтэй хуурай болон агаарын замаар холбох шаардлагатай байна.

SWOT шинжилгээг хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3.

Давуу тал	Сул тал
<ol style="list-style-type: none"> <li>Орос, Хятад гэсэн томоохон аялал жуулчлалын зорих орнуудын дунд байршилтай;</li> <li>ОХУ ба Европын орнуудаас Ази тив рүү хуурай замаар нэвтрэхэд дайран өнгөрөх газар болдог;</li> <li>Нүүдэлчдийн өдөр тутмын амьдрал бол аялагчдыг өөрсдийг нь оролцуулан (жишээ нь: хонь хариулах, адуу малд явах, хонь холбох, үхэр саах г.м) үйлдэгдэх боломжтой;</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Хархорины бүсэд жуулчдад үйлчилгээ үзүүлэх цогцолбор байхгүй (амралт, зугаа цэнгээн. Энэ нь хамгийн их орлого олдог сегмент юм);</li> <li>Улсаас нэгдсэн бодлогоор аялал жуулчлалын бүсүүд болон цогцолборуудыг хөгжүүлдэггүй;</li> <li>Хархорины аялал жуулчлалын бүсэд дэд бүтцийн хөгжил шаардлагатай хэмжээнд хүрээгүй;</li> <li>Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэхээр төлөвлөж буй газар нутагт мал сүргийн тоо харьцангуй их, хүн амын нягтрал өндөр.</li> </ol>
Боломж	Аюул



<ol style="list-style-type: none"> <li>1. Хөрш орнуудын сонгож авсан атрактивууд нь Монгол улсын хилтэй ойрхон тул авто замаар холбосноор зардал багатай;</li> <li>2. Манай орныг зорих бус зөвхөн дамжин өнгөрөх аялагчдаас ч орлого олох боломжтой (энэ хоёр оронд жилд 15 сая аялагчид зорчдог гэсэн статистик мэдээ байдаг);</li> <li>3. ОХУ-ын Байгаль нуурийн экотуризмын бүс, ӨМӨЗО-ны Чингис хааны цогцолборуудтай нэгдмэл хэлбэрээр зар сурталчилгаа зохион байгуулах.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1. Угсаа гарал нэгт Өвөр Монголчууд нь түүх, соёлын аялал жуулчлалын хувьд дэлхийд Монголын түүхээр өөрсдийгөө сурталчилж байгаа нь бидэнд ялгарах онцлогтой байхыг шаардаж байна;</li> <li>2. Орхоны хөндийд аялал жуулчлалын бизнес эрхэлж байгаа байгууллагуудын стандартыг хангалтгүй шалгаж байгаа нь чанаргүй үйлчилгээ үзүүлж жуулчдыг дахин ирэх сэдлийг бууруулах;</li> <li>3. Орхон голын эхэнд алтны 2 том үйлдвэр ажилладаг. Энэ нь голын ус татрах, яваандаа ширгэх эх үүсвэр болно.</li> </ol>
--	---

Стратегийн биелэлтийн оновчтой байдал нь тактикийн үр дүнтэй хэрэгжүүлэлтээс шууд хамаарна.

### ***Дутуу талаа ашиглахдаа боломжоо бодитой болгох буюу довтолох***

*(Мэдээлэл сурталчилгааны хувьд нэгэн зэрэг олон чиглэлд ажиллах)*

Аялагч нь эх орноосоо гарахын өмнө аялах маршрутаа гаргадаг тул мэдээлэл сурталчилгаанд анхаарах. Эхний ээлжинд Оросоос Хятад руу, Хятадаас Орос руу аялах дөт бөгөөд замдаа Дэлхийн соёлын Өвийн үнэт зүйлс, нүүдэлчдийн соёл, Монголын өргөн уудам тал нутаг, байгалийн үзэсгэлэнт газруудаар дайран өнгөрөх маршрутаар аялах боломжтой гэдгийг таниулах. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хоёрдугаар шат буюу 2019 оноос эхлэн дайран өнгөрөх маршрутаас гадна Хархорины бүс нутаг болон бусад бүсүүд, аялал жуулчлалын цогцолборуудаар аялал хийх боломжтойг сурталчилан таниулах.

ОХУ, БНХАУ-уудын агаарын болон авто замын зогсох, буудаллах цэгүүдэд Хархорины бүсийн талаарх мэдээлэл сурталчилгааг идэвхижүүлэх. Хөтөлбөрийн хэрэгжилтээс хамааран Хархорины бүсийн маршрутын үнэ, үйлчилгээний хүртээмж, дайран өнгөрөх үзмэрийн тоо зэргийг ялгавартай тогтоох.

Бүсийн хүчтэй байр суурийг бий болгохын тулд салбар хоорондын уялдааг сайжруулах, сегмент хоорондын хослолыг нэмэгдүүлэх. Татах хүчтэй сегментэд шинэ байр суурийг эзлэх буюу салбарын багцыг нэмэгдүүлэх.

### ***Сул талаа арилгахдаа аюулаас зайлсхийх буюу хамгаалах***

*(Бүтээгдэхүүний шугамыг өргөжүүлэх буюу өрсөлдөгчийн нэвтрэх замыг хаах)*

Эртний Хархорум хотын туурийг хамгаалалтанд авах, археологийн үзмэрүүдээр музей байгуулах, жуулчны баазууд, зочид буудлын зэрэглэлийг дээшлүүлэх. Өгөөдэй хааны Түмэн Амгалан ордныг түүх, археологийн судалгаанд үндэслэн барьж босгох.

Олон ястны өлгий гэсэн дэд бүс байгуулснаар нүүдэлчдийн өвөрмөц дэд соёлуудыг аялагчдад харуулах. Нүүдэлчдийн улирлын шинжтэй ажил (мал хөнгөлөх, эмнэг хангал сургах, адуу дэллэх, унага тамгалах, гүү барих, хонь хяргах, эсгий хийх, нүүдэллэх г.м)-ууд болон өдөр тутмын ажил (сүү боловсруулах, гэрийн дээс томох, бүч томох, сүлжих зэрэг)-уудыг соёлын аялал жуулчлалын

бүтээгдэхүүн болгох тал дээр дэд хөтөлбөр боловсруулан ажиллах. Энэ нь аялагч өөрөө гар бие оролцдоогоороо сүүлийн үеийн аялал жуулчлалын хандлага, аялагчдын эрэлтэд хамгийн их нийцсэн бүтээгдэхүүн болно.

### 1.2.2. Хархорины бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратегийн томъёолол

Хархорины бүсийн аялал жуулчлалыг түүх соёл, рашаан эмчилгээ сувилал, байгалийн үзэсгэлэн, эрдэм шинжилгээ зэрэг дөрвөн үндсэн дэд бүсэд хуваана. Аялалын маршрутууд нь бүс дамнасан ба бүсийн доторх гэсэн хэлбэрүүдтэй байна.

Дэд бүсүүдийн аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ зорих газрууд тэдгээрийн ойролцоо байрлах татах чадвар бүхий нөөцүүдийн хоорондын уялдааг үнэлсэн таталцлын шинжилгээнд суурилна. SWOT шинжилгээг хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4.

Давуу тал	Сул тал
<ol style="list-style-type: none"> <li>Орхоны хөндий нь Дэлхий өвд бүртгэгдсэнээрээ аялагчдын сонирхлыг татна. Ирсэн аялагчдад нүүдэлчдийн соёлын биет болон биет бус өвийг зөвөөр таниулан өөрсдөд нь мэдрүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>Рашаан эмчилгээний жуулчлал нь 7-21 хоног буюу урт хугацаатайгаараа онцлог учир орлогын хувьд өндөр сегмент;</li> <li>Эртний Хархорум хот нь дэлхий даяар, ялангуяа ойрын зах зээл болох Японд мэдээлэл сайтай;</li> <li>Одоогоор зорих газар бүхий ихэнх цэгүүдэд жуулчны баазууд байгуулагдсан ба тэдгээрийг хөгжүүлэх боломжтой;</li> <li>Бага талбайд зорих газар, татах чадвар бүхий нөөцүүдийн нягтаршил ихтэй нь зардал багатай аялал хөгжих боломжтой.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Одоо байгаа халуун хүйтэн рашаануудад түшигэлсэн сувилал, тэдгээрийн байгууламжууд нь дэлхийн түвшнээс хоцрогдсон үйлчилгээ, орчин, технологитой;</li> <li>Байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх дэд бүс болох Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт байгаль хамгаалал хангалтгүй (мод тайралт ихтэй), байгалийн үзэсгэлэн болон түүхийн дурсгалуудын хамгаалалт муу (эртний хиригсүүрүүдийг удаа дараа ухсан г.м);</li> <li>Эртний Хархорум хотын туурь нь жуулчдад үзүүлэх үзмэргүй;</li> <li>Эрдэм шинжилгээний дэд бүс болгохоор төлөвлөж буй Өгий нуур нь Орхон голын татралтаас шалтгаалан сэлгэлт хийгдэхгүй болсон;</li> <li>Бүс рүү орох, гарах замын сүлжээ бүрэн байгуулагдаж дуусаагүй, бүс доторх зарим чиглэлийн авто зам нь хатуу хучилтгүй байгаа нь хөрсний эвдрэлийн нэг шалтгаан болж байгаа.</li> </ol>
Боломж	Аюул
<ol style="list-style-type: none"> <li>Хархорины бүс нутагт эрх зүйн болон бодит хамгаалалтыг хийснээр байгаль экологийн хувьд удаан хугацаанд тэнцвэрт байдлаа хадгалах боломжтой;</li> <li>Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн талаарх мэдээллийг бүсийн суурь</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Орхон голын ус татарч байгаа, цаашдаа ширгэх аюултай;</li> <li>Бүсийн байгаль экологийн асуудал хүндэрч байна. Шалтгаан нь бүсэд хэт их мал ялангуяа ямаа байгаагаас бэлчээрийн даац муудаж цөлжилт ихсэж</li> </ol>

<p>мэдээлэл болгон цацсанаар тухайлсан сегмент дахь эрэлтийг үүсгэх боломжтой;</p> <p>3. Бүсийн удирдлага зохион байгуулалтыг нэгдмэл болгох эрх зүйн зохицуулалтыг хийж өгөх;</p> <p>4. Бүсийг олон улсын аялал жуулчлалын парк болгон хөгжүүлэх.</p>	<p>болсон;</p> <p>3. Бүс дэх малчид уламжлалт нүүдлийн соёл (адуу малаа хариулах, уламжлалт нүүдэл, сур элдэж боловсруулан хэрэглэх, дээс томох гэх мэт өдөр тутмын зарим уламжлалт зан үйл)-оо гээж байгаа нь соёлын аялал жуулчлалын хөгжилд сөрөг нөлөөлөл үзүүлнэ.</p>
--	--

***Давуу талаа ашиглах, боломжоо бодит болгох буюу довтолох:***

*(дэд бүсүүдийн хөгжил нь бүсийн уялдааг өөрөө хангана)*

Эмчилгээ сувиллын чиглэлийн аялагчдын оруулах орлого өндөр тул халуун хүйтэн рашаанд түшиглэн энэ чиглэлийн ялангуяа биеийн алжаал тайлах сувилгааг эрчимтэй хөгжүүлэх. Нөгөө талаар энэ нь нэг цэг дээр хамгийн удаан буюу 7-21 хүртэл хоногоор байрладаг тул маршрутын нийт орлого өндөр, зардал нь байгалийн аялал жуулчлалтай харьцуулахад бага буюу тогтмол байдаг.

Бүсийн нутаг дэвсгэрт эртний түүхт улс гүрнүүдийн хот балгадын туурь их байдаг тул энэ давуу талаа ашиглан тухайн тууриудад өндөр зэрэглэлийн тухлах жуулчны баазууд, зочид буудлуудыг барьж байгуулах.

Бүсийн дотор өндөр зэрэглэлийн захиалгат жуулчлалын төрлүүдийг зохион байгуулах, маршрутуудыг бий болгох. Тухайлбал:

- Шонхороор ан хийх
- Тэмээн жингээр нүүдэл хийх, жирийн нүүдэлчин айлд амьдрах
- Загас агнуурын аялал
- Үхэр тэргээр аялах г.м

***Сул талаа арилгах, аюулаас зайлсхийх буюу хамгаалах***

Бүсийн гол горхи, нуурыг ай саваар нь хамгаалах эрх зүйн болоод бодит хамгаалалтын тогтолцоог бий болгон мөрдөх.

Бүсэд байх айл өрхийн тоог хязгаарлах боломжгүй тул нэг өрхийн малын тоог хязгаарлах, уламжлалт нүүдлийн соёлоо хадгалан үлдсэн айлуудыг тогтмол урамшуулах тогтолцоог бий болгох.

Шинээр байгуулах жуулчны бааз, түр буудаллах буудлуудыг аялал жуулчлалын бааз, үйлчилгээний байгууллагын эргэн тойрон 10 км дотор нэмж байгуулахгүй байх. Үүнийг газрын зөвшөөрөл олгохгүй байх журмаар цэгцлэх.

Аялал жуулчлал эрхлэхээр сонгосон газрыг дуудлага худалдаа явуулж шудрага өрсөлдүүлэн олгох, хэрэв өрсөлдөгчгүй бол төсөл шалгаруулан шууд олгох журам тогтоох.

### **1.3. Хөтөлбөрийн зорилго, зорилтуудын томъёолол**

#### **1.3.1. Аялал жуулчлалын бүс**

##### ***Хархорины бүсийн аялал жуулчлалын эрх зүйн байдал***

Хархорины бүсийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн одоогийн зохицуулалт нь аялал жуулчлалын бүс, түүний үйл ажиллагааг зохицуулах боломжгүй байна.

Зөвхөн Орхоны хөндийгөөр тогтохгүй цаашид аялал жуулчлалын бүсүүдийг хөгжүүлэхэд эрхзүйн орчныг бүрдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Хүний хүчин зүйлийн нөлөөгөөр бий болж байгаа байгаль орчны доройтол, малын тоо толгойн хэт өсөлт, бэлчээр талхлалт нь аялал жуулчлалын нөөц бүхий газруудыг үнэгүйдүүлж, аялал жуулчлалын салбарын тогтвортой хөгжилд саад учруулах хэмжээнд хүрч байна. Иймээс аялал жуулчлалын бүсийг нарийвчлан тогтоож, түүнд мөрдөх дэглэмийг бий болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Зохицуулалтгүй жуулчлалын сөрөг үр дагавар болох аялал жуулчлалын байгалийн нөөцүүд талхлагдах, түүх, соёлын дурсгалууд сүйтгэгдэх хэмжээнд хүрсэн байна. Цаашид аялал жуулчлалын бүсийн эрх зүйг тодорхой болгохын зэрэгцээ бүсийн хөгжлийн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага байгуулах нь шаардлагатай.

Аялал жуулчлалын бүсийн тухай хуулийн төсөл боловсруулах, холбогдох хууль, тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг 2009 онд багтаан УИХ-д өргөн барьж батлуулах ажлыг салбар хариуцсан яам зохион байгуулах нь зүйтэй.

Мөн аялал жуулчлалын бүс дэх хот, суурингуудын хөгжлийн чиглэлийг тодорхойлж, байгаль орчинд сөрөг нөлөөгүй “Ногоон хот” дэд хөтөлбөр боловсруулах, үйлдвэрлэл үйлчилгээний стандарт тогтоох шаардлагатай байна.

##### ***Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалт***

Хархорины бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг хүлээсэн төрийн захиргааны байгууллага (Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргаа - ХАЖБЗ) байгуулах.

Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргаа нь дор дурдсан эрх үүрэг бүхий байгууллага байна.

- Хархорины бүсийн аялал жуулчлал хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлого боловсруулахад оролцох
- Аялал жуулчлалын салбар, Орхоны хөндийн бүс нутагтай холбоотой хууль тогтоомж батлагдахад санал өгөх
- Хархорины бүс нутагт аялал жуулчлал, аялал жуулчлалын суурь нөхцөл болох байгаль орчин, түүх дурсгал, биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ажилд оролцох, тэдгээрт үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг судлан шийдвэрлэх санал боловсруулж дээд шатны удирдах байгууллагад хүргэх

- Дэлхийн Өвийн болон байгаль хамгаалах чиглэлийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж байгаль, түүх, соёлын дурсгалыг хамгаалах нэгдсэн төлөвлөгөөтэй ажиллах
- Аялал жуулчлалын бүс дэх аялал жуулчлал, байгаль, түүх, соёлын дурсгалд сөрөг нөлөө үзүүлж байгаа болон сөргөөр нөлөөлж болохуйц үйл ажиллагааг таслан зогсоож холбогдох байгууллагад мэдэгдэн шийдвэрлүүлэх
- Аялал жуулчлалын бүс дэх үйл ажиллагааны дэглэмийг тогтоох, хяналт тавих

Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргаа нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу үйл ажиллагаагаа явуулах ба Хангайн бүсийн хөгжлийн концепцийг үйл ажиллагааны удирдлага болгоно. Мөн Өвөрхангай, Архангай аймгуудын аялал жуулчлал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, тус аймгуудын орон нутгийн төсөвт аялал жуулчлалын салбараас орох орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна.

Мөн аялал жуулчлалын бусад томоохон бүсүүд болох Хөвсгөлийн, Говийн бүсүүдийн аялал жуулчлалын төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, Орхоны хөндийн аялал жуулчлалтай холбох талаар санаачлагатай ажиллана.

#### Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргааны зорилго:

Хархорины бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль, түүх, соёлын дурсгалыг хадгалах хамгаалахад нэгдсэн удирдлагаар хангах, аялал жуулчлалын салбарын оролцогчдын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах

#### Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргааны үйл ажиллагааны чиг үүрэг:

- Хархорины аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байгууллагуудын стандартыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хархорины аялал жуулчлалын бүс дэх соёлын биет бус өвийг сэргээх, түүнээс олох аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх
- Хархорины аялал жуулчлалын бүс дэх аялал жуулчлалын маршрутыг тогтоож, тур оператор компаниуд болон бусад аяллын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудаар мөрдүүлэх
- Аялал жуулчлалын бүсэд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан ажиллах. Хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаа явуулах
- Бүсийн аялал жуулчлалын салбарт ажиллагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх
- Бүсийн аялал жуулчлалын мэдээллийг сайжруулах
- Жуулчдын аюулгүй байдлыг хангах, тав тухтай байдлыг дээшлүүлэх
- Түүх, соёлын өвийг хадгалах хамгаалах
- Байгаль орчныг хамгаалах

#### Зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэр

Үйл ажиллагааны хэлбэр нь байнгын болон байнгын бус гэсэн хоёр хэсгээс бүрдсэн байна.

Байнгын бус хэсгүүдтэй байх нь нэг талаас Монгол улсын засаг захиргааны нэгжийн эрх үүргийн дагуу сумын засаг дарга нь тухайн сумын нийгэм эдийн засгийн хөгжлийг хангагч байх, нөгөө талаас бүсийн асуудалд оролцох зайлшгүй шаардлагатай тул энэ уялдааг хангах давуу талтай. Нөгөөтэйгүүр хурлаас гарсан шийдвэрийг сум орон нутагтаа үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөтэй гэдэг нь ойлгомжтой.

Байнгын бус хэлбэр нь хурлын зохион байгуулалттай байх ба бүсэд харъяалагдах 6 сумдын засаг дарга нар, байгаль орчин хариуцсан ажилтнууд, аялал жуулчлал хариуцсан ажилтнуудаас бүрдэх ба улирал бүр хуралдаж холбогдох асуудлыг хэлэлцэн баталж байна. Үүнд:

- Байнгын хэсгийн ажлын гүйцэтгэл, байнгын бус хэсгийн гишүүдийн хүлээсэн үүргийн дагуу ажлуудыг дүгнэх, цаашдын ажлын төлөвлөгөөг батлах;
- Бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудын явц, аялал жуулчлалын дунд болон урт хугацааны бодлого боловсруулах;
- Бүсийн нэгж, бичил бүсүүдийн үүрэг, хамтран ажиллах чиглэлийг тодорхойлох;

Байнгын хэсэг нь Хархорины бүсийн аялал жуулчлал хариуцсан байгууллагын ерөнхий координатороор ахлуулсан ажлын баг байх ба ажлын багийг ерөнхий координатор өөрөө бүрдүүлнэ. Ерөнхий координаторыг аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага томилон ажиллуулна.

### ***Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын салбарын жолоодогч хүчний хөгжлийг хангах***

Жолоодогч хүчний хөгжлийг хангах нь салбарын масштабын өсөлтөд шууд нөлөөлөх тул анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд салбарын өсөлт юунаас шалтгаалж байгааг олж тогтоох, тухайн салбарт өөрчлөлтийг бий болгож буй тэргүүлэгч хүчнүүдийг тогтоон тэдгээрийн хөгжих нөхцлүүдийг бүрдүүлж өгөх шаардлагатай. Нэн тэргүүнд анхаарал хандуулах шаардлагатай гурван жолоодогч хүчний хөгжлийг дараах байдлаар тоймлон оруулав. Үүнд:

#### **Хүний нөөц**

##### ***Зорилго:***

Хархорины бүсийн аялал жуулчлалын бүсэд дээд зэргийн чанартай үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах ур чадвартай боловсон хүчнийг бий болгох.

##### ***Зорилтууд:***

- Хүний нөөцийн янз бүрийн түвшний мэдлэг, ур чадварыг илэрхийлэх чадавхийг хэмжих стандартыг бий болгох, сайжруулах, шинэчлэх, жилийн давтамжтайгаар шалгалт хийж байх;
- Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн боловсрол, сургалт үйлчилгээний төвийг Хархорины аялал жуулчлалын бүсэд байгуулах;
- Тогооч, үйлчлэгч, цэвэрлэгч, ресепшн, хөтөч, мужаан зэрэг мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх талаар төрөөс анхаарах;

#### **Хослох бүтээгдэхүүн**

**Зорилго:**

Монголын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэгч байгаль, түүх, соёлын нөөцийг хадгалж, зөв зохистой ашиглах;

**Зорилтууд:**

- Жуулчлалаас байгальд сөргөөр нөлөөлж байгаа байдлыг багасгах. Тэр дундаа дотоодын аялагчдын үүсгэдэг асуудал (замгүй газраар явж шинэ зам гарган хөрс эвддэг, хог хаягдал, гол ус бохирдуулдаг, хаа сайгүй түүдэг асаадаг г.м) -ыг төр, хувийн хэвшил, орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллагуудын зүгээс хамтран анхааралдаа аван зохих ажлыг гүйцэтгэх;
- Үзвэр, үзүүлбэрүүдэд зориулсан гар урлал, урлагын тоглолтыг бий болгох

**Соёлжилт, стандартчилал****Зорилго:**

Хархорины бүсэд жуулчлагчдад эрүүл хүнс, эргэн ирэхүйц үйлчилгээ бүхий аялал жуулчлалын байгууллагуудыг санал бий болгох;

**Зорилтууд:**

- Хархорины бүсийн тодорхой цэгүүдэд сүү, мах, жимс, хүнсний ногоог малчид, тариаланчдаас хүлээн авч жуулчны баазуудад түгээх эрүүл ахуйн хянан шалгах газрыг байгуулах;
- Жуулчны баазууд, зочид буудлуудын зэрэглэлийг жил бүр шалгаж байх. Зэрэглэлийн талаарх мэдээллийг жуулчдыг бүсийн хилээр орж ирэхэд дэлгэрэнгүй өгдөг болох;

**Хархорины аялал жуулчлалын бүсийн бүсчлэл, дэд бүс, тэдгээрийн дэглэм**

Барилга, Хот Байгуулалтын Яамны сайдын 2007 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолын зургийн даалгаварт хөтөлбөрийг Архангай аймгийн Хашаат, Хотонт, Өгийнуур, Өвөрхангай амгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий сумдын нутаг дэвсгэрийг хамруулах тухай тусгагдсаны дагуу боловсруулсан.

Хархорины аялал жуулчлалын бүсийн газар нутгийг Байгаль-Экологийн хамгаалалтын бүс, аялал жуулчлалын бүс гэж ангилан хилийн цэсийн саналыг гаргалаа.

**Байгаль-Экологийн хамгаалалтын бүс**

Байгаль-Экологийн хамгаалалтын бүс нь аялал жуулчлалын бүсэд орсон нутаг дэвсгэрт нөлөөлж болох хүний хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах зорилгоор хамгаалалтад авсан бүс юм. (Зураг 10)

Хархорины аялал жуулчлалын бүсийн байгаль-экологийн хамгаалалтын хилийн заагийг аялал жуулчлалын бүсэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлсны үндсэн дээр тогтоосон.

Судалгааны дүнгээс үзэхэд аялал жуулчлалын үндсэн ба туслах маршрутын дагуу хөрсний элэгдэл, цөлжилт зэрэг экологийн хүндрэлүүдээс гадна усны

хомсдол, бэлчээр талхлалт зэрэг хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой сөрөг нөлөөлөл ажиглагдаж байна.

Өөрөөр хэлбэл аялал жуулчлалын бүсийг хамгаалах нь зүйтэй боловч тус бүсэд нөлөө үзүүлж байгаа газар нутгийг мөн хамгаалах зайлшгүй шаардлага тулгараад байна. Тухайлбал Орхон голын усны түвшин багасаж байгаа нь тус голд цутгадаг гол горхины гольдролыг өөрчилснөөс болсон нь тогтоогдсон. Энэ нь газар тариалан эрхлэх, алт олборлох зэрэг үйл ажиллагаатай холбоотой.

Байгаль-экологийн хамгаалалтын бүсэд хөтөлбөрт хамрагдаж байгаа Архангай, Өвөрхангай аймгуудын зургаан сумын нутаг дэвсгэр (1307.63 мянган га) болон хөтөлбөр боловсруулсан багийн зүгээс Өвөрхангай аймгийн Уянга, Зүүнбаян улаан сум, Архангай аймгийн Цэнхэр, Түвшрүүлэх сумдын зарим нутаг дэвсгэрийг хамгаалалтын бүсэд оруулах санал дэвшүүлж байна.

*Байгаль-экологийн хамгаалалтын бүсэд хориглох зүйлс:*

- Уул уурхайн үйл ажиллагаа явуулах;
- Аж ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх;
- Батлагдсан замаас бусад газраар тээврийн үйл ажиллагаа явуулах;
- Ан агнуурын үйл ажиллагаа эрхлэх;
- Аялал жуулчлалын бүсэд жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд тавигдах нийтлэг шаардлагын дагуу хориглох зүйлс;
- Байгаль орчны нөхөн сэргээлтийг хийхдээ одоогийн тэнцвэрт байдлыг хангах;

*Байгаль-экологийн хамгаалалтын бүсийн хилийн цэс*

Ширээтийн даваанаас баруун урагшаа эргэн Ширээт нуурийн урд хөвөөг даган 15 орчим км яваад баруун хойш эргэн Хөх даваа, түүнээс Улиастайн голын зүүн эргийг даган уруудаж Судайн голын уулзварт хүрээд баруун хойш эргэн 30 орчим км яваад Тонгоргын даваа хүрч, түүнээс Тонгоргын голын эхийн хярыг даган баруун хойш явна. Цаашаа Өвөр Хөшигтийн хойд хярыг даган Хөх давааны эхний хярын зүүн бэл хүрээд зүүн хойд зүгт эргэн Өвөр Хөшигтийн хойд нурууг даган яваад Хар хустын давааг даган Суварга хайрханы баруун бэлээр хойш даван Сонгино уул хүрнэ. Тэндээс зүүн хойд зүгт Улаан чулууны талыг уруудан Шар Булууны уулыг дамнан, Гялааны уул, Гурванзан, Хамаг уул, Хүрэн асга уул, Дуут зэрэг уулуудаар дамжин хойш уруудаж Сайрын овоо хүрээд тэндээс Тамирын голын баруун эргийг барин уруудаж Цэнхэр сумын төвийг дайрна. Тэндээс Хөх овоо ороод урагшаа эргэн Бор толгой, Хар толгойгоор дамжин, Баян өндөр уул хүрнэ. Тэндээс зүүн хойд зүгт чиглэн Их Хангай уул, Шовх толгой, Будагт Шовх уул, Бэлхийн толгой хүрнэ. Мөн тэндээс Тамирын голыг хойшоо гатлан Өндөр уул хүрээд зүүн хойд зүгт чиглэн Их Сэртэн уул, Ачаат уул ба Их дуух, Цагаан толгойгоор дамнан Шар Бандийн Гозгор хүрнэ. Тэндээс зүүн урагшаа эргэж Баян дуурх уул, Ихэр уул, түүнээс зүүн урагш Нүдэн уулаар дамнан Бэрхийн холбоо уул хүрнэ. Тэндээс Их бэрхийн хөндийгөөр зүүн урагшаа уруудан Сономын худаг, Бор нуруу, Сэртэнгийн өндөр уул зэргээр дамжин Цагаан Чулуутын үзүүр хүрээд мөн зүүн урагшаа эргэж Улаан толгой хүрээд урагшаа эргэж Тарнын гол өгсөөд Бага



цагаан нуурын зүүн бие Улаан бургастын тохой хүрээд баруун зүгт эргэн Гол овоо уул хүрнэ. Тэндээс баруун урд зүгт эргэж Сондуултын хяр, Сант овоот уулаар дамнан Тасархай булаг, Цагаан хошуу дахь 3-р шон хүрнэ. Тэндээс зүүн урагшаа эргэж Аралтын ухаа овоо хүрээд баруун тийш эргэн Сүвээгийн булгаар дайран Дулааны овоо хүрээд зүүн урд зүгт Жаргалант овоо уул, Ар булгийн даваагаар дамнан Хангай Уул хүрнэ. Тэндээс зүүн урд зүгт Асгатын уул, Цэцэг мод, Шинэ давааг дамнан Хоолой Худаг хүрээд Зүүн Баян уулаар дамжин Онгийн голын хөвөө №-1 шон хүрнэ. Тэндээс Зүүнбаян Улаан сумын урдуур Онгийн голын Баруун эргийг өгсөн Онги-Цэцэнгийн голын уулзвар хүрээд Холбоо хүрэн уулаар дамнан Уянга сумын урд хамараар дайран Жаргалант уул, Ихэрийн даваа дайран, Урангийн голын Баруун эргээр өгсөн Ширээтийн даваа хүрнэ.

#### Аялал жуулчлалын бүс

Хөтөлбөрт хамрагдах дээрх 6 сумдын нийт 1307.63 мянган га газраас ойролцоогоор 800 мянга орчим га газар нь аялал жуулчлалын нөөц, дэд бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээ, экологийн тэнцвэрт байдлын хувьд нэгдмэл учир Аялал жуулчлалын бүс болгохоор санал дэвшүүлж байна. (Зураг 11)

#### Аялал жуулчлалын бүсийг тогтоох шалгуурууд

Хархорины бүсийн аялал жуулчлалын бүсийг тогтооход дараах хүчин зүйлсийг харгалзан үзсэн болно. Үүнд:

- Орхоны хөндийн бүс нутгийн аялал жуулчлалын бүсэд хөтөлбөрт тусгагдсан үзмэр, түүхийн дурсгал, байгалийн үзэсгэлэнт газар, рашаан сувиллын нөөц бүхий газар болон бусад аялал жуулчлалын нөөцийг бүрэн хамарсан байх;
- Аялал жуулчлалын бүс нь байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангасан байх. Зөвхөн аялал жуулчлалын нөхцөл нөөцийн үнэлгээнд суурилан бүсийн хил заагийг тогтоохоос гадна усны хагалбар, усны эх, ус намгархаг газар, ой модтой уул зэрэг экологийн тэнцвэрт байдлыг хангах үүднээс бүхэлд нь аялал жуулчлалын бүсэд хамруулах;
- Аялал жуулчлалын үйлчилгээ, хослох бүтээгдэхүүн үйлчилгээ, дэд бүтэцийн хувьд нэгдмэл, үндсэн маршрутын зам дайран өнгөрдөг байх;

#### Аялал жуулчлалын бүсэд хориглох зүйл

- Бүс нутагт байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл явуулах;
- Газар тариалан эрхлэх;
- Уугуул биш мал амьтан үржүүлэх;
- Тогтсон маршрутаас гадуур аялал хийх;
- Батлагдсан замаас өөр газраар тээврийн хэрэгслээр зорчих;
- Зохих зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барих;
- Малын тоо толгой нэмэгдүүлэх, бэлчээр талхлалтыг нэмэгдүүлэх
- Жуулчдын зорих газар, жуулчдыг татах нөөцөд хөтөлбөрт тусгагдсанаас бусад бүтээн байгуулалт хийх;
- Түүх соёлын үнэт өвийг зүй бусаар ашиглах;

- Байгаль орчны нөхөн сэргээлтийг одоогийн тэнцвэрт байдлыг хангах байдлаар хийх.

#### Аялал жуулчлалын бүсийн хилийн цэс

Ширээтийн даваанаас баруун тийш Ширээт нуурын урд биеэр явж, Хөхийн даваа хүрээд түүнээс зүүн хойд зүгт Цагаан Азрагын голын зүүн эргийг даган уруудаж Цагаан Азрагын Нууруудын баруун биеэр хойшоо яван Улиастайн голын баруун эргээр уруудан Орхон-Улиастайн голын уулзвараар дайран зүүн хойд зүгт Тооройн өндөр овоо, Их зэстийн нуруу, Цагаан булуу уул, Улаан нуруу, Сөдөтийн даваа, Өвтийн даваа, Бат-Өлзий уулуудаар дамнан зүүн тийш эргэж Цагаан хөндийгөөр уруудан хойшоо эргэж Овоот толгой хүрээд тэндээс хойд зүгт Төмөр хайрханыг оройлдон Улаан хадны уул хүрнэ. Тэндээс зүүн тийш Хөх сүмийн голыг уруудан Майхан толгой хүрээд тэндээс Цагаан овоо уулаар дамжин зүүн тийш Бэрх уул хүрнэ. Тэндээс зүүн хойд зүгт Хөөвөрийн бригадаар дамжин Цагаан толгой, Хөх толгой, Мухар цагаан хөтөлөөр тус тус дайран Шорвог нуурын баруун талаар Бэрх ууланд хүрнэ. Бэрх уулнаас чанх хойд зүгт Тамирын голыг хөндлөн гаталж Дөрвөлжин хэрмээр зүүн тийш эргэн Мааньт уулыг дайран Их дуут хүрнэ. Түүнээс Цагаан толгойгоор дайран зүүн тийш явж Шар баньдын шовгор хүрээд зүүн урд зүгт Баян дуурах уул хүрнэ. Тэндээс Ихэр уулаар дайран чанх урагшаа явж Жаргалант овоо, Гурван овоо, Их номт уул, Өлзийт овоо, Бага Эрээн овоо уул хүрнэ. Бага Эрээний овоо уулнаас баруун урагшаа чиглэж Бургаст овоо, Дулаан хайрхан овоо, Сант уул, Жаргалант овоо хүрнэ. Тэндээс баруун тийш эргэн Ар Булгийн даваа, Хангай уул, Цагаан суврагын даваа, Цагаан залаа уул, Өвтийн даваа, Хятрууны даваагаар дайран Хангай нуруу, Улаан нуруу, Хар хустын нурууг оройлдон баруун урд зүгт явж Ширээтийн даваа хүрнэ.

#### Аялал жуулчлалын дэд бүсүүд

Хөтөлбөрийн аялал жуулчлалын бүсийг дараах дөрвөн дэд бүсэд хуваан хөгжүүлнэ. (Зураг 12). Үүнд:

- Түүх, соёлын аялал жуулчлал зонхилсон Хархорины бичил бүс;
- Байгалийн аялал жуулчлал зонхилсон Бат-Өлзийн бичил бүс;
- Рашаан сувиллын аялал жуулчлал зонхилсон Хужиртын бичил бүс;
- Эрдэм шинжилгээ, судалгааны аялал жуулчлал зонхилсон Өгийнуурын бичил бүс.

#### Тусгай хамгаалалттай газар нутгууд

Хархорины аялал жуулчлалын бүсийн газар нутагт Дэлхийн Өв – Орхоны хөндийн соёлын дурсгалт газар (Зураг 13), Улсын болон орон нутгийн Тусгай хамгаалалттай газар нутаг (Зураг 14), Олон улсын конвенцед бүртгэгдсэн газар нутаг зэрэг дэлхийн болон улс, орон нутгийн чанартай тусгай хамгаалалт бүхий олон газар хамрагдаж байна. Эдгээр тусгай хамгаалалттай газар нутгуудад UNESCO-ийн Дэлхийн Өв-ийн шаардлага, шалгуур, "Тусгай хамгаалалттай газар нутгийн нийтлэг горим", "Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглуулах түр журам", "Орчны бүс нутгийг байгуулж ажиллуулах тухай", "Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа шинжилгээний ажил явуулах журам", "Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал явуулах журам" болон соёлын өвийг хамгаалахтай

холбоотой бусад тусгай дүрэм, журам, Олон улсын конвенцийн дагуу зохицуулсан зохих шаардлага, дэглэмүүдийг баримтална.

Дэлхийн чанартай тусгай хамгаалалттай газар нутгуудад Дэлхийн Өв – ОХСДГ, олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувуу олноор нүүдэллэн ирж амьдардаг орчныг хамгаалах тухай "Рамсерийн конвенц"-д орсон Өгий нуур багтана.

Улсын чанартай тусгай хамгаалалттай газар нутагт Хангайн нурууны байгалийн цогцолбор газар, Орхоны хөндийн байгалийн цогцолбор газар болон дурсгалт газрууд (Хөшөө Цайдамын Түрэгийн үеийн дурсгалын цогцолбор, хар балгас хотын туурь, Хархорум хотын туурь болон Эрдэнэзуу хийд, Төвхөн хийд) багтана. Мөн орон нутгийн бусад (аймгийн) ИТХ-ын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан газар нутгууд хамаарагдана. (Зураг 14, 15)

### **1.3.2. Хархорины аялал жуулчлалын бүсийн хот байгуулалтын хөгжлийн стратегийн томъёолол**

Бүсийн хот, суурин газруудыг үндэсний архитектурын өв уламжлалыг орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулсан өвөрмөц дүр төрх бүхий хот, сууринууд болгон хөгжүүлэх;

Хархорин хотыг Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах конвенцийн шаардлагыг хангах түвшинд хүргэн хөгжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

Хархорин хот болон сумын төвүүдийн гудамж, хашаа, байшинг уламжлалт монгол төрхөд ойртуулан, монгол гэрийн хөгжлийг тусган сайжруулах;

Бүсийн хот сууринуудыг зам тээвэр, дэд бүтцээр бүрэн хангах;

Олон улсын нисэх онгоцны буудлыг байгаль экологич, өв соёлыг хадгалан хамгаалах Дэлхийн Өвийн шаардлагад нийцүүлэн, зохистой байршлыг сонгон барьж байгуулах;

Бүсэд шинээр хот, суурин газруудыг төлөвлөн барьж, байгуулах тохиолдолд зөвхөн үндэсний архитектурын өв уламжлалын өвөрмөц шийдэлд түшиглэн орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан, бүс нутгийн экологийн даацад тохирсон бөгөөд байгаль орчин, өв соёлд сөрөг нөлөөгүй бичил үйлдвэрлэл бүхий хот, сууринуудыг хөгжүүлэх;

### **Хархорины аялал жуулчлалын бүс дэх хот суурингууд, тэдгээрийн хөгжлийн уялдаа**

Аялал жуулчлалын бүс дэх хөгжлийн хандлагыг тодорхойлох нь аялал жуулчлалын салбарын өсөлтөд нөлөөлөх, төв суурин газруудын хөгжлийн уялдааг хангах, бүс нутгийн оршин суугчдын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Мөн тэргүүлэх чиглэлийг боловсруулахдаа бүсийн хот, суурингуудын давуу талд тулгуурлах нь зүйтэй.

Бүсийн хот суурингуудын хамтран хөгжих, бүсийн аялал жуулчлал, байгаль орчны асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлага урган гарч байна. (Зураг 16)

Иймээс удирдлага зохион байгуулалтын хувьд нэгдсэн тогтолцоо (Орхоны хөндийн аялал жуулчлалын захиргаа, сумдын засаг дарга нараас бүрдсэн хурал)-

оор дамжуулан өөр өөрийн ашиг сонирхлыг илэрхийлэх, хамтран ажиллах, ялангуяа хот, суурингуудын хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегийг боловсруулах, үүрэг хүлээх зэрэг нь бүс нутагт аялал жуулчлалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд чухал алхам болно.

Бүсийн доторх зарим суурин, сумд аялал жуулчлалын үндсэн маршрутаас хол, үзмэр үйлчилгээ хомс, хөгжих боломж багатай байгаа тул аялал жуулчлалын дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг бусад салбарыг хөгжүүлэхэд бүсийн аялал жуулчлалын захиргаа, сумдын удирдлагуудын хамтын ажиллагаа, санаачлага ихээхэн чухал гэдгийг онцлон тэмдэглэж байна. Бүсийн сумд байгалийн болон түүх соёлын давуу талдаа тулгуурлан хөгжих нь зүйтэй боловч энэхүү эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь суурин газруудыг хохироохгүй байх, эдийн засгийн одоогийн чадамжийг бууруулахгүй байх наад захын шалгууртай байх шаардлага тавигдаж байна.

Урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход хамгийн чухал хүчин зүйл нь өнөөгийн хөрөнгө оруулалтаас илүү бодлогын шинэтгэлүүд байдгийг анхаарч, бүсийн байгаль экологи, түүх соёлын дурсгалд ээлтэй, хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн бодлого боловсруулах нь чухал юм.

#### Бат-Өлзий сум

Сумын төв Өвт сууринд 2007 оны байдлаар Өвт багийн 689 өрх, 2233 хүн оршин сууж байна.

Бат-Өлзий сум нь байгалийн үзэсгэлэнт газар олонтой, аялал жуулчлалын салбар хөгжиж байгаа нутаг юм. Гэхдээ аялал жуулчлалын салбарт тус сумын иргэд албан ёсны хөдөлмөр эрхэлж, тогтвортой ажлын байр бий болохгүй байсаар байна.

Харин жуулчдад морь, сарлаг унуулах, дайвар бүтээгдэхүүн нийлүүлэх зэргээр орлого олж байна.

Жуулчдын хамгийн их үзэхийг хүсдэг зүйл бол амьд нүүдлийн соёл. Бат-Өлзий сумын нутагт цаашид нүүдлийн соёлын өвийг хамгаалах, нүүдэллэн амьдрах боломжийг хадгалан үлдэх нь чухал юм. Бат-Өлзий сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлбол:

- Байгалийн болон соёлын аялал жуулчлал
- Эмчилгээний рашаан сувилал
- Ардын эмнэлгийн эмийн жижиг үйлдвэр
- Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй
- Сүү цагаан идээний үйлдвэр
- Жимс жимсгэнийн аж ахуй
- Гэрийн мод, модон эдлэлийн үйлдвэрлэл
- Уламжлалт мал аж ахуй

#### Хужирт сум

Сумын төв Хужирт сууринд 2007 оны байдлаар Шивээт, Шунхлай гэсэн 2 багийн нийт 689 өрхийн 2233 хүн оршин сууж байна

Орон сууцны хангамжийн хувьд нийтийн орон сууцанд 15 өрхийн 61 хүн, хувийн байшинд 30 өрхийн 129 хүн, гэрт 119 өрхийн 491 хүн, орон гэргүй 6 өрхийн 10 хүн байна.

Хужирт сум нь рашаан эмчилгээний салбараа хөгжүүлж байгаа. Энэ давуу талдаа тулгуурлан цаашид эмчилгээний аяллыг хөгжүүлэх боломжтой. Хужирт рашаан сувилал нь нэг ээлжиндээ 340 хүн хүлээн авах хүчин чадалтай.

Хужирт сумын хөгжлийн цаашдын хандлагыг эмчилгээ сувилал, байгалийн аялал жуулчлалд тулгуурлан хөгжүүлэх гэж тодорхойлж байна.

Одоогоор Хужиртын рашаан сувилалд зөвхөн дотоодын аялагчид, эмчилгээний зорилгоор очиж эмчлүүлж байгаа ч энд олон ажлын байрууд гарч орон нутгийн төсөвт багагүй орлого оруулж байна.

Цаашид Хужирт сумын төвд ойр байгалийн үзэсгэлэнт газруудад амралтын төв байгуулан рашаан, шавар эмчилгээ, сэтгэл засал зэрэг чиглэлүүдийг хослуулан хөгжүүлэх нь зүйтэй.

Мөн Хужиртын болон Хөндлөн булгийн рашаан, шаварыг хамгаалахад анхаарах зайлшгүй шаардлагатай болсон.

Мөн Хужиртын рашаан, шаварт тулгуурласан эмчилгээ сувилгааны үйлчилгээнд хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хужирт сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл нь:

- Эмчилгээний рашаан сувилал
- Байгалийн аялал жуулчлал
- Уламжлалт мал аж ахуй

#### Хашаат сум

Сумын төв Баян сууринд 2007 оны байдлаар Баян багийн 210 өрхийн 818 хүн оршин сууж байна.

Хашаат сумын төв нь байршлын хувьд аялал жуулчлалын маршрутад шууд холбогдохгүй, аялал жуулчлалын бүс тус сумын нутгийн багахан хэсгийг хамарч байгаа тул аялал жуулчлалын салбараас шууд орлого олох боломж багатай юм.

Тиймээс аялал жуулчлалын салбарын дагалдах бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Хашаат сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл нь:

- Аялал жуулчлалын дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Уламжлалт мал аж ахуй
- Усалгаатай газар тариалан
- Сүү, цөцгийн тосны үйлдвэр

#### Өгийнуур сум

Сумын төв Зэгстэй сууринд 2007 оны байдлаар Зэгстэй багийн 127 өрхийн 561 хүн оршин сууж байна.

Өгийнуур сум нь байгалийн аялал жуулчлалын томоохон төв болж байгаа тул хөгжлийн тэргүүлэх чиглэлээр сонгох бололцоотой юм.

Өгий нуурын усны түвшин жил ирэх тусам багасаж байгаа тул нуур орчмыг хамгаалахад онцгой анхаарах шаардлагатай байна. явдал юм. Хэрэв нуурт цутгадаг голууд урт хугацаанд цутгахгүй, нуур орчимд хүн малын тоо цаашид

өсвөл нуурын усны түвшин доошилж, ус сэлгэхгүйгээс нуур замагтаж хатах магадлалтай болоод байна. Өгийнуур сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл:

- Байгалийн аялал жуулчлал
- Эрдэм шинжилгээ, судалгааны аялал жуулчлал
- Уламжлалт мал аж ахуй

#### Хотонт сум

Сумын төв Хотонт сууринд 2007 оны байдлаар Хотонт багийн 313 өрхийн 1230 хүн оршин сууж байна.

Хотонт сум нь аялал жуулчлалаас гадна улсын хэмжээний автозам, Хөвсгөл-Орхоны хөндийн бүсийн аялал жуулчлалын дамжин өнгөрөх цэг гэдгээрээ бусад суурингуудаас ялгаатай юм.

Бүсийн бусад суурин газруудтай харьцуулахад сумын төвийн хувьд үйлчилгээний салбар өсөх хандлагатай байна. Цаашид дамжин өнгөрөх давуу талдаа тулгуурлан худалдаа, зочид буудал, зоогийн газар, жуулчны баазийн чиглэлд хөгжүүлэх боломжтой.

Цаашид түүх соёлын аялал жуулчлал болон эмчилгээний рашаан сувилалд тулгуурлан хөгжих боломжтой.

Хотонт сумын айраг, цагаан идээ нь хүмүүсийн танил бүтээгдэхүүн болсон нь орлогын бас нэгэн эх үүсвэр болж байгаа юм.

Хотонт сумын хөгжүүлэх тэргүүлэх чиглэл нь:

- Түүх соёл, байгалийн аялал жуулчлал
- Эмчилгээний рашаан сувилал
- Цагаан идээний үйлдвэрлэл
- Худалдаа үйлчилгээ
- Уламжлалт мал аж ахуй
- Усалгаатай газар тариалан

#### Хархорин сум

Хангайн бүсийн тулгуур төв, Хархорин сумын төв Хархорин хотод 2007 оны байдлаар Вангийн овоо, Ганган Орхон, Эрдэнэ толгой гэсэн 3 багийн нийт 2337 өрхийн 8844 хүн оршин сууж байна.

"Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г 2004 онд "Хот байгуулалт" ТӨҮГ боловсруулан Засгийн газар баталсан боловч түүнийг хэрэгжүүлэх ажил өнөөг хүртэл хийгдэж эхлээгүй байна. Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх дараагийн үе шатны зураг төсөл болох хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө одоогоор боловсруулагдаагүй байна. Хотын хэмжээнд 30 гаруй томоохон барилгатайгаас ихэнх нь 1961 - 1986 онд баригдсан. Сүүлийн жилүүдэд тухайлбал 1996 онд нэгдсэн эмнэлгийн 3 давхар, 2005 онд нэгдсэн эмнэлгийн амбулаторийн 2 давхар, 2006 онд Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор 2 давхар барилга нэмж баригдсан.

Хархорин хот нь төвлөрсөн халаалтын системтэй байсан боловч Дулааны станц (1992 онд ашиглалтанд орсон) нь 1996 оноос хойш ажиллаагүй зогссон тул одоо ашиглах боломжгүй болсон. Сумын төвийн барилгуудын дулааныг нам даралтын 18 уурын зуухаар хангаж байна. Нүүрсээ Баянтээгийн уурхайгаас авдаг.

Усан хангамжийн хувьд төвлөрсөн систем байхгүй. Ундны усны зориулалтын гүний 2 худагтай боловч нэг нь насосгүй учир одоогоор ажилладаггүй. Ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн хувьд төвлөрсөн шугам сүлжээ нь 1979 онд ашиглалтанд орсон. Зөвхөн Хорих ангийн үйлдвэр, ЦШСГазар, Нэгдсэн эмнэлэг зэргээс гарах бохир усыг насосоор шахан цэвэрлэх байгууламжинд хүргэдэг. Тунгаагуур нь лагаар дүүрч ажилгүй ажилгүй болсон тул бохир усыг насос станцаар шууд шүүх талбайд хаяж байна.

Цахилгаан хангамжийн хувьд Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ хувьцаат компаний харъяа Эрдэнэт-Хархорин салбарын Хархорины хэсэг нь 110 кв-ын 380 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110 / 35 / 10 кв-ын хүчдэлтэй 4 дэд станцтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Хархорины хэсэг нь Хангайн бүсийн Өвөрхангай, Архангай аймгууд болон Төв аймгийн зарим сумдыг эрчим хүчээр хангах үүрэгтэй ажилладаг.

Хархорин хотод Хархорум их сургууль, эрчим хүчний салбар, худалдаа үйлчилгээний 74 гаруй цэг, зочид буудал 4 зэрэг 160 гаруй аж ахуйн нэгж ажиллаж байна.

УИХ-ын 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 01-р тогтоолоор Хархорин, Эрдэнэт хотуудыг Хангайн бүсийн тулгуур төвүүд байхаар тогтоосон. Хархорин хотын хэтийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг Аялал жуулчлал, үйлдвэр, үйлчилгээ тэргүүлсэн бүсийн засаг захиргаа, нийгэм, соёл үйлчилгээний төв байхаар тодорхойлсон.

Өнөөгийн байдлаар Хархорин хотын хөгжлийн талаар олон төсөл, хөтөлбөр хийгдээд байна. Үүнд: “Хангайн бүсийн тулгуур төв Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” (2004 он), “Эртний нийслэл Хархоринг жишиг хот болгон хөгжүүлэх хөтөлбөр” (2005 он), “Нийслэлийн баримжаатай жишиг хотын экологи-хот байгуулалтын үнэлгээ” (2006 он) зэрэг Хархорин хотын хэтийн хөгжлийн чиг хандлагын талаар үзэл баримтлал, концепцууд дэвшигдэн, судалгаа шинжилгээ, төлөвлөлтийн ихээхэн ажлууд хийгдсэн байна.

Хархорин хотын эдийн засгийн суурь салбарыг аялал жуулчлал гэж томъёолох нь зүйтэй гэж үзэж байна.

Байгаль орчин, түүх дурсгал, соёлын үнэт өвийг хамгаалах зарчимтай уялдуулан хотын хөгжлийн хандлагыг урьдчилан зөв тодорхойлох, чиглүүлэх нь чухал байна. Мөн Монголын түүх, угсаатан судлал, археологи, байгаль орчны менежмент, экологи зэрэг чиглэлүүдийн эрдэм шинжилгээ, боловсролын салбарыг хөгжүүлэхэд тохиромжтой. Цаашид Монголын окуны томоохон төв болох боломж ч бий.

Аялал жуулчлалын салбарын улирлын хэлбэлзлийг бууруулах, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого баримтлах нь байнгын ажлын байрыг бий болгох боломж олгоно.

Хархорин сумын тэргүүлэх чиглэл нь:

- Аялал жуулчлал
- Соёл, шинжлэх ухаан, боловсролын үйлчилгээ
- Түүх соёл, археологийн судалгаа, музей
- Эрчимжсэн газар тариалан, уламжлалт мал аж ахуй

Хархорины аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд Дэлхийн Өв байх шаардлага болон ОХСДГ-ын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан Хархорин хотын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, түүний дагуул, хаяа тосгон, суурингуудын үндсэн чиг үүргүүдийг нарийвчлан тогтоож, тэдгээрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж эхлэх.

### **1.3.3. Хархорины аялал жуулчлалын бүсийн нийгэм, эдийн засгийг аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх ба байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах стратегийн томъёолол**

#### ***Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах***

Хархорины бүс нутагт аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөр, тухайлбал Хархорин, Эрдэнэзуу хот орчмыг аялал жуулчлалын төв хот болгон хөгжүүлэхдээ ямар ч төрлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхээс үл хамааран экотуризмын үзэл баримтлалд тулгуурлан хөгжүүлэх шаардлагатай нь дэлхийн аялал жуулчлалын орчин үеийн хандлагад хийсэн судалгаанаас дүгнэгдэж байна.

#### **Зорилго:**

Бүс нутгийн экосистемийн тогтвортой байдлыг хангаж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, Орхоны хөндийн унаган төрх байдлыг хадгалсан байх;

Аялал жуулчлалаас шалтгаалан газрыг доройтуулж болохуйц, байгаль орчинд болон соёлын дурсгалд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах;

Орон нутгийн хэрэгцээ шаардлагатай нийцүүлэх, байгаль хамгаалалтын үр ашгийг түгээн дэлгэрүүлэх үүднээс тухайн орон нутгийн захиргаа болон хүмүүстэй хамтран ажиллах үүрэг хариуцлага бүхий бизнесийг чухалчлах;

Ашиг орлогын байгалийн бүс болон хамгаалалттай бүс нутгийн хамгаалалт болон менежментэд чиглүүлэх;

Байгаль орчинд нөлөөлөх байдлыг багасгах, үнэлэх үүднээс байгаль орчны болон нийгмийн суурь судалгааны ашиглалт, мөн түүнчлэн урт хугацааны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдэд онцгой анхаарал хандуулах;

Орон нутгийн оршин суугчидтай хамтран ажилласан судлаачдын тодорхойлсоны дагуу, аялал жуулчлалын хөгжил нь нийгмийн болон хүрээлэн байгаа орчны хүлээн зөвшөөрч болохуйц өөрчлөлтийн хязгаараас хэтэрдэггүйг баталгаажуулахын тулд эрэлхийлэл хийх;

Орон нутгийн ургамал, зэрлэг онгон байгалийн дүр төрхийг хадгалан үлдээх, байгалийн болон соёлын орчинтой хорших замаар дэд бүтцийг байгаль орчинтой шүтэлцээт байдлаар хөгжүүлэхийг зорих;

Бүс нутгийн экосистемийн тогтвортой байдлыг хангаж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, Орхоны хөндийн унаган төрх байдлыг хадгалсан байх шаардлагатай. Үүний тулд агаар мандлын хамгааллын, усны нөөцийн ашиглалт, хамгааллын, газрын нөөцийн ашиглалт, хамгааллын, ойн нөөц, биологийн төрөл зүйлсийн хамгааллын, цөлжилтийн эсрэг болон гамшгаас сэргийлэх чиглэлээр дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх;



### **Нийгэм, эдийн засгийг аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх**

Орон нутгийн бизнес болон олон нийтэд тэр дундаа байгалийн болон хамгаалалттай бүс нутаг дотор хийгээд ойр зэргэлдээ амьдарч байгаа хүмүүсийн эдийн засгийн ашиг орлогийг нэмэгдүүлэхийг хичээх.

Аялал жуулчлалын бүс дэх хөгжлийн хандлагыг тодорхойлох нь аялал жуулчлалын салбарын өсөлтөд нөлөөлөх, хот суурин газруудын хөгжлийн уялдааг хангах, бүс нутгийн оршин суугчдын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Мөн тэргүүлэх чиглэлийг боловсруулахдаа бүс дэх суурингуудын давуу талд тулгуурлах нь зүйтэй.

Орхоны хөндийн бүсэд байгаль, түүх соёл, эрдэм шинжилгээ, эмчилгээний чиглэлийн жуулчлал хөгжүүлэхэд нэн тохиромжтойн зэрэгцээ бусад салбаруудад тухайлбал мал аж ахуйн салбарт шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай юм.

Малын тоо толгойн хэт өсөлт, зохицуулалтгүй аялал жуулчлал, уул уурхайн салбарын сөрөг нөлөө илэрсээр байгаа болон цаашид улам нэмэгдэж байгааг дээр дурдсан.

Тус бүс нутагт малын тоо толгой сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байгаа нь нэг талаас сайн зүйл боловч бэлчээрийн мал аж ахуйн тоог хязгаарлах зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Гэхдээ мал аж ахуй нь үндсэн орлого нь болж байгаа оршин суугчдын хувьд орлогогүй болох аюул нүүрлэх тул нутгийн оршин суугчдыг аялал жуулчлалаас олох орлогыг нэмэгдүүлэх, эрчимжүүлсэн мал аж ахуйн хэлбэрээр ажиллах гэсэн арга замуудыг сонгох нь зүйтэй.

Аялал жуулчлалын бүсэд уул уурхайн салбараас олох орлого төдийлөн их биш, нутгийн оршин суугчдад хүртээмжгүйн дээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, аялал жуулчлалын салбарын хөгжих боломжийг хааж байгаа зэрэг шалтгаанаар уул уурхайн салбарын аливаа үйл ажиллагааг таслан зогсоох хэрэгтэй.

Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд бэлчээр ашигласны төлбөрөөс чөлөөлөх, зарим татварын хөнгөлөлт үзүүлэх, Хархорины мах боловсруулах үйлдвэрт түшиглэн мал нядлах, хадгалах боломжуудаар хангах зэрэг бодлогын талаас нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийн хувьд бэлчээр ашигласны төлбөр, зарим татварыг нэмэгдүүлэх замаар сонирхлыг нь бууруулах зэрэг арга хэмжээ авч болох юм.

Бүс дэх суурингуудын салангид бодлого, хөгжлийн ерөнхий чиглэлийг тодорхойлох бие даасан хандлагаас илүүтэйгээр хамтран хөгжих, бүс дэх аялал жуулчлал, байгаль орчны асуудлыг цогцоор нь авч үзэх шаардлага урган гарч байна.

Одоогийн байгаа эдийн засгийн бүтцийг өөрчлөхөд зарим бэрхшээлүүд зайлшгүй тулгарна. Эдийн засгийн өнөөгийн бүтцэд байгаа бэлчээрийн мал аж ахуй, модны аж ахуй (хууль бус), уул уурхай, газар тариалан зэрэг салбаруудад сөрөг нөлөө үзүүлэх, тэдгээрээс олох орлого буурах, хүн амын ажил эрхлэлтийн түвшин доошлох зэрэг хандлагууд илэрч болох юм.

Иймээс удирдлага зохион байгуулалтын хувьд нэгдсэн тогтолцоо (Орхоны хөндийн аялал жуулчлалын захиргаа, сумдын засаг дарга нараас бүрдсэн хурал)-оор дамжуулан өөр өөрийн ашиг сонирхлыг илэрхийлэх хамтран ажиллах, ялангуяа суурингуудын хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегийг боловсруулах, үүрэг хүлээх зэрэг нь бүс нутагт аялал жуулчлалын салбарыг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэхэд чухал алхам болно.

Бүсийн доторх зарим суурин, сумд аялал жуулчлалын үндсэн маршрутаас хол, үзмэр үйлчилгээ хомс, хөгжих боломж багатай байгаа тул аялал жуулчлалын дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл зэрэг бусад салбарыг хөгжүүлэхэд бүсийн аялал жуулчлалын захиргаа, бус дэх сумдын удирдлагуудын хамтын ажиллагаа, санаачлага ихээхэн чухал байна. Бүсийн сумд байгалийн болон түүх соёлын давуу талдаа тулгуурлан хөгжих нь зүйтэй боловч энэхүү эдийн засгийн бүтцийн өөрчлөлт нь бүсийн хот суурин газруудыг хохироохгүй байх, эдийн засгийн одоогийн чадамжийг бууруулахгүй байх наад захын шалгууртай байх шаардлага тавигдаж байна.

Урт хугацааны тогтвортой хөгжлийг бий болгоход хамгийн чухал хүчин зүйл бол өнөөгийн хөрөнгө оруулалтаас илүү бодлогын шинэтгэлүүд байдгийг анхаарч, бүсийн байгаль экологи, түүх, соёлын дурсгалд ээлтэй, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн бодлого боловсруулах нь чухал юм.

#### **1.3.4. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн**

##### Зорилго

Одоо байгаа аялал жуулчлалын бүтээгдэхүүний чанарыг сайжруулан, олон улсын зах зээлийн шаардлагад нийцсэн шинэ төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийг бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх;

##### Зорилт

- Аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн сайжруулах;
- Түүх, соёлын дурсгалт газруудыг сэргээн засварлах, тохижуулах, байгалийн үзэсгэлэнт газруудыг нөхөн сэргээх;
- Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулах, үзмэр, үзүүлбэр бий болгох;
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын амьд тогтолцоог хөгжүүлэх;

#### **Жуулчдын зорих газар, татах чадвар бүхий нөөц**

Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын нөхцөл нөөцийн үнэлгээний дагуу тус бүс нутагт жуулчдын зорих газар ес, жуулчдыг татах чадвар бүхий нөөц 36 ширхэг байна. (Зураг 5)

Жуулчдын зорих газрын хувьд зарим тодорхой бүтээн байгуулалт, сурталчилгаа, маркетинг шаардана. Тэгвэл жуулчдыг татах чадвар бүхий нөөцийн хувьд бүтээн байгуулалт, сурталчилгаа, маркетинг, үндсэн маршрутад холбогдох, хадгалалт хамгаалалтын байгууламж зэрэг олон төрлийн ажлыг нэмж хийх хэрэгцээтэй. (Хүснэгт 5)

Жуулчдын зорих газар ба татах чадвар бүхий нөөцүүдийг хөгжүүлэх, дэлхийн стандартад нийцүүлэх үүднээс *авто зогсоол, мэдээллийн самбар,*

*мэргэжлийн тайлбарлагч, авто зам, явган хүний зам, хоноглох, амрах байр, жуулчдын хоол зэрэг үйлчилгээ, үндсэн маршрутад холбох, цахилгаан эрчим хүч, холбоо харилцаа, хамгаалалтын хашаа, тусгай байгууламж барих, маркетинг, зар сурталчилгаа, сэргээн засварлалт, нөхөн сэргээлт, тэнцвэрт байдлыг хангах, зохистой ашиглах төлөвлөгөө* гэсэн арван төрлийн бүтээн байгуулалтаас алийг нь илүү бий болгох талаар үнэлгээ хийсэн. (Хүснэгт 5, 6)

Жуулчдын зорих газрын хувьд нийт арван үзүүлэлтийн нийлбэр нь бага бол нэмэлт бүтээн байгуулалт бага шаардана гэсэн утгыг, эсрэгээрээ нийлбэр нь их гарсан бол нэмэлт бүтээн байгуулалт их хэрэгцээтэй гэсэн нэгдмэл утыг илэрхийлнэ.

Харин жуулчдыг татах чадвар бүхий нөөцийн хувьд арван үзүүлэлтийн нийлбэр бага гарна гэдэг нь нэг талаас нэмэлт бүтээн байгуулалт бага шаардах нөгөө талаас ойрын хугацаанд бүтээн байгуулалт хийж, жуулчдын зорих газар болгох, үндсэн маршрутад оруулах шаардлагагүй гэсэн хоёрдмол утгыг илэрхийлнэ. Жуулчдыг татах чадвартай нөөцийн дээрх үнэлгээний утга их (12-оос дээш өндөр утгатай) гарвал ойрын хугацаанд нэмэлт бүтээн байгуулалт хийж, богино хугацаанд үндсэн маршрутанд холбох шаардлагатай гэсэн утга санааг агуулна.

Хүснэгт 5. Жуулчдын зорих газруудад шаардлагатай бүтээн байгуулалт, хийгдэх ажлууд

№	Сум	Зорих газрууд	Шаардлагатай бүтээн байгуулалт, хийгдэх ажлууд										Нийт
			Авто зогсоол	Мэдээллийн самбар, мэргэжлийн тайлбарлагч	Авто зам, явган хүний зам,	Хоноглох, амрах байр, жуулчдын хоол зэрэг үйлчилгээ	үндсэн маршрутад холбох	Цахилгаан эрчим хүч, холбоо харилцаа	Хамгаалалтын хашаа, тусгай байгууламж барих	Маркетинг, зар сурталчилгаа	Сэргээн засварлалт, нөхөн сэргээлт	Тэнцвэрт байдлыг хангах, зохистой ашиглах төлөвлөгөө	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Хужирт	Хужиртын амралт сувиллын төв	0	0	0	2	0	0	0	1	1	2	6
2	Бат-Өлзий	Улаан цутгалан	1	1	1	0	0	1	2	1	1	1	9
3		Төвхөн хийд	2	1	2	1	0	1	2	1	1	2	13
4	Хархорин	Эрдэнэзуу хийд	0	1	0	0	0	0	1	1	1	2	6
5		Хархорум хотын туурь	1	2	2	0	0	0	2	1	2	2	12
6	Хотонт	Уйгарийн хар балгас	2	2	1	1	0	1	2	1	2	1	13
7	Өгийнуур	Өгий нуурын цогцолбор	1	1	2	0	0	1	1	1	2	2	11
8	Хашаат	Хөшөө цайдам дахь түүхийн дурсгал	0	0	0	1	0	0	0	1	0	1	3
9	Уянга	Хүйсийн найман нуур	1	1	2	2	1	1	2	1	0	2	13

**Тайлбар:** 0 - хэрэгцээгүй  
1 - хэрэгцээтэй  
2 - нэн даруй хэрэгцээтэй

Хүснэгт 6. Жуулчдын татах чадвар бүхий нөөцүүдэд шаардлагатай бүтээн байгуулалт, хийгдэх ажлууд

№	Сум	Татах чадвар бүхий нөөцүүд	Шаардлагатай бүтээн байгуулалт, хийгдэх ажлууд										Нийт
			Авто зогсоол	Мэдээллийн самбар, мэргэжлийн тайлбарлагч	Авто зам, явган хүний зам,	Хоноглох, амрах байр, жуулчдын хоол зэрэг үйлчилгээ	үндсэн маршрутад холбох	Цахилгаан эрчим хүч, холбоо харилцаа	Хамгаалалтын хашаа, тусгай байгууламж барих	Маркетинг, зар сурталчилгаа	Сэргээн засварлалт, нөхөн сэргээлт	Тэнцвэрт байдлыг хангах, зохистой ашиглах төлөвлөгөө	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Хужирт	Хүрэлийн үеийн дөрвөлжин булш	0	2	1	0	1	0	2	1	1	1	9
2		Хүрэлийн үеийн хөшөө	0	1	0	0	1	0	2	1	1	1	7
3		Хөндлөн булгийн рашаан	1	1	2	1	1	0	2	2	1	2	13
4		Хаалган дэнжийн бугат хясаа	1	2	1	0	1	0	1	1	2	1	10
5		Үүртийн тохой	2	1	2	1	0	0	2	1	2	1	12
6		Дулааны хуурай Сэрвэнгийн хүн чулуун увшхай	0	1	0	0	1	0	2	2	1	1	8
7		Цагаан залаат зуслан	0	2	1	2	2	1	0	2	0	2	12
8	Бат-Өлзий	Цагаан голын хүрхрээ	2	1	2	1	1	0	1	2	0	1	11
9		Хустын рашаан	2	1	2	1	1	0	2	1	1	2	13
10		Тэмээн чулууны хиригсүүр	1	2	1	0	2	0	2	2	1	2	13
11		Өвөр агуйтын хиргисүүр	1	2	1	0	2	0	2	2	2	2	14
12		Хойд агуйтын хиргисүүр	1	2	1	1	2	0	2	1	1	2	13
13		Могойтын рашаан	2	2	2	1	1	1	2	2	1	2	16

14		Хятруун	2	2	2	1	1	1	1	2	1	2	15
15		Алаг толгой	1	2	1	0	1	0	1	1	0	1	8
16		Хоргой хүрэм	1	1	2	1	2	0	0	2	0	1	10
17		Орхоны бага хүрхрээ	1	2	1	2	1	0	2	2	1	2	14
18	Хархорин	Мэлхий чулуу	2	2	1	0	2	0	2	1	2	1	13
19		Эрхтэн чулуу	1	2	1	0	1	0	1	1	2	1	10
20		Шанхын хийд	2	2	1	1	2	1	1	2	2	2	16
21		Бүүдэн хөшөө	0	2	1	0	1	0	2	1	1	1	9
22		Орхон-7	2	2	1	1	2	0	2	2	2	2	16
23		Хөшөөн дэнжийн дурсгал	1	2	1	0	1	0	2	2	1	2	12
24		Бага элстэйн дурсгал	1	2	1	0	1	0	2	2	1	2	12
25		Мухдагийн амны дурсгал	1	2	1	0	1	0	2	2	1	2	12
26		Гүмбийн дэнж	1	2	1	0	1	0	2	2	1	2	12
27		Ухны гацааны дурсгал	2	2	1	0	2	0	2	1	2	2	14
28		Захын булгын эртний хотын туурь	1	2	0	0	1	0	1	1	2	2	10
29		Бага эрээний хүн чулуу	1	2	1	0	1	0	2	1	1	2	11
30		Бумбатын хүн чулуу	1	2	1	0	1	0	2	1	1	2	11
31		Баянголын амны Уйгарын дурсгал	2	2	1	0	2	1	2	2	1	2	15
32		Хотонт	Сумын төвийн бичигт хад	0	2	0	0	1	0	2	2	2	2
33	Дойт толгойн ордны туурь		2	2	1	0	2	0	2	2	2	2	15
34	Цагаан сүмын рашаан		0	1	1	1	2	1	1	2	1	2	12
35	Өгийнуур	Чилингийн балгас	1	2	1	0	2	0	2	2	2	2	14
36		Улаан худаг	1	2	1	0	1	0	2	1	2	1	11

**Тайлбар:** 0 - хэрэгцээгүй  
1 - хэрэгцээтэй  
2 - нэн даруй хэрэгцээтэй

## **Үйлчилгээ**

### **Жуулчны бааз**

Хархорины аялал жуулчлалын бүсэд 2008 оны 7 дугаар сарын байдлаар үйл ажиллагаа явуулж буй 41 жуулчны бааз, нийт 497 орчим гэрээр үйлчилгээ үзүүлж байна. Гэрууд дундажаар гурван ортой бөгөөд Хархорины бүс нутагт 2008 оны байдлаар нэг өдөрт 1500 орчим жуулчин хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай байна. Хархорины бүсийн аялал жуулчлалын нөхцөл, нөөцийн судалгаанаас үзэхэд жуулчны баазуудын үйлчилгээ маш доогуур байна.

Жуулчдын тав тухыг хангахуйц ор, халуун ус, шүршүүр, хоол, үндэсний урлагын тоглолт болон бусад сонирхол татахуйц үзвэрээр үйлчлэх, тэдний хамгаалалт аюулгүй байдлыг хангахад чиглэсэн нэмэлт үйлчилгээ зэрэг нь хангалттай түвшинд хүрээгүй байна.

Үйлчилгээний ажилчдын харилцаа, биеэ авч яваа байдал, олон үндэстний жуулчдын сэтгэлзүйг ойлгох, мэдрэх тал дээр дутагдалтай. Хархорины бүс нутгийг Зүүн Азийн бүс нутгийн томоохон зорих газар болгох зорилгыг хэрэгжүүлэхэд дэлхийн хэмжээний үйлчилгээ, олон улсын стандартад нийцсэн соёл, хандлага, үнэлгээг бий болгон мөрдүүлэх хэрэгтэй. Жуулчны баазуудыг дараахь газруудад шинээр барьж байгуулах шаардлагатай буюу одоогийн байдлаар илүү эрэлт хэрэгцээ ихтэй газруудыг дурдвал:

- Хүйсийн найман нуурын хойд ба өмнө талд
- Хустын рашаан
- Хужиртын рашаан сувилал
- Цагаан залаат
- Хотонт сум, Уйгарын хар балгас
- Төвхөн хийд доод ам
- Улаанцутгалан
- Хад бригад
- Хөшөө цайдамын ойролцоо
- Цагаан Сүмийн рашаан

Жуулчны баазын зөвшөөрөл авах, байрлах газрын зөвшөөрөл зэргийг ХАЖБЗ-тай зөвшилцсөний үндсэн дээр асуудал эрхэлсэн газрууд өгдөг байх хэрэгтэй.

Жуулчны баазуудын үйлчилгээний стандарт, үйл ажиллагаа явуулахдаа мөрдөх дүрэм журам, стандартуудыг Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн байгууллага болон ХАЖБЗ-аас хамтран хэрэгжүүлэх, мөрдүүлэх үүрэг хүлээх.

### **Тайлбарлагч, танилцуулгын самбар**

Хархорины бүсэд байгуулагдах аялал жуулчлалын зорих газрууд, дайран өнгөрөх үзмэрүүд, томоохон цогцолбор газрууд, байгалийн ба түүх соёлын үнэт өвүүдийн хувьд танилцуулгын мэдээлэл, аялах маршрутын зураг болон бусад шаардлагатай мэдээлэл агуулсан самбаруудыг байгуулах.

Зарим жуулчны цогцолбор, үзмэр, зорих газар, дайран өнгөрөх газруудад үзмэрийнхээ талаар өргөн мэдээлэлтэй тайлбарлагч, хөтөч нарыг жуулчны улирлуудад тогтмол ажиллуулах. Танилцуулгын самбарыг Уйгарын хар балгас,

Гүмбийн дэнжийн хиригсүүр, Орхон-7 дурсгал, Мойлтийн амны дурсгал, Тэмээн чулууны амны хиригсүүр, Урд ба хойд агуйтын хиригсүүрүүд, Төвхөн хийд, Хархорум хотын туурь, Баянголын амны Уйгарын дурсгал, Хятруун, Могойт, Хустын рашаанууд, Үүртийн тохой, Улаан цутгалан болон бусад шаардлагатай газруудад байгуулах.

#### Холбоо харилцаа

Хархорины бүс нутагт үүрэн телефоны сүлжээг өргөжүүлэх, өндөр хурдны интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх Засгийн газар болон аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх хувийн хэвшил хамтран санаачилгатай ажиллах.

Жуулчны бааз бүр интернэтийн сүлжээнд холбогдох, Хөтөлбөрт хамрагдаж байгаа сумын төвүүд өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбогдох замаар аялагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

#### Маршрутын зам, дэд бүтэц

Хөтөлбөрийн хоёр үе шаттайгаар төлөвлөгдсөн үндсэн маршрутын дагуух замуудыг шат дараалан хатуу хучилттай зам болгох бодлого баримтална. Харин дэд буюу туслах маршрутын замыг сайжруулах, даваа гүвээг засварлах, шавар ус тогтдог хотгор газруудыг тэгшлэх ажлууд хийгдэнэ. Орхон гол ба буюу жижиг голуудын хувьд гүүр барих ажлууд хийх.

#### Хоол хүнс

Хархорины бүсийн жуулчны баазууд, аялал жуулчлалын цогцолбор газруудын хоол ундны хангалт, түүхий эдийн татах төвлөрүүлэлтийг Хотонт, Хашаат суманд тулгуурлан хийнэ.

Жуулчны баазуудын хоол амт чанарыг сайжруулж, нэр төрлийг олшруулахын тулд мах, төмс хүнсний ногоо, өндөг, гурил, сүү цагаан идээ зэрэг түүхий эдийн хангалтыг орон нутгийн иргэд аж ахуй нэгжийн боломжид тулгуурлан нийлүүлэх.

Хоол хүнс болон түүхий эд материалыг экологийн цэвэр бүтээгдэхүүний гаралтай, Монгол улсад мөрдөгдөж буй эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байхаар хийж гүйцэтгэхэд анхаарах.

Хотонт, Хашаат сумдад эрчимжсэн мал ажуй, фермерийн аж ахуй, усалгаатай газарт тариаланг хөгжүүлэх. Ялангуяа өндөр ашиг шимтэй үхэр, гахай, тахианы аж ахуй, олон төрлийн хүнсний ногоо тариаланг бүх талаар дэмжин хөгжүүлэх.

#### Жуулчдын сэтгэл ханамж

Хархорины бүсийн аялал жуулчлалыг урт хугацаанд тогтвортой өсгөх үндсэн нөхцөл нь ирсэн гийчдийг сэтгэл хангалуун буцаах явдал юм. Ингэснээр тэд дахин Монголд, Хархорины бүсэд зочлохын зэрэгцээ найз нөхөд, ах дүү, ойр дотны хүмүүстээ аман сурталчилгаа хийнэ. Энэ нь Монголд, Хархорины бүсэд аялах жуулчлах сонирхол, сэдлийг төрүүлнэ.

Жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах төрлийг ажил, бодлогыг хэрэгжүүлнэ. Үүнд:



- Жуулчдын зорих газар, цогцолборуудыг жуулчдад зориулсан үйлчилгээг чанартай, хүртээмжтэй болгох;
- Жуулчны баазууд, зочид буудал, тээвэр, хөтөч тайлбарлагч нарын үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэх;
- Нүүдлийн соёлыг дэлгэн харуулсан томоохон ивэнтүүдийг тогтмол зохион байгуулах;

### **Аялал жуулчлалын маршрут**

Хархорины аялал жуулчлалын бүсэд байгалийн аялал жуулчлал, түүх соёлын аялал жуулчлал, эмчилгээ сувилгааны аялал жуулчлал, эрдэм шинжилгээ судалгааны аялал жуулчлал гэсэн дөрвөн дагнасан аяллын маршрутыг гаргаж байна. Мөн түүх соёлын - байгалийн аялал жуулчлал, рашаан эмчилгээ - байгалийн аялал жуулчлал, түүх соёлын - эрдэм шинжилгээ судалгааны аялал жуулчлал, байгалийн - эрдэм шинжилгээний аялал жуулчлал зэрэг дөрвөн хосолсон аяллын маршрутыг гаргалаа.

Маршрутыг хөтөлбөр боловсруулах зургийн даалгаварт заагдсан цаг хугацааны үечлэлийн дагуу 2008-2018 он, 2018-2028 он (Зураг 6, 7, 8, 9) гэсэн хугацааны интервальд өргөжилт, өөрчлөлтийг хамруулсан. (Хүснэгт 7)

Маршрутыг гаргахдаа дараах хүчин зүйлсийг тооцож үзсэн. Үүнд:

- Хархорины бүсийн аялал жуулчлалын нөхцөл, нөөцөд хийсэн үнэлгээний дүн, тоон үзүүлэлт, таталцах чадвар ба татах чадварын үнэлгээ дүн, тоон үзүүлэлтүүд;
- Дэлхийн жуулчдын сонгож буй нийтлэг маршрутуудын дундаж хугацаа, нэг өдөрт туулж буй зай, нэг маршрутын хүрээнд үзэх буюу дайран өнгөрөх үзмэрийн тоо, маршрутын туулж буй дундаж зай, нэг үзмэр дээр өнгөрүүлж буй хугацаа зэрэг үзүүлэлт;
- Дагнасан маршрутыг сонгож буй үед жуулчдын бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагууд болон хосолсон буюу холимог маршрутыг сонгож буй аялагчдын хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлагуудыг тус бүрд нь үнэлэх замаар маршрутад хамрагдах бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд чанарын стандартыг тогтоох;
- Одоогийн дэд бүтэц, аялал жуулчлалын дайвар бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, жуулчны баазуудын байршил, хүчин чадал, жуулчны компаниудын санал болгож маршрутууд зэрэг хүчин зүйлс;

## Хүснэгт 7. Хархорины аялал жуулчлалын бүсийн аялал жуулчлалын маршрутын ерөнхий байдал

Хугацаа 2008-2018									
Төрөл	Дагнасан аяллын маршрут	Хосолсон аяллын маршрут							
Ангилал	Үндсэн маршрут	Үндсэн маршрут							
Чиглэл	Байгаль	Түүх, соёл	Рашаан сувилал	Эрдэм шинжилгээ	Байгаль-Түүх, соёл	Рашаан сувилал-Байгаль	Түүх, соёл-Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ-Байгаль	
Хамрах бүс	Бат-Өлзийн бичил бүс	Хархорины бичил бүс	Хужиртын бичил бүс	Өгийнуурын бичил бүс	Бат-Өлзий ба Хархорины бичил бүсүүд	Хужирт ба Бат-Өлзийн бичил бүсүүд	Хархорин ба Өгийнуурын бичил бүсүүд	Өгийнуур ба Бат-Өлзийн бичил бүсүүд	
Үзмэр		<u>Маршрут-1:</u>	<u>Маршрут-1:</u>	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Өгий нуур 4. Эрдэнэзуу 5. Улаанбаатар	1. Улаанбаатар 2. Элсэн тасархай 3. Эрдэнэзуу 4. Мэлхийн толгой 5. Шанхын баруун хүрээ хийд 6. Шунхлай уул, дөрвөлжин булш 7. Хаалган дэнжийн бугат хясаа 8. Үүртийн тохой бугат хясаа 9. Тэмээн чулууны амны хиригсүүр 10. Урд агуйтын хиригсүүр 11. Улаан цутгалан 12. Ар агуйтын	1. Улаанбаатар 2. Элсэн тасархай 3. Эрдэнэзуу 4. Мэлхийн толгой 5. Шанхын баруун хүрээ хийд 6. Шунхлай уул, дөрвөлжин булш 7. Хаалган дэнжийн бугат хясаа 8. Үүртийн тохой чулууны амны хиригсүүр 9. Тэмээн чулууны амны хиригсүүр 10. Урд агуйтын хиригсүүр	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Хужиртын рашаан сувилал 4. Хаалган дэнж 5. Үүртийн тохой 6. Хустын рашаан 7. Могойтын рашаан 8. Хангайн овоо цутгалан 9. Улаан найман нуур 10. Хятрууны рашаан 11. Хоргой хүрэм 12. Хүйсийн 13. Төвхөн хийд 14. Эрдэнэзуу	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Орхон-7 дурсгал 4. Мойлтын амны дурсгал 5. Баянголын амны Уйгарын дурсгал 6. Уйгарын хар балгас 7. Дойт толгойн ордны туурь 8. Өгий нуурын цогцолбор 9. Улаан худаг 10. Хөшөө цайдамын цогцолбор 11. Эрдэнэзуу	1. Улаанбаатар 2. Элсэн тасархай 3. Эрдэнэзуу 4. Орхоны хөндий 5. Өгийнуур 6. Хөгшин орхон гол 7. Эрдэнэзуу 8. Батхан, Хөгнөхан уулс 9. Улаанбаатар

найман нуур	дурсгал	4. Эрдэнэзуу	11. Хангайн	15. Батхаан,	12. Улаанбаатар
15. Төвхөн хийд	13. Төвхөн хийд	5. Улаанбаатар	цагаан овоо	Хөгнөхан	
16. Эрдэнэзуу	14. Майхан		12. Улаан	уулс	
17. Хөгнөхан,	толгойн	<u>Маршрут-4:</u>	цутгалан	16. Улаанбаатар	
Батхаан уулс	дурсгал	1. Улаанбаатар	13. Хоргой хүрэм		
18. Улаанбаатар	15. Гүмбийн дэнж	2. Эрдэнэзуу	14. Хүйсийн		
	дээрх дурсгал	3. Хятрууны	найман нуур		
	16. Орхон-7	рашаан	15. Төвхөн хийд		
	дурсгал	4. Эрдэнэзуу	16. Майхан		
	17. Эрдэнэзуу	5. Улаанбаатар	толгойн		
	18. Улаанбаатар		дурсгал		
		<u>Маршрут-5:</u>	17. Гүмбийн дэнж		
<u>Маршрут-2:</u>		1. Улаанбаатар	дээрх дурсгал		
1. Улаанбаатар		2. Эрдэнэзуу	18. Орхон-7		
2. Эрдэнэзуу		3. Цагаан сүм	дурсгал		
3. Орхон-7		рашаан	19. Эрдэнэзуу		
4. Мойлтын амны		4. Эрдэнэзуу	20. Батхан,		
дурсгал		5. Улаанбаатар	Хөгнөхан		
5. Баянголын			уулууд		
амны Уйгарын			21. Улаанбаатар		
дурсгал					
6. Уйгарын Хар					
балгас					
7. Дойт толгой					
ордны туурь					
8. Чилингийн					
балгас					
9. Өгийнуур					
10. Улаанхудаг					
11. Хөшөө цайдам					
цогцолбор					
12. Эрдэнэзуу					
13. Улаанбаатар					

Хугацаа 2018-2028								
Төрөл	Дагнасан аяллын маршрут	Хосолсон аяллын маршрут						
Ангилал	Үндсэн маршрут	Үндсэн маршрут						
Чиглэл	Байгаль	Түүх, соёл	Рашаан сувилал	Эрдэм шинжилгээ	Байгаль-Түүх, соёл	Рашаан сувилал-Байгаль	Түүх, соёл-Эрдэм шинжилгээ	Эрдэм шинжилгээ-Байгаль
Хамрах бүс	Бат-Өлзийн бичил бүс	Хархорины бичил бүс	Хужиртын бичил бүс	Өгийнуурын бичил бүс	Бат-Өлзий ба Хархорины бичил бүсүүд	Хужирт ба Бат-Өлзийн бичил бүсүүд	Хархорин ба Өгийнуурын бичил бүсүүд	Өгийнуур ба Бат-Өлзийн бичил бүсүүд
<b>Үзмэр</b>	1. Улаанбаатар 2. Элсэн тасархай 3. Эрдэнэзуу 4. Шунхлай уул 5. Орхоны хөндий 6. Цагаан голын хүрхрээ 7. Хаалган дэнж 8. Үүртийн тохой 9. Хустын рашаан 10. Хангай овоо 11. Орхоны хүрхрээ 12. Хоргой хүрэм 13. Хятрууны ам 14. Хүйсийн найман нуур 15. Төвхөн хийд 16. Цагаан сүмийн рашаан 17. Хотонт сум, Хотонт хайрхан	<u>Маршрут-1:</u> 1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Мэлхий толгой 4. Уханы гацаа 5. Эрхтэн чулуу 6. Захын булгийн ордны туурь 7. Шанхны баруун хүрээ хийд 8. Бумбатын хүн чулуу 9. Бага эрээний хүч чулуу 10. Хуурай сэргэнгийн дурсгал 11. Шунхлай уулын булш 12. Хаалган дэнж бугат хясаа	<u>Маршрут-1:</u> 1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Хужиртын рашаан сувилал 4. Эрдэнэзуу 5. Улаанбаатар  <u>Маршрут-2:</u> 1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Хустын рашаан 4. Эрдэнэзуу 5. Улаанбаатар  <u>Маршрут-3:</u> 1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Могойтын рашаан 4. Эрдэнэзуу 5. Улаанбаатар	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Өгий нуур 4. Эрдэнэзуу 5. Улаанбаатар	1. Улаанбаатар 2. Элсэн тасархай 3. Эрдэнэзуу 4. Мэлхийн толгой 5. Шанхын баруун хүрээ хийд 6. Шунхлай уул, дөрвөлжин булш 7. Хаалган дэнжийн бугат хясаа 8. Үүртийн тохой 9. Тэмээн чулууны амны хиригсүүр 10. Урд агуйтын хиригсүүр 11. Хангайн	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Хужиртын рашаан сувилал 4. Хаалган дэнж 5. Үүртийн тохой 6. Хустын рашаан 7. Могойтын рашаан 8. Хангайн овоо 9. Улаан цутгалан 10. Хятрууны рашаан 11. Хоргой хүрэм 12. Хүйсийн найман нуур 13. Төвхөн хийд 14. Өндөрсант уул 15. Хотонт сумын	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Орхон-7 дурсгал 4. Мойлтын амны дурсгал 5. Баянголын амны Уйгарын дурсгал 6. Уйгарын хар балгас 7. Дойт толгойн ордны туурь 8. Өгий нуурын цогцолбор 9. Улаан худаг 10. Хөшөө цайдмын цогцолбор 11. Эрдэнэзуу 12. Улаанбаатар	1. Улаанбаатар 2. Эрдэнэзуу 3. Шунхлай уул 4. Хаалган дэнж 5. Үүртийн тохой 6. Хангайн овоо 7. Улаан цутгалан 8. Хоргой хүрэм 9. Хүйсийн найман нуур 10. Төвхөн хийд 11. Өндөрсант уул 12. Хотонт сумын төв 13. Дойт толгойн ордны туурь 14. Өгий нуур 15. Эрдэнэзуу 16. Батхан, Хөгнөхан уулс 17. Улаанбаатар

18. Дойт толгой	13. Үүртийн тохой		цагаан овоо	төв
19. Өгийнуур	14. Тэмээн	<u>Маршрут-4:</u>	12. Улаан	16. Дойт толгойн
20. Хөшөө цайдам	чулууны амны	1. Улаанбаатар	цутгалан	ордны туурь
21. Эрдэнэзуу	хиригсүүр	2. Эрдэнэзуу	13. Хоргой хүрэм	17. Өгий нуур
22. Хөгнөхан, Батхаан уулс	15. Урд агуйтын хиригсүүр	3. Хятрууны рашаан	14. Хүйсийн найман нуур	18. Эрдэнэзуу
23. Улаанбаатар	16. Улаан цутгалан	4. Эрдэнэзуу	15. Төвхөн хийд	19. Батхан, Хөгнөхан уулс
	17. Орхоны эхийн хүн чулуу	5. Улаанбаатар	16. Хотонт сумын төвийн	20. Улаанбаатар
	18. Ар агуйтын дурсгал	<u>Маршрут-5:</u>	дурсгал	
	19. Төвхөн хийд	1. Улаанбаатар	17. Уйгарын хар балгас	
	20. Майхан толгойн дурсгал	2. Эрдэнэзуу	18. Дойт толгойн ордны туурь	
	21. Мухдагийн амны дурсгал	3. Цагаан сүм рашаан	19. Чилингийн балгас	
	22. Гүмбийн дэнж дээрх дурсгал	4. Эрдэнэзуу	20. Өгий нуур	
	23. Орхон-7 дурсгал	5. Улаанбаатар	21. Улаанхудаг	
	24. Эрдэнэзуу		22. Хөшөө цайдам цогцолбор	
	25. Улаанбаатар		23. Эрдэнэзуу	
	<u>Маршрут-2:</u>		24. Батхан, Хөгнөхан уулс	
	Өмнөх үеийн маршрутыг мөрдөх		25. Улаанбаатар	
	<u>Маршрут-3:</u>			
	1. Улаанбаатар			
	2. Эрдэнэзуу			
	3. Мэлхий толгой			
	4. Уханы гацаа			
	5. Эрхтэн чулуу			
	6. Шанхын			

- баруун хүрээ  
хийд
7. Шунхлай  
уулын булш
  8. Хаалган дэнж  
бугат хясаа
  9. Үүртийн тохой
  10. Тэмээн  
чулууны амны  
хиригсүүр
  11. Урд агуйтын  
хиригсүүр
  12. Улаан  
цутгалан
  13. Ар агуйтын  
дурсгал
  14. Төвхөн хийд
  15. Хотонт сумын  
төвийн дурсгал
  16. Уйгарын хар  
балгас.
  17. Дойтын  
толгойн ордны  
туурь
  18. Чилингийн  
балгас
  19. Улаан худаг
  20. Хөшөө  
цайдамын  
цогцолбор
  21. Эрдэнэзуу
  22. Улаанбаатар

### **1.3.5. Аялал жуулчлалын бүсийн байгаль хамгаалал**

Хархорины аялал жуулчлалын бүсэд хийсэн судалгаагаар тухайн бүс нутгийн хөрсний хэв шинж өөрчлөгдөж буй шалтгаан, нөхцөл, ирээдүйд гарч болох элсний нүүдэл, цөлжилт, тоосжилтийн сөрөг үр дагаваруудыг тооцоолон хот байгуулалт, экологийн даацын үнэлгээнд үндэслэн дүгнэлт гаргахад Хархорин хотыг нэг зуун хорин мянгаас илүүгүй хүн амтай хот байх нь илүү тохиромжтой гэж үзэж байна. Хэт олон хүн амтай, төвлөрсөн хот байх нь одоогийн эмзэг экосистемийн хувьд сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөртэй гэсэн дүгнэлтийг хийж байна.

Манай түүхч, эрдэмтдийн олон жилийн уйгагүй хөдөлмөрийн үр дүнд Дэлхийн оюуны байгууллага UNESCO нь Орхоны хөндийн түүхийн хөшөө дурсгал, байгалийн үзэсгэлэнт газрууд болон эртний Хархорум хотын туурийг оруулсан өргөн уудам газар нутгийг Дэлхийн соёлын Өвд бүртгэн авч Дэлхийн Өвийн хорооны 2004 оны 7 дугаар сарын 1-ний өдөр БНХАУ-ын Сүжоу хотноо болсон хуралдааны шийдвэрээр баталгаажуулснаар Хархорины аялал жуулчлалын бүсийн ирээдүйн хөгжилд шинэ шаардлага тавьсан юм.

#### ***Байгаль орчинд халгүй хөгжил***

Хархорин хотыг хөгжүүлэх болон шинээр жишиг хот байгуулахдаа байгаль орчин-экологийн тэнцвэрт байдалд гарах сөрөг нөлөөллүүдийг тооцон үзэж шийдвэрлэх арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

Тус аялал жуулчлалын бүс нутгийн газарзүйн байрлал, газар тариалангийн зориулалтаар их хэмжээний газрыг боловсруулалтанд оруулж байсан нь цөлжилт, хөрсний элэгдэлд хүчтэй нэрвэгдэх маш эмзэг байдлыг бий болгож байгаа бөгөөд түүнээс урьдчилан сэргийлэх, ногоон зурвас, хаалт байгуулах, ойжуулах ажлыг өргөн хүрээнд явуулах шаардлагатай юм.

Хархоринг жишиг хот болгон хөгжүүлэх үйл явц, дэд бүтэц, барилга байгууламжуудыг байгуулах, хүн амын төвлөрлөөс байгаль орчин-экологийн тэнцвэрт байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг дараах байдлаар урьдчилан тооцоолж байна. Үүнд: Агаарын бохирдол, тоосжилт бий болох, ургамал, амьтны аймгийн зүйлийн бүрдлийн тоо, толгой цөөрөх, цөлжилт, хөрсний элэгдэл, эвдрэл эрчимжих, гадаргын болон газрын доорхи усны нөөцийн хомсдол, бохирдол үүсэх, жижиг гол, горхи, булаг, шанд ширгэж хатах, ойн нөөцийн зохисгүй ашиглалт, хомсдол бий болох, бэлчээрийн даац хэтэрч талхлагдах, хатуу болон шингэн хог хаягдлаас орчны бохирдол үүсэх, түймэр, үер, шороон шуурга зэрэг байгалийн гамшгийн давтамж, хор хөнөөл нэмэгдэх зэрэг болно.

Байгаль-экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж болзошгүй дээр дурьдсан сөрөг нөлөөллүүд бий болох магадлалтай ч түүнээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, байгальд халгүй техник, технологийг ашиглах замаар экологийн цэвэр, жишиг хот байгуулах бололцоотой гэж үзэж байна.

#### ***Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүдийн томъёолол***

- Хархорин хот орчмын эко бүс нутгийн байгаль орчин-экологийн даацын үнэлгээг хийж, экосистемийн онцлог байдалд тохирсон менежментийн

- төлөвлөгөөг хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;
- Бүс нутгийн ургамал, амьтны аймгийн динамик судалгааг хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөх;
  - Хотжилт, дэд бүтцийн хөгжил, хүн амын төвлөрлөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийж, болзошгүй сөрөг нөлөөлөл, урьдчилан сэргийлэх, хамгаалах арга замыг тодорхойлох;
  - Сэргээгдэх эрчим хүчний (нар, салхи, ус) эх үүсвэрийг ашиглахын зэрэгцээ бүх төрлийн сууцны халаалтанд цахилгаан болон шингэрүүлсэн хийн хэрэглээг нэмэгдүүлэх;
  - Гадаргын болон газрын доорхи усны нөөцийн судалгаа хийж, ашиглалтын горимыг тогтоох;
  - Бүсийн хот суурингийн хэмжээнд гадаргуугийн болон гүний усны нөөцийг тогтоох, хүн амыг стандартад нийцсэн унд ахуйн усаар найдвартай хангах;
  - Бүсийн нутаг дэвсгэрийн эмчилгээний зориулалттай рашаан усны хамгаалалтыг сайжруулах, үйл ажиллагааг зохистой зохион байгуулах;
  - Бүсийн голуудын сав газруудад байрлах жуулчны бааз, отгуудыг зэрэглэлд оруулах, ариун цэвэр халдвар аюулгүй ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах;
  - Орчин үеийн байгальд халгүй техник, технологи, ноу хау-г судалж, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх;
  - Экологийн хяналтын нэгдсэн лабораторийг байгуулах;
  - Байгальд халгүй техник, технологийн дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, урамшууллын механизмыг бүрдүүлэх;
  - Хархорин хот орчмын экосистемд нийцсэн байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах шинэ концепци боловсруулах;
  - Газрын менежментийг хөгжүүлж, газрын өмчлөл, эзэмшилт, ашиглалтын хилийг тогтоож, эрхийг баталгаажуулах;
  - Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх, түүх соёлын дурсгалт газрыг улсын хамгаалалтанд авах;
  - Төв суурин газруудын хөрсний бохирдлын хэмжээ зэрэглэлийг тогтоож, хөрс хамгаалах зохистой аргуудыг хэрэгжүүлэх;
  - Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах;
  - Атаршсан ба орхигдсон хөдөө аж ахуйн эдэлбэр газруудад нөхөн сэргээлт хийх;
  - Хархорин хотын ногоон бүсийн ойн санг дэс дараатайгаар нэмэгдүүлэх ажлыг гүйцэтгэж, одоогийн байгаа хэмжээг 5 дахин нэмэгдүүлэх;
  - Хархорин хотод Монгол оронд ургадаг бүх төрлийн мод, сөөгийг тарималжуулж модлог ургамлын цэцэрлэг (дендрари) байгуулах;
  - Цөлжилт, хөрсний элэгдэл илэрч буй газруудад ойн зурвас, ногоон хаалт байгуулах ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж, цөлжилтийг хязгаарлах арга хэмжээ авах;



- Ойг нөхөн сэргээх, үр бэлтгэх, тарьц ургуулах талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал санаачилга, хөрөнгө оруулалтыг дэмжиж, тэдний хүч оролцоог нэмэгдүүлэх;
- Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, түймрийн халз зурвас гаргах, сэргээх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах;
- Байгаль хамгаалагчдын тоог нэмэгдүүлэх, хариуцах газрын (талбайн) хэмжээг багасгах, шаардлагатай машин тоног төхөөрөмжөөр хангах;
- Ойжуулалт, хот цэцэрлэгжүүлэлтэд шаардлагатай тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газруудыг олноор байгуулахыг дэмжих;
- Орхон голын эхийн ойг нөхөн сэргээх;
- Биологийн төрөл зүйлийн тархалт, нөөцийг тогтоох, ховордсон биологийн төрөл зүйлийн тархац, нутгийг хамгаалах;
- Элсний нүүлтэнд өртөгдөх хандлага гарч буй суурин газруудад бутлаг ургамал (харгана, бударгана) тарьж хөрсийг бэхжүүлэх;
- Онцгой байдлын мэдээлэл холбооны техник технологийг шинэчлэн, гамшгийн холбоо, зарлан мэдээлэл, дохиоллын системийг боловсронгуй болгох;
- Сумын төвүүдэд гал унтраах анги салбарыг бий болгох, ой хээрийн түймрийн үед ажиллах нөхцөлийг хангах;
- Төв суурин газрын үерийн байгууламжийн ашиглалтыг сайжруулах, түүнийг хариуцах байгууллагыг мэргэжлийн инженер техникийн ажилтан, техник тоног төхөөрөмжөөр хангах;
- Гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах, гарсан үед ажиллах багийн үйл ажиллагаа явуулах бэлэн байдлыг хангах;

#### **1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийтлэг арга, хэрэгсэл**

Хөтөлбөрийн оновчтой удирдлага, зохион байгуулалтыг бий болгох, хөтөлбөрийг хэрэгжүүлэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх, хөрөнгө санхүүгийн шаардагдах эх үүсвэрийг олж, оновчтой ашиглах, олон нийтийн оролцоог хангах нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх үндсэн нөхцөл мөн.

##### **1.4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиглэл**

- Хангайн Бүсийн Зөвлөл, ОХСДГ-ын менежментийн захиргаа, ОХБЦГ-ын болон ХНБЦГ-ын хамгаалалтын захиргаа, аймаг сумдын ИТХ, Засаг даргын тамгын газруудын үйл ажиллагааг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;
- Засгийн газрын түвшинд холбогдох яамд, агентлагуудын энэ талын хамтын ажиллагааг оновчтой уялдуулан зохицуулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар бүсийн зөвлөл, аймгуудын ЗДТГ, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжих оновчтой арга хэрэгсэл, механизмыг бий болгох;
- Жил жилийн улсын төсөв, дунд хугацааны төлөвлөлтийн бусад баримт бичгүүд, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийн салбар бүрээр боловсруулан хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг аялал жуулчлалын энэхүү

хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдуулах;

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр харьцангуй богино хугацааны төрөлжсөн хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;
- Дээд, дунд, доод шатны төлөвлөлтийн нэгжүүдийн үйл ажиллагааг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр оновчтой уялдуулах;
- Хувийн хэвшил дэх төлөвлөлтийг энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэх зорилгоор эдийн засаг, эрх зүйн оновчтой механизм, хөшүүргүүдийг бий болгох;
- Үндэсний болон аймаг орон нутгийн статистикийн бүх түвшний үзүүлэлт, бүртгэл, мэдээллийг хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт - шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөхөд тохиромжтой байх чиглэлээр боловсронгуй болгох;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг улс төрийн намууд УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байх;
- Хөтөлбөрт дэвшүүлсэн тэргүүлэх зорилтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, давуу талуудаа бататган, сул талуудаа саармагжуулан, алдаа дутагдлаа засч байх;
- Дэлхий өв – Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын менежментийн төлөвлөгөөтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нягт уялдуулах;

#### **1.4.2. Эдийн засгийн өсөлтийг хангах үндсэн арга, хэрэгсэл**

- Эдийн засгийн хөшүүргүүдийг хэрэглэн дэлхийн жишигт хүрсэн аялал жуулчлалын үйлдвэрлэлийг дэмжих;
- Аялал жуулчлал өндөр хөгжсөн болон түргэн хурдацтай хөгжиж байгаа орнуудын энэ талын туршлагыг бүтээлчээр хэрэглэх;
- Хүн ардынхаа оюуны чадавхи, аялал жуулчлалын нөөцөд тулгуурлан хөгжих бодлогыг тууштай баримталж, аялал жуулчлалын боловсрол олгох салбарт тэргүүлэх ач холбогдол өгч, өндөр хөгжилтэй орнуудад болон дотоодын шаардлага хангасан их дээд сургуулиудад мэргэжлийн боловсон хүчин, мэргэжилтэй ажилчдыг олноор бэлтгэх;
- Аялал жуулчлалын эдийн засгийн өсөлтийг аялал жуулчлалыг дэмжих үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлтөөр хангах чиглэл баримтлах;
- Аялал жуулчлалын тэргүүний технологийг нутагшуулахыг бүх талаар дэмжих;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;

#### **1.4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр**

- Дотоодын банк, санхүүгийн эх үүсвэрийг бүрэн ашиглах;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих;
- Дотоодын хөрөнгө оруулалтыг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ашиглах оновчтой арга механизм, хөшүүргийг бий болгох;
- Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх;

- Хувийн хэвшил, Засгийн газар, орон нутгийн оролцоотой хамтарсан томоохон төслүүдийг хэрэгжүүлэх;
- Гадаадын улс орон, олон улсын байгууллагаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авах;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлж, хамтарсан судалгааны экспедиц, төслүүдийг зохион байгуулах, дэлхийн жишигт хүрсэн жуулчны бааз, амралт сувиллын газруудыг байгуулан ажиллуулах;

#### **1.4.4. Олон нийтийн оролцоо**

- Шийдвэр гаргах бүх түвшинд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг сайжруулах;
- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, иргэд, малчид, тариаланчдыг өөрсөдтэй нь холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд өргөнөөр оролцуулж тэдгээрийн эрх ашгийг тууштай хамгаалах;
- Бүс нутгийн хүн амын 50 гаруй хувийг эзэлдэг эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхи, хөгжилд оролцох хүсэл эрмэлзлийг идэвхтэй дэмжих;
- Бүс нутгийнхаа тулгамдсан асуудал, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд залуучуудыг өргөн оролцуулах оновчтой хөшүүрэг бий болгох;
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлаар бодлого боловсруулах, шийдвэр гаргахад бизнес эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Төрийн бус байгууллагуудын гүйцэтгэж чадах олон чиг үүргийг тэдэнд шилжүүлэх замаар захиргааны орон тоо, төсөв зардлыг бууруулж, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагуудын, түншлэл хамтын ажиллагааг өргөтгөх зэрэг болно.

## **ХОЁР. ХАРХОРИН, ЭРДЭНЭЗУУ ОРЧМЫГ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ОРЧИН ҮЕИЙН АРГАЧЛАЛААР ЖУУЛЧДЫН ТӨВ ХОТ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР**

### **2.1. Хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл**

2006 онд боловсруулсан Монгол Улсын аялал жуулчлалын салбарын мастер төлөвлөгөөнд аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх салбар болгон авч үзэн, аялал жуулчлалын салбарын зорилго зорилтуудыг шинэчлэн боловсруулсан нь аялал жуулчлалыг хөгжүүлэх асуудалд төрөөс хандах хандлагыг өөрчилж илүү далайцтай үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангаж байна.

Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан "Үндэсний хөгжлийн цогц бодлого"-д аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгоно гэж заасан. Үүнийг хэрэгжүүлэхээр жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах, аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлж, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлснээр үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэж сайжруулах зорилтуудыг тавьсан.

Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан, бүсийн аялал жуулчлалын хөгжлийг хоёр үе шаттайгаар боловсруулж, нэгдүгээр шатанд "Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах замаар бүсийн аялал жуулчлалын сүлжээ байгуулж, стандартыг дээшлүүлэн олон улсын сүлжээнд холбоно", хоёрдугаар шатанд "Аялал жуулчлалын салбарын бүсийн эдийн засагт эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар, менежментийг олон улсын стандартад хүргэнэ" гэсэн тэргүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна

Монгол улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд Хархорин хотыг Хангайн бүсийн тулгуур төв болгон хөгжүүлэхээр заасан. 2004 онд батлагдсан Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд хот доторхи болон хот орчмын аялал жуулчлалын талаар тусгагдсан.

Тус бүс нутаг дахь Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар нь 2004 онд Дэлхийн Өвд бүртгэгдсэнээр уг газар нь хүн төрөлхтний тусын тулд хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх нэр хүндтэй үүргийг Монгол улс олон улсын өмнө хүлээх болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.14-т "Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөр, хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна" гэж заасан.

### **2.2. Хөтөлбөрийн үндэслэл**

Монгол улсын аялал жуулчлалын салбарын нэг томоохон зорих газар нь Хархорин Эрдэнэзуу байсаар ирсэн билээ. Гэвч одоогийн байдлаараа аялал

жуулчлалын салбарт хувь нэмэр оруулах нь бага байна. Учир нь Хархорум хотын туурь, Эрдэнэзуу хийдийн өнөөгийн байдал нь жуулчдын зорин ирж, үзэхийг хүссэн хүлээлтэнд хүрдэггүй, сэтгэл ханамжгүй буцаж байгааг сүүлийн үеийн судалгаануудаас харж болно. Тус бүсийн аялал жуулчлалын нөөцийн ашиглалтын байдал хангалтгүй байхын зэрэгцээ, жинхэнэ аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болж чадаагүй, нэг нөөц дээр хэт төвлөрсөн байдалтай байгаа нь аялал жуулчлалын салбар тогтвортой, үр ашигтай хөгжихөд саад учруулсаар байна. Гэвч энэхүү хөтөлбөрт хамрагдаж байгаа Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өгийннуур сумдын хувьд аялал жуулчлал хөгжих боломж нь Монгол орны бусад бүс нутгуудтай харьцуулахад илүү байна гэж дүгнэж болох юм. Учир нь байгалийн үзэсгэлэнт газар, нүүдэлчдийн түүх, соёлын өв нэгэн дор байгаагийн зэрэгцээ, бага зайд аялал жуулчлалын бүтээгдэхүүн болон жуулчдын сонирхлын татах газрууд олон байгаа нь тус бүс нутгийг дотоодын өрсөлдөх чадварын өрсөлдөөнд давуутай нөхцөл үүсгэж байна.

Хархорин орчмын бүс нутагт UNESCO-ийн Дэлхийн Өвд бүртгэсэн Орхоны хөндийн соёлын дурсгалт газар, Хангайн нурууны байгалийн цогцолбор газар зэрэг олон төрлийн тусгай хамгаалалттай газрууд давхцан оршдог. Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын үнэт зүйлсийг цогцолбороор нь багтааж байгаа энэ бүс нутагт нандин өвөө хадгалж хамгаалахын зэрэгцээ аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн түвшинд байлгах онцгой шаардлага тавигдаж байгаад энэ хөтөлбөрийн гол агуулга чиглэгдэж байна.

Мөн Монгол улсын аялал жуулчлалын “Босоо тэнхлэг” буюу Өмнөговь, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл гэсэн говь, хээр тал, Хангайн байгалийн бүсүүдийг дэд бүтэцтэй холбож чадвал аялал жуулчлал жинхэнэ утгаараа хөгжих бүрэн бололцоотой юм.

Орхон гол, Улаан цутгалан, Өгий нуур, Хужиртын халуун рашаан, Хятрууны халуун рашаан, Цайдам нуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд экологийн доройтолд орж байгаа бөгөөд Хархорум хотын туурь, Төвхөн хийд, Хар балгас, Шанхын баруун хүрээ хийд болон бусад соёлын үл хөдлөх дурсгалууд нь аялал жуулчлалын бүтээгдэхүүний шаардлагын түвшинд хараахан хүрээгүй байна.. Эдгээр бүтээгдэхүүн болон тэдгээрийн хүрээлэн буй орчинд байгаль хамгаалал сул, тогтвортой аялал жуулчлалын зарчмууд хэрэгжихгүй байна. Ийм байдлаар цаашид үргэлжилбэл эко аялал хөгжих нөхцөлгүй, түүх соёлын үнэт дурсгалууд сүйдэн үгүй болох эрсдэлтэй орчин үүсээд байна.

Тус бүс нутгийн хот, суурингуудын ерөнхий байдлыг дүгнэж үзэхэд, газар ашиглалтын бүсүүд эмх цэгцгүй, ихэнх хэсгийг нь төлөвлөлтгүйгээр байгуулагдсан уламжлалт гэр сууц зонхилсон хороолол эзлэх бөгөөд энэ хэсэгт хүн амын дийлэнх хэсэг нь оршин сууж байна. Цахилгаанаас бусад инженерийн шугам сүлжээ байхгүй, үндсэн дэд бүтэц нь бүрдээгүй, усан хангамж болон ариутгах татуургын төвлөрсөн систем байхгүй байна. Хархорин хотын өмнө байсан дэд бүтэц ашиглалтгүй байна. Хот, суурины барилга, архитектурын чанар, тохижилтын түвшин доогуур байна. Эдгээр байдал нь аялал жуулчлалын хотын төдийгүй хот байгуулалт төлөвлөлтийн наад захын шаардлагыг хангахгүй байна.

Иймд энэ чиглэлээр хийгдэж байсан судалгааны ажлуудын үр дүн, одоогийн бодит нөхцөл байдал, хэтийн төлөвийн уялдаа холбоог хангасан хөтөлбөр боловсруулан Хархорины бүс нутгийн байгаль экологийн тогтвортой байдлыг ханган, хот байгуулалтын болон аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

### **2.3. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

#### **2.3.1. Хөтөлбөрийн зорилго**

Дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн Дэлхийн Өв-Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар багтаж байгаа газар нутаг, хүн төрөлхтний түүхэн дэх соёл иргэншлийн үүслийн нэг зангилаа төв нь байсан бөгөөд төв Азийн нүүдэлчдийн өлгий нутаг болох Хархорины бүс нутгийг, Орхоны хөндийн соёлын биет өвийн, түүхэн үе үеийн бүхий л дурсгалуудыг цогцолбороор нь хадгалан хамгаалж, сэргээн босгож, соёлын биет бус өвийг уламжлан хадгалсны үндсэн дээр олон улсын жуулчид сонирхож зорин ирэх газрын нэг, Монгол улсад тогтвортой аялал жуулчлалын хөгжлөөрөө тэргүүлдэг, аялал жуулчлалын салбараас орон нутгийн төсөв болон нутгийн иргэдэд бодит орлого оруулдаг, байгальд ээлтэй, оюуны багтаамж өндөртэй үйлдвэрлэл, аялал жуулчлал хөгжсөн, нүүдлийн соёлын өв уламжлалыг орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулан хөгжсөн үндэсний өвөрмөц дүр төрх бүхий жуулчдын төв бүс нутаг болгоход хөтөлбөрийн үндсэн зорилго оршино.

#### **2.3.2. Хөтөлбөрийн зорилтууд**

- Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- Хархорин хотыг бүсийн аялал жуулчлалын төв хот болгон бусад сумын төвүүдийг шинэчлэн хөгжүүлэх;
- Аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Түүх, соёлын биет өвийг хадгалан хамгаалж, сэргээн бүтээх, болон биет бус өвийг хадгалах, хамгаалах;
- Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзмэр, үзүүлбэрүүдийг уламжлалд түшиглэн, шинээр бий болгох;
- Байгаль орчин, экологийг хамгаалах, нөхөн сэргээх;
- Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз, цогцолбор байгуулах;
- Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газар болон Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих;

## **2.4. Хэрэгжүүлэх арга зам**

### **2.4.1. Хархорины аялал жуулчлалын бүсийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоо, хот суурингуудийг хөгжүүлэх талаар**

- Хархорин хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, бусад сумын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүдийг шинэчлэн боловсруулж батлуулах;
- Аялал жуулчлалын болон байгаль-экологийн хамгаалалтын бүсийг тодорхой гаргаж, тэдгээрт мөрдөх дэглэмийг тогтоох;
- Бүсийн хот, суурин газруудыг үндэсний архитектурын өв уламжлалын өвөрмөц шийдэлд түшиглэн орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан, бүс нутгийн экологийн даацад тохирсон, байгаль орчин, өв соёлд сөрөг нөлөөгүй бичил үйлдвэрлэл бүхий хот, сууринууд болгон хөгжүүлэх;
- Хот, суурины зам тээвэр, дэд бүтцийг хөгжүүлэх;

### **2.4.2. Аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар**

- Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
- Аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн сайжруулах;
- Түүх соёлын дурсгалт газруудыг сэргээн засварлах, тохижуулах, байгалийн үзэсгэлэнт газруудыг нөхөн сэргээх;
- Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулах, үзмэр, үзүүлбэр бий болгох;
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын амьд тогтолцоог хөгжүүлэх;

### **2.4.3. Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх талаар**

- Аялагч, жуулчин, зочдыг хүлээн авах төв, зочид буудлын цогцолбор байгуулах;
- Олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз байгуулах;
- Аялал жуулчлалын үндсэн маршрутын замуудыг байгаль, экологийн тэнцвэртэй уялдуулсан байдлаар хатуу хучилттай болгох, туслах маршрутын замуудыг сайжруулах;
- Аялал жуулчлалын хослох бүтээгдэхүүн, үйлчилгээг бүх талаар дэмжин хөгжүүлэх;
- Олон улсын нисэх онгоцны буудлыг байгаль экологи, өв соёлыг хадгалан хамгаалах Дэлхийн Өвийн шаардлагад нийцүүлэн, зохистой байршлыг сонгон барьж байгуулах;

### **2.4.4. Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих**

- Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын нутаг дэвсгэрт тухайн хамгаалалтын дэглэм, шаардлагуудыг нь чанад баримтлан бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх;

- Хүрээлэн буй орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээх тогтолцоог бэхжүүлэх;
- Түүх, соёлын дурсгалуудыг байнгын хамгаалалттай болгох, зарим түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүсийг нэмж тогтоон баталгаажуулах;
- Нүүдлийн соёлын үнэт зүйлсийг хадгалан хамгаалж, нүүдлийн соёлын зан үйлийг сэргээх, түүнийг хадгалахад онцгой анхаарч, нутгийн иргэдийн хэвшил болгох;

### **2.5. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг барилга, хот байгуулалт, аялал жуулчлал болон соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд гүйцэтгэнэ.
- Дэлхийн Өв - Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын нутаг дэвсгэрт үл хөдлөх өв болон биет бус өвийг хадгалж, хамгаалах, сэргээн бүтээх, засаж сэлбэх, ашиглалтын үйл ажиллагааг зохицуулах, хадгалалт, хамгаалалт, сэргээн босголтын горимд харш аливаа үйл ажиллагааг хуулийн дагуу хориглох, хяналт тавих арга хэмжээг Дэлхийн Өв - Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа гүйцэтгэнэ.
- Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын нутаг дэвсгэрт хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглалтын үйл ажиллагааг зохицуулан тусгай хамгаалалттай газрын горимд харш аливаа үйл ажиллагааг хуулийн дагуу хориглох, хяналт тавих арга хэмжээг Орхоны хөндийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаа гүйцэтгэнэ.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг аймгийн Засаг дарга нар хариуцна.
- Мэдээлэл, сурталчилгаа, маркетингийн асуудлыг Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргаа хариуцна.
- Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн өрийн бус байгууллагуудын гүйцэтгэж чадах олон чиг үүргийг тэдэнд шилжүүлэх замаар түншлэл хамтын ажиллагааг өргөтгөнө

### **2.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгон хөгжүүлэх хөтөлбөрийг 2008-2028 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Эхний үе шатыг 2008-2018 онд, хоёрдугаар үе шатыг 2019-2028 онд тус тус хэрэгжүүлнэ.

### **2.7. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт**

Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгох хөтөлбөрийг дараахь эх үүсвэрүүдээр санхүүжүүлнэ.

а. Улсын төсөв

б. Орон нутгийн төсөв

в. Гадаад орон, олон улсын байгууллагын хөрөнгө, хандив



## г. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

### 2.8. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

- Хархорины аялал жуулчлалын бүсийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоо, газар зохион байгуулалтыг боловсронгуй болгосон байна.
- Аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, хүртээмж нэмэгдэж сайжирна.
- Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг сэргээн засварлаж, байгалийн үзэсгэлэнт газруудийг нөхөн сэргээж тохижуулсан, тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулагдсан байна.
- Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзмэр, үзүүлбэрүүд шинээр нэмэгдэж бий болсон байна
- Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжиж, олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз байгуулагдана.
- Дэлхийн Өвд бүртгэгдсэн газар нутгийн дэглэмийг чанд баримтлан, Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллах нөхцөл бүрдэнэ.
- Хүрээлэн буй орчны экосистемийн тогтвортой байдлыг хангаж, түүх соёлын дурсгалуудын хадгалалт хамгаалалт сайжирна.
- Хархорины аялал жуулчлалын бүсийн хот суурин газруудын хөгжлийг ерөнхий төлөвлөгөөний дагуу удирдан зохицуулж хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Хөтөлбөрийн удирдлагын хүрээнд Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалтын тогтолцоо бүрэлдэн бий болно.
- Аялал жуулчлалын үндсэн маршрутын дагуух замуудыг хатуу хучилттай болгон, туслах маршрутын дагуух замуудыг сайжруулсан байна.
- Аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан хүрээлэн буй орчин, түүх, соёлын өвд ээлтэй, үндэсний өвөрмөц дүр төрх бүхий аялал жуулчлалын бүс болно.

### 2.9. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

- Хархорины аялал жуулчлалын бүсийн захиргаа байгуулагдан, үйл ажиллагаа нь тогтворжсон байдал;
- Хот, суурингууд батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болсон байдал, тоо;
- Дэлхийн Өв- Орхоны хөндийн соёлын дурсгалт газрын нутаг дэвсгэрт Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах конвенцийн шаардлагыг хангасан үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байдал, тоо;
- Түүх соёлын дурсгалт газрууд, байгалийн үзэсгэлэнт газруудийг сэргээн засварлаж, тохижуулсан байдал, тоо;
- Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзмэр, үзүүлбэрүүд шинээр нэмэгдэж бий болсон байдал, тоо;

- Тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулагдсан байдал, тоо;
- Түүх, соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах талаар арга хэмжээ авсан байдал, тоо;
- Байгаль орчин, экологийг хамгаалах, нөхөн сэргээх талаар арга хэмжээ авсан байдал, тоо;
- Олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз байгуулагдсан байдал, тоо;
- Дэлхийн болон Монголын бусад бүс нутгаас ялгарах монгол үндэсний өвөрмөц дүр төрхийг хадгалж байгаа үзүүлэлтүүд, тоо хэмжээ;

## 2.10. Хархорин, Эрдэнэзуу орчмыг хот төлөвлөлтийн орчин үеийн аргачлалаар жуулчдын төв хот болгох хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө

*Нэгдүгээр үе шат (2009-2018 он)*

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцан гүйцэтгэх байгууллага
<b>1. Хархорины аялал жуулчлалын бүсийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоо, хот суурингуудийг хөгжүүлэх талаар:</b>				
<b>1.1. Хархорин хот болгон бусад сумын төвүүдийг шинэчлэн хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүдийг тодотгох, боловсруулж батлуулах</b>				
1.1.1	Хархорин хотын хөгжлийн ерөнхий төлөвлөлгөөнд тодотгол хийж, шинэчлэн боловсруулж батлуулах	2009-2010	Улсын төсөв	ЗТБХБЯ
1.1.2	Хужирт сумын төв, Хужирт суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2009-2010	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Өвөрхангай аймгийн ЗДТГ
1.1.3	Бат-Өлзий сумын төв, Өвт суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2009-2010	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Өвөрхангай аймгийн ЗДТГ
1.1.4	Өгийнуур сумын төв, Зэгстэй суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2009-2010	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Архангай аймгийн ЗДТГ
1.1.5	Хотонт сумын төв, Хотонт суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2009-2010	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Архангай аймгийн ЗДТГ
1.1.6	Хашаат сумын төв, Баян суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	2009-2010	Улсын төсөв Аймгийн төсөв	БХБЗТЯ Архангай аймгийн ЗДТГ
1.1.7	Багуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө загвар болгон, Хархорин сумын Шанх багийн төвийн загвар ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлж эхлэх	2009-2010	Аймгийн төсөв Сумын төсөв	Өвөрхангай аймгийн ЗДТГ, Хархорин сумын ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ
<b>1.2. Аялал жуулчлалын болон байгаль-экологи, өв соёлын хамгаалалтын бүсийг тодорхой гаргаж, тэдгээрт мөрдөх дэглэмийг тогтоох</b>				
1.2.1	Хархорины бичил бүсийн аялал жуулчлалын болон байгаль-экологи, өв соёлын хамгаалалтын бүсийн хилийг нарийвчлан тогтоох	2009-2011	Аймгийн төсөв Сумын төсөв	БСШУЯ БОАЖЯ, ДӨ-ОХСДГХЗ Архангай, Өвөрхангай аймгийн ИТХ ХАЖБЗ
1.2.2	Аялал жуулчлалын болон байгаль-экологи, өв соёлын хамгаалалтын бүсэд баримтлах дэглэмийг боловсруулан тогтоож батлан мөрдөж эхлэх	2009-2011	Аймгийн төсөв Сумын төсөв	БСШУЯ БОАЖЯ,

				ДӨ-ОХСДГХЗ Архангай , Өвөрхангай аймгийн ИТХ ХАЖБЗ,
1.2.3	Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсэд байрлаж байгаа ашиглагдахгүй болсон объектуудыг нүүлгэн шилжүүлэх.	2010-2012	Улсын төсөв	ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ Өвөрхангай аймгийн ЗДТГ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
1.2.4	Хархорум хотын туурийн дундуур татсан усжуулалтын ашиглаж байсан хоолойг зайлуулах.	2010-2012	Улсын төсөв	ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ Өвөрхангай аймгийн ЗДТГ Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
1.2.5	Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсэд байрлаж байгаа цахилгааны шугам, цэвэрлэх байгууламжийг нүүлгэн шилжүүлэх	2015-2018	Улсын төсөв	ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ Өвөрхангай аймгийн ЗДТГ Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
1.2.6	Дэлхийн Өв-Орхоны хөндийн Соёлын дурсгалт газар, Байгалийн цогцолбор газруудын хилийн цэсийг тэмдэгжүүлэх, хаяг, тэмдэг байрлуулах	2009-2011	Улсын төсөв Аймгийн төсөв	Архангай , Өвөрхангай аймгийн ЗДТГ ХАЖБЗ ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил
1.2.7	Хархорины бичил бүсийн нутаг дэвсгэрт уул уурхайн хайгуулын лиценц, ашиглалтын зөвшөөрөл олгохыг бүрэн хориглох, өгөгдсөн лиценц, зөвшөөрлүүдийг хүчингүй болгох	2009- 2010	Улсын төсөв	ЭБЭХЯ
<b>1.3. Бүсийн хот, суурин газруудыг монгол үндэсний өвөрмөц дүр төрх бүхий хот, сууринууд болгон хөгжүүлэх;</b>				
1.3.1	Бүсийн хот, суурин газруудыг монгол үндэсний архитектурын өв уламжлалыг, орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулан хөгжүүлэх	2009-2018	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Архангай , Өвөрхангай аймгийн ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ
1.3.2	Бүсийн хот, суурин газруудыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй орчин үеийн авсаархан үйлдвэрлэл хөгжсөн, байгальд ээлтэй хот сууринууд болгон хөгжүүлэх	2009-2018	Улсын төсөв Аймгийн төсөв	БОАЖЯ, Архангай , Өвөрхангай аймгийн ЗДТГ

				ДӨ-ОХСДГХЗ
1.3.3	Хот, суурингуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	2011-2018	Улсын төсөв Аймгийн төсөв	БХБЗТЯ Аймгуудын ЗДТГ
1.3.4	Хархорин хотыг Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах конвенцийн шаардлагыг хангах түвшинд хүргэхээр хөгжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	2011-2018	Улсын төсөв Аймгийн төсөв	БХБЗТЯ Аймгуудын ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ
1.3.5	Хархорин хот болон сумын төвүүдийн гудамж, хашаа, байшинг уламжлалт монгол төрхөд ойртуулан, монгол гэрийн хөгжлийн дэвшлийг тусган хөгжүүлэх.	2009-2018	Орон нутгийн төсөв Хувийн хэвшил	Аймгуудын ЗДТГ Сумдын ЗДТГ, МГХҮТ Хувийн хэвшил
<b>1.4. Хот, суурины зам тээвэр, дэд бүтцийг хөгжүүлэх</b>				
1.4.1	Дэлхийн Өвийн хамгаалалтын хилийн гадна, олон улсын нисэх онгоцны буудал барьж байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах.	2009-2010	Улсын төсөв	ЗТБХБЯ
1.4.2	Олон улсын нисэх онгоцны буудал барьж байгуулах ажлыг эхлүүлэх.	2010-2018	Улсын төсөв	ЗТБХБЯ
1.4.3	Хужиртын нисэх онгоцны буудлыг шинэчлэн сайжруулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах, Хархорины нисэх онгоцны буудлыг Дэлхийн Өвийн хамгаалалтын хилийн гадна шилжүүлэн байрлуулах	2009-2014	Улсын төсөв	ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ
1.4.4	Хот, суурины замын тэмдэг, тэмдэглэгээний болон гудамжны хаягийн стандартыг зохиох, тэдгээрийг мөрдүүлэх дүрэм, журмыг боловсруулах, шуудангийн кодын системийг боловсронгуй болгох	2010-2011	Аймгийн төсөв Сумын төсөв	ЗТБХБЯ, Аймаг, сумдын ЗДТГ
1.4.5	Хужирт сумын төвд цэвэрлэх байгууламж шинээр барьж байгуулах. Бохирдсон газрыг нөхөн сэргээх.	2009-2012	Улсын төсөв	ЗТБХБЯ БОАЖЯ, Сумын ЗДТГ
1.4.6	Сумын төвүүдэд бага хэмжээний цэвэрлэх байгууламж барих.	2009-2012	Улсын төсөв	ЗТБХБЯ БОАЖЯ, Сумын ЗДТГ
1.4.7	Сумын төвүүдийг цэвэр усны хангамжийн найдвартай эх үүсвэр, шугам сүлжээтэй болгох	2009-2018	Улсын төсөв	ЗТБХБЯ БОАЖЯ, Сумын ЗДТГ
1.4.8	Орчин үеийн технологид түшиглэсэн мэдээлэл, харилцаа холбооны орчинг бий болгох, интернэтийн ба үүр телефоны өргөн сүлжээгээр бүрэн хангах.	2010-2018	Улсын төсөв Хувийн хөрөнгө оруулалт	ЗТБХБЯ, ХАЖБЗ, Хувийн хэвшил
1.4.9	Байгаль, экологид сөрөг нөлөөгүй эрчим хүчний эх үүсвэр, ялангуяа сэргээгдэх эрчим хүчийг өргөнөөр ашиглах арга хэмжээ авах	2010-2018	Улсын төсөв Хувийн хөрөнгө оруулалт	ЗТБХБЯ, БОАЖЯ, ЭБЭХЯ Хувийн хэвшил
<b>2. Аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх</b>				

<b>2.1. Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох</b>				
2.1.1	Хархорины бүсийн аялал жуулчлалын захиргааг байгуулах: Бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах төрийн захиргааны байгууллага байгуулах, ДӨ-ОХБДГХЗ, ОХБЦГХЗ болон бүсийн оршин суугчдын төлөөллийг оролцуулах замаар иргэдийн оролцоог хангах	2009-2010	Улсын төсөв	БОАЖЯ, Аймгуудын ЗДТГ Сумын ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ
2.1.2	<u>Менежментийн төлөвлөгөө боловсруулах:</u> Бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө боловсруулан батлах	2010-2011	Улсын төсөв	ХАЖБЗ ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ
2.1.3	<u>Бүсийн аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгаа, маркетингийг сайжруулах</u> Аялагч, жуулчид нэг газраас цогц мэдээлэл хүртэх боломжтой болгох. Энэ чиглэлд вэб сайт хийх, ном товхимол, сэтгүүл гаргах, CD танилцуулга хийх, шинэчилж байх	2009- 2018	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
2.1.4	Хөтөлбөрийн хэрэгжих хугацаанд Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг дэлхийн нийтэд танилцуулахад чиглэсэн сурталчилгааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах.	2009-2018	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
2.1.5	Аялал жуулчлалын үйлчилгээний стандарт, аттестатчилалын журам гаргах, чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.	2010-2028	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ
2.1.6	Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын мэргэжлийн боловсрол сургалт үйлчилгээний төвийг Хархорин хотод байгуулах	2010-2012	Улсын төсөв	БСШУЯ БОАЖЯ, ХАЖБЗ,
2.1.7	Хархорины бүсийн бэлчээрийн даац, ус ургамлын судалгаа хийж мал сүргийн байршил, нягтралыг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх.	2009-2012	Улсын төсөв	БОАЖЯ, ХХААХҮЯ ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ ХАЖБЗ, Хувийн хэвшил
2.1.8	Хархорины бүс нутагт үйлдвэрлэлийн зориулалтаар газар тариалан эрхлэх, газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмалын хайгуул явуулах, олборлолт хийх, уул уурхайн үйлдвэрлэлт явуулахгүй байх эрх зүйн орчин бүрдүүлэх.	2009-2010	Улсын төсөв	БОАЖЯ, ЭБЭХЯ
<b>2.2. Аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн сайжруулах</b>				
2.2.1	Хархорины бүсийн аялал жуулчлалын эхний ээлжийн үндсэн маршрутыг	2009-2012	Улсын төсөв	БОАЖЯ,

	тогтоох, хэрэгжүүлэх арга хэмжээ авах			ХАЖБЗ, Хувийн хэвшил
2.2.2	Хархорины бүсийн аялал жуулчлалын дэд бүсүүдийн доторх эхний ээлжийн туслах маршрутуудыг тогтоох, хэрэгжүүлэх ажлыг эхлэх	2013-2018	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ, Хувийн хэвшил
2.2.3	Хархорины бүсийн болон түүх, соёлын аялал жуулчлалын маршрут, үзмэр, жуулчны баазууд болон жуулчдад зориулсан бусад бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээлэл түгээх цэг, самбар зэргийг Хархорин хотод байгуулах.	2009-2010	Орон нутгийн төсөв Хувийн хэвшил	БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
2.2.4	Эрдэм шинжилгээ, судалгааны аялал жуулчлалын Өгийнуурын бичил бүсийн маршрут, үзмэр, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийн цэг, самбар зэргийг байгуулах.	2010-2011	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
2.2.5	Байгалийн аялал жуулчлалын Бат-Өлзийн бичил бүсийн доторх маршрутууд, аялал жуулчлалд зориулсан бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан самбар, мэдээллийн цэгийг сумын төвд байгуулах.	2009-2010	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
2.2.6	Рашаан сувиллын аялал жуулчлалын Хужиртын бичил бүсийн доторх маршрутууд, аялал жуулчлалд зориулсан бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээллийг агуулсан самбар, мэдээллийн цэгийг сумын төвд байгуулах.	2009-2010	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
<b>2.3. Түүх соёлын дурсгалт газрууд, байгалийн үзэсгэлэнт газруудийг сэргээн засварлах, тохижуулах</b>				
2.3.1	Эрдэнэ Зуу хийдийг хадгалж хамгаалах, сэргээн босгох, засаж тохижуулан хөгжүүлэх цогцолбор төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлж эхлэх	2010-2018	Улсын төсөв-80% Хувийн хэвшил-20%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ Эрдэнэзуу сүм музейн захиргаа Хувийн хэвшил
2.3.2	Төвхөн хийдийг иж бүрэн сэргээн тохижуулах, замыг засаж сайжруулах	2010-2014	Улсын төсөв-80% Хувийн хэвшил-20%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ Төвхөн хийдийн захиргаа Хувийн хэвшил
2.3.3	Өвөр агуйт, Ар агуйт, Тэмээн чулууний ам, Гүмбийн дэнж, Майхан толгой, Мухдагийн ам, Бага элтэй, Хөшөөн дэнж зэрэг газарт байрлах хиригсүүр, тахилгын онгон бүхий цогцолборуудад машины зогсоол, танилцуулга ба маршрутын самбар, хамгаалалтын хашаа зэрэг байгууламжуудыг барьж	2010-2016	Улсын төсөв-20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ ХАЖБЗ,

	байгуулан тохижуулах			Хувийн хэвшил, Археологийн хүрээлэн
2.3.4	Мэлхийт толгойн ордны туурь, Дойт толгойн ордны туурь, Чилингийн балгасан дээр танилцуулга ба маршрутын самбар хийх.	2010-2012	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ ХАЖБЗ, Хувийн хэвшил, Археологийн хүрээлэн
2.3.5	Хужирт суманд байрлах цуурмал хар чулуун хөшөө, Бумбатын өврийн хүн чулуу, Бага эрээний хүн чулуу, Дулааны хүн чулуун увшхай зэргийг сэргээн засварлах, хамгаалалтын хашаа, маршрут ба танилцуулгын самбар байгуулах.	2010-2012	Улсын төсөв–60% Хувийн хэвшил-40%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ ХАЖБЗ, Хувийн хэвшил, Археологийн хүрээлэн
2.3.6	Улаан цутгалан, Үүртийн тохой, Хоргой хүрэм, Цагаан голын хүрхрээ, Орхоны бага хүрхрээ зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад хамгаалалт, нөхөн сэргээлт, жуулчны аюулгүй байдлыг хангах, нөөцийн тогтвортой ашиглалтыг бий болгоход чиглэсэн ажлууд хийх.	2009-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ ХАЖБЗ, Хувийн хэвшил
2.3.7	Хөндлөн булгийн рашаан, Могойтын рашаан, Хустын рашаан, Хятрууны рашаан зэргийн хамгаалалт, зохистой ашиглалтын төлөвлөгөө, шаардлагатай бүтээн байгуулалтын ажлыг хийх.	2009-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	АЖБЗ, Хувийн хэвшил
2.3.8	Шанхын баруун хүрээ хийдийг сэргээн засварлаж, тохижуулах	2010-2013	Улсын төсөв–50% Хувийн хэвшил-50%	БСШУЯ ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ АЖБЗ, Хувийн хэвшил,
2.3.9	Хархорины бүсэд түүх, археологийн судалгаа хийж, түүх соёлын дурсгалуудын үнэ цэнэ, хугацааг тогтоох, малтлагууд хийх	2009-2018	Улсын төсөв	БСШУЯ, Археологийн хүрээлэн, ДӨ-ОХСДГХЗ
<b>2.4. Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулах, үзмэр, үзүүлбэр бий болгох</b>				
2.4.1	"Хархорум" музей байгуулах	2009-2012	Улсын төсөв Япон улсын хөрөнгө, хандив	БСШУЯ "Хархорум" музейн захиргаа
2.4.2	Уйгарын язгууртны бунханы музей байгуулах	2009-2012	Улсын төсөв	БСШУЯ
2.4.3	"Нүүдэлчдийн өв соёлын гэр хүрээ" цогцолбор байгуулах	2009-2018	Улсын төсөв Хувийн хэвшил Гадаад болон олон	Хархорин сумын ЗДТГ МГХҮТ ТББ



			улсын байгууллагын хөрөнгө	
2.4.4	Шанхын Баруун хүрээнд "Чингис хааны сүлд тугны өргөө" цогцолборыг байгуулах	2010-2014	Улсын төсөв-50% Хувийн хэвшил-50%	БСШУЯ ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
2.4.5	Тахилгат уулыг тахих зан үйл, ёслолыг цаг хугацааны дараалалд оруулан түүх соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох.	2009-2018	Улсын төсөв-10% Хувийн хэвшил-90%	БСШУЯ ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ ХАЖБЗ, Хувийн хэвшил
2.4.6	Эрийн гурван наадам, адууны баяр, сарлагны баяр зэргийг аялал жуулчлалын улиралд нэг газар, тогтмол зохион байгуулах.	2009-2018	Улсын төсөв-10% Хувийн хэвшил-90%	ХАЖБЗ, Хувийн хэвшил, ДӨ-ОХСДГХЗ ТББ
2.4.7	Нүүдэлчин малчдын ахуй амьдралтай танилцуулах, жуулчид өөрсдөө нүүдэлчдийн орчин ахуйд орж, тодорхой хугацаанд хамтран амьдрах нөхцлийг бүрдүүлсэн аяллын бүтээгдэхүүн, маршрут бий болгох.	2009-2018	Улсын төсөв -10% Хувийн хэвшил-90%	ХАЖБЗ, Хувийн хэвшил, ДӨ-ОХБДГХЗ
2.4.8	Эсгий хийх, хонь хяргах, ямаа самнах, гүүний үрс хийх, унага тамгалах, эмнэг хангал сургах гэх мэтийн нүүдлийн соёлын тодорхой уламжлал, заншил, ёслолуудыг жуулчдад сонирхуулах үндсэн маршрутад оруулах.	2009-2018	Улсын төсөв-10% Хувийн хэвшил-90%	ХАЖБЗ, Хувийн хэвшил, ДӨ-ОХСДГХЗ ТББ
2.4.9	Хотонт сумын төвд орон нутгийг судлах музейг байгуулах, түүхийн үнэ цэнэтэй дурсгалуудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах.	2010-2014	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БСШУЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил
<b>2.5. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын амьд тогтолцоог хөгжүүлэх</b>				
2.5.1	Сумын иргэд олон нийтийг жуулчидтай найрсаг, эелдэг харилцах, анд нөхөд байх сэтгэлгээг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах. Сургалт, сурталчилгааны ажил өрнүүлэх.	2009-2018	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, Хувийн хэвшил ДӨ-ОХСДГХЗ
2.5.2	Монгол айл гэрийн соёлын уламжлалыг хөгжүүлж, орчин үеийн үнэт зүйлсээр баяжуулан төгөлдөржүүлэх	2009-2018	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	ХАЖБЗ, Хувийн хэвшил ДӨ- ОХБДГХЗ ТББ
2.5.3	Бат-Өлзий, Хужирт, Хархорин сумдын хилийн зааг нутаг орчимд нүүдлийн соёл уламжлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох. Малчид, нутгийн иргэдэд суурилсан аялал жуулчлалыг тус бичил бүсэд хөгжүүлэх.	2009-2018	Улсын төсөв-10% Хувийн хэвшил-90%	ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил, ТББ
<b>3. Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчны бааз байгуулах</b>				

<b>3.1. Аялагч, жуулчин, зочдыг хүлээн авах төв, зочид буудлын цогцолбор, олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз байгуулах</b>				
3.1.1	Хархоринд аялагч, жуулчид, зочдыг хүлээн авах төв, зочид буудлын цогцолбор байгуулах.	2009-2014	Улсын төсөв	БСШУЯ ЗТБХБЯ
3.1.2	Уйгарын хар балгасын ойролцоо зочид хүлээн авч үйлчлэх нүүдлийн үйлчилгээний газрыг байгуулах.	2010-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил
3.1.3	Хөшөө цайдамын ойролцоо өндөр зэрэглэлийн жуулчны бааз, жуулчдад зориулсан үйлчилгээг ДӨ-ОХБДГ-ын хамгаалалтын хилийн гадна байгуулах.	2010-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил
3.1.4	Улаан цутгалангийн ойролцоо өндөр зэрэглэлийн жуулчны бааз, жуулчны үйлчилгээг байгуулах.	2010-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ХАЖБЗ, ОХБДГХЗ Хувийн хэвшил
3.1.5	Найман нуурын дээд ба доод хэсэгт аялагч, жуулчин, зочдыг хүлээн авах төв болон ердийн хөсгөөр үйлчлэх цэгийг байгуулах.	2009-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ХАЖБЗ, ОХБДГХЗ Хувийн хэвшил
3.1.6	Хустын рашааны ойролцоо жуулчны бааз, ердийн хөсгөөр үйлчлэх цэг, хамгаалалтын хашаа, тэмдэгжүүлэлт, чулуун зам барьж байгуулах.	2009-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил
3.1.7	Цагаан залаат хүүхдийн зуслангийн ойролцоо жуулчны бааз, жуулчид хүлээн авах дэд үйлчилгээг бий болгох.	2010-2014	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил
<b>3.2. Аялал жуулчлалын үндсэн маршрутын болон туслах маршрутын дагуух замуудыг сайжруулах</b>				
3.2.1	Хархорин, Хужиртын хооронд 55 км хатуу хучилттай зам тавьж дуусгах.	2009-2011	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.2	Хужирт, Бат-Өлзий сум хооронд дахь 45 км сайжруулсан шороон зам тавих.	2010-2011	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.3	Бат-Өлзий→Улаан Цутгалан→Хүйсийн найман нуур чиглэлийн сайжруулсан шороон зам тавих	2010-2011	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.4	Улаан цутгалан→Төвхөн хийд→Хархорин чиглэлийн сайжруулсан шороон зам тавих	2012-2014	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ

3.2.5	Төвхөн →Хотонт чиглэлийн сайжруулсан шороон зам тавих	2014	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.6	Хөшөөт цайдам→Өгий нуур чиглэлийн хатуу хучилттай замыг тавьж дуусгах	2009-2011	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.7	Хархорин→Хотонт чиглэлийн хатуу хучилттай зам тавьж дуусгах	2009-2010	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.8	Өгийнуур→Хотонт чиглэлийн сайжруулсан шороон зам тавих	2010-2011	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ
3.2.9	Орхон гол, Хустын гол, Улаан гол болон бусад жижиг голууд дээгүүрх гүүрүүдийг засварлах, зарим шаардлагатай газарт шинээр гүүр барих	2010-2018	Улсын төсөв Орон нутгийн төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ, Аймгуудын ЗДТГ
<b>3.3. Аялал жуулчлалын хослох бүтээгдэхүүн, үйлчилгээг бүх талаар дэмжин хөгжүүлэх</b>				
3.3.1	Гар урлал, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, жуулчдад зориулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сумын төвүүдэд хөгжүүлэх.	2009-2018	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	Аймгуудын ЗДТГ ХАЖБЗ, Хувийн хэвшил
3.3.2	Жуулчдад зориулсан үндсэн үйлчилгээг Хархорин суманд төвлөрүүлэх, бусад сумын төвүүдэд жуулчдад зориулсан үйлчилгээ эрхлэхэд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэх.	2009-2028	Хувийн хэвшил	Аймгуудын ЗДТГ ХАЖБЗ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
3.3.3	Хотонт суманд хүнсний ногоо, мах, сүү цагаан идээ, өндөг, тахиа гахайны мах болон бусад хүнсний бүтээгдэхүүний хангалтыг хийхэд чиглэсэн аж ахуй байгуулах.	2009-2018	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	ХХААХҮЯ Аймгуудын ЗДТГ Хувийн хэвшил
3.3.4	Хашаат суманд аялал жуулчлалын газруудыг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилгоор тус суманд мал аж ахуй, газар тариалан хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	2009-2014	Улсын төсөв-20% Хувийн хэвшил-80%	ХХААХҮЯ Аймгуудын ЗДТГ Хувийн хэвшил
3.3.5	Хархорины аялал жуулчлалын бүс дэх ДӨ-ОХСДГ-ын нутагт шалган нэвтрүүлэх хилийн пост байгуулах	2009-2010	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Сумын ЗДТГ
3.3.6	Өгий нуурын эрэг дээр шувуу, ус намгархаг газар, нуурын талаар мэдээлэл, судалгаа, сурталчилгааны төв байгуулах.	2009-2010	Улсын төсөв Япон улсын хөрөнгө, хандив	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ, JICA, Хувийн хэвшил
<b>4. Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих</b>				
<b>4.1. Дэлхийн Өв- Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын нутаг дэвсгэрт дэглэм, шаардлагыг нь чанд баримтлан бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх.</b>				

4.1.1	Хархорины бүс ба ОХСДГ зэргийн хамгаалалтын шаардлагыг хангасан, дэлхийн жишигт хүрсэн үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй үндэсний онцлогтой жуулчны бааз, зочид буудлын үйлчилгээний газруудыг байгуулах, аялал жуулчлал эрхлэх эрх зүйн орчин бүрдүүлж хэрэгжүүлэх.	2009-2011	Улсын төсөв	БОАЖЯ, ЗТБХБЯ
4.1.2	Хархорины бүсийн байгаль орчны үнэлгээ болон түүх археологийн иж бүрэн судалгаан дээр үндэслэн жуулчны зорих газрууд ба татах чадвар бүхий нөөцүүдийг хамгаалах төлөвлөгөө боловсруулах.	2009-2010	Улсын төсөв	БСШУЯ, БОАЖЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил ДӨ-ОХСДГХЗ
4.1.3	Үүртийн тохой, Шанхын хийд, Хар балгас, Өвөр агуйтын хиригсүүр, Тэмээн чулууны амны хиригсүүр, Мухдагийн амны дурсгал, Орхон-7, Мойлтын амны дурсгал зэрэгт үерийн хамгаалат барих, хамгаалалтын хашаа барих, байнгын ба байнгын бус хамгаалагчтай болгох.	2009-2012	Улсын төсөв-50% Хувийн хэвшил-50%	БСШУЯ, БОАЖЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
4.1.4	Хархорины бүсийн түүх соёлын дурсгалууд, байгалийн үзэсгэлэнт томоохон зорих газрууд, жуулчны баазууд, болон бусад цогцолборуудад аянга зайлуулагч суурилуулах	2009-2012	Улсын төсөв-50% Хувийн хэвшил-50%	БСШУЯ, БОАЖЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
4.1.5	Могойтын рашаан, Хятрууны рашаан, Төвхөн хийд, Өндөр сант хайрхан, Хүйсийн найман нуур зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудад ой түймрээс сэргийлэх, гарсан түймрийг унтраахад чиглэсэн тусгай ангийг бэлтгэх, техник тоног төхөөрөмжөөр хангах.	2010-2014	Улсын төсөв-70% Хувийн хэвшил-30%	БСШУЯ, БОАЖЯ ХАЖБЗ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
<b>4.2. Хүрээлэн буй орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээх тогтолцоог бэхжүүлэх</b>				
4.2.1	Хархорин хот болон бусад суурин, жуулчдын баазуудын хог хаягдлын одоогийн механизмийг боловсронгуй болгох, төвийн хур хогийг цэвэрлэх. Хог хаягдлыг ялгаж дахин боловсруулалт хийх цех байгуулах. Хогийн цэгүүдийг шинэчлэн тохижуулах	2009-2014	Улсын төсөв	БОАЖЯ ХАЖБЗ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
4.2.2	Хот, суурины төвийн элсний нүүдлийг зогсоох, мод тарих, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах	2009-2018	Орон нутгийн төсөв Хувийн хэвшил	БОАЖЯ ХАЖБЗ, Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
4.2.3	Хашаат, Хотонт, Хархорин сумдын нутаг дэвсгэрт цөлжилт, хөрсний элэгдэл, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх.	2009-2018	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил

4.2.4	Бат-Өлзий, Хужирт, Хархорин, Уянга сумын нутаг дэвсгэрийн ойн санг хамгаалах, тайрах огтлолт хийхгүй байх, гал түймрийн аюулаас хамгаалах, ойн нөхөн тарилт хийх.	2009-2018	Улсын төсөв-50% Хувийн хэвшил-50%	БОАЖЯ, ХАЖБЗ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.5	Хужирт сумын төвийг газрын элэгдэл, нуралтыг зогсоох арга хэмжээ авах	2009-2011	Улсын төсөв Орон нутгийн төсөв	Сумын ЗДТГ ТББ
4.2.6	Орхон, Тамир, Хөгшин Орхон, Улаан, Хятруун, Хуст, Цагаан гол болон Өгий, Дойт зэрэг гол, нууруудын хог хяагдлыг цэвэрлэх, орчмын хог хаягдлын менежментийг оновчтой зохион байгуулах, эргийн нуралтаас сэргийлэх. Жижиг нуур, цөөрөм, булаг шанд, гол горхийг хамгаалах. Усны ундрагыг бүрэн хамгаалалтад авах.	2009-2018	Улсын төсөв-50% Хувийн хэвшил-50%	БОАЖЯ, ХАЖБЗ, ОХБЦГХЗ  Хувийн хэвшил
4.2.7	Хархорины бүсийн биологийн төрөл зүйл, нэн ховор амьтан ургамлын зүйл бүрдлийн судалгаа хийх, хамгаалалт ба нөхөн сэргээлтийн иж бүрэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.	2009-2018	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.8	Хотонт сумын нутаг дэвсгэр дэх үлийн цагаан оготны томоохон голомтыг устгах, нүүдлийг зогсооход чиглэсэн арга хэмжээ авах.	2009-2010	Улсын төсөв-80% Хувийн хэвшил-20%	БОАЖЯ, Сумын ЗДТГ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.9	Элсний нүүдэл, хөрсний элэгдэл, цөлжилтийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах. Шороон шуургыг бууруулах. Ногоон байгууламж, ойн зурвас, цэцэрлэгт хүрээлэн байгуулах.	2009-2028	Орон нутгийн төсөв Хувийн хэвшил	БОАЖЯ, Сумын ЗДТГ, ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.10	Ойн санг хамгаалах, модны тайралтыг хязгаарлах, ойг нөхөн сэргээх арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлэх.	2009-2028	Улсын төсөв-40% Хувийн хэвшил-40% Орон нутгийн төсөв-20%	БОАЖЯ, Сумын ЗДТГ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
<b>4.3. Түүх, соёлын дурсгалуудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, улсын хамгаалалтанд байгаа зарим түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүсийг тогтоон баталгаажуулах</b>				
4.3.1	Судалгаа шинжилгээний ажлын дүнд тулгуурлан түүх, соёлын бусад дурсгал, дурсгалт газруудыг хадгалж, хамгаалах, хамгаалалтын бүс тогтоох, сэргээн босгох төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2010- 2018	Улсын төсөв-80% Орон нутгийн төсөв-20%	БОАЖЯ, ХАЖБЗ, Хувийн хэвшил ДӨ-ОХСДГХЗ
4.3.2	Төвхөн хийд, Эрдэнэзуу хийд, Хөшөө цайдамын цогцолбор, Шанхын хийд болон жуулчны баазуудад галын аюулаас сэргийлэх, галын дохиолол суурилуулах.	2009-2010	Улсын төсөв-20% Хувийн хэвшил-80%	БОАЖЯ, БШУЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ

				ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.3.3	Газар хөдлөлийн эрсдэлийг судлах, түүх соёлын дурсгалт газрууд болон байгалийн үзэсгэлэнт газруудыг газар хөдлөлийн эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах.	2009-2011	Улсын төсөв	ЗТБХБЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ
<b>4.4. Нүүдлийн соёлын үнэт зүйлсийг хадгалан хамгаалж, нүүдлийн соёлын зан үйлийг сэргээх, түүнийг хадгалахад онцгой анхаарч, нутгийн иргэдийн хэвшил болгох</b>				
4.4.1	Хархорины бүсэд байрлаж буй нүүдлийн уламжлалт соёл, арга технологи, амьдрах арга ухаан, ахуй соёл зэрэг биет бус өвийг судлах, тэдгээрийг хадгалж хамгаалах, нүүдлийн соёлын буруу үзэгдэл, үйлдлүүдийг хязгааралах зохистой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.	2010-2028	Улсын төсөв-80% Орон нутгийн төсөв-20%	БСШУЯ БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил

### Хоёрдугаар үе шат (2019-2028 он)

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцан гүйцэтгэх байгууллага
<b>1. Хархорины аялал жуулчлалын бүсийн нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоо, хот суурингуудийг хөгжүүлэх талаар:</b>				
<b>1.1. Хархорин хот болон бусад сумын төвүүдийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүдийн дагуу шинэчлэн хөгжүүлэх</b>				
1.1.1	Хархорин хотыг хөгжлийн шинэ ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэчлэн хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	2019-2028	Улсын төсөв	ЗТБХБЯ
1.1.2	Сумын төв, сууринуудыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнүүдийн дагуу шинэчлэн хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	2019-2028	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Өвөрхангай аймгийн ЗДТГ
1.1.3	Багийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	2019-2028	Аймгийн төсөв Сумын төсөв	Өвөрхангай аймгийн ЗДТГ Хархорин сумын ЗДТГ
<b>1.2. Аялал жуулчлалын болон байгаль-экологийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлж, хэвшүүлэх нутаг дэвсгэрийн бүсчлэлийн тогтолцоог боловсронгуй болгох</b>				
1.2.1	Хархорины бүсийн аялал жуулчлалын болон байгаль-экологийн хамгаалалтын бүсийн хилийн цэсийг тэмдэгжүүлэх, хаяг, тэмдэг байрлуулах	2019-2020	Аймгийн төсөв Сумын төсөв	БОАЖЯ, Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ ХАЖБЗ
1.2.2	Аялал жуулчлалын болон байгаль-экологийн хамгаалалтын бүсэд баримтлах дэглэмийг мөрдүүлж, хэвшүүлэх	2009-2019-2028	Аймгийн төсөв Сумын төсөв	БОАЖЯ, Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ

1.2.3	Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсэд байрлаж байгаа Дэлхийн Өвийн шаардлагад нийцэхгүй объектуудыг нүүлгэн шилжүүлж дуусах.	2019-2028	Улсын төсөв	ХАЖБЗ, ЗТБХБЯ ДӨ-ОХСДГХЗ Өвөрхангай аймгийн ЗДТГ Сумын ЗДТГ, Хувийн хэвшил
1.2.4	Судалгаа шинжилгээний ажлын дүнд тулгуурлан түүх, соёлын бусад дурсгал, дурсгалт газруудын хамгаалалтын бүсийг тогтоох.	2010- 2018	Улсын төсөв-80% Орон нутгийн төсөв- 20%	БСШУЯ ДӨ-ОХСДГХЗ Өвөрхангай аймгийн ЗДТГ Сумын ЗДТГ
1.2.5	Хархорины бүсийн бэлчээрийн даац, ус ургамлын судалгаа хийж мал сүргийн байршил, нягтралыг зохицуулах	2009-2012	Улсын төсөв	БОАЖЯ, АЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил
<b>1.3. Бүсийн хот, суурин газруудыг монгол үндэсний өвөрмөц дүр төрх бүхий хот, суурингууд болгон хөгжүүлэх;</b>				
1.3.1	Бүсийн хот, суурин газруудыг монгол үндэсний архитектурын өв уламжлалыг, орчин үеийн дэвшилтэт технологитой хослуулан, газар нутгийн байгаль, экологийн даацад нийцүүлэн хөгжүүлэх	2019-2028	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ ХАЖБЗ
1.3.2	Бүсийн хот, суурин газруудыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй орчин үеийн авсаархан үйлдвэрлэл хөгжсөн, байгальд ээлтэй, монгол үндэсний өвөрмөц хот сууринууд болгон хөгжүүлэх	2009-2018	Улсын төсөв Аймгийн төсөв	БОАЖЯ, Архангай, Өвөрхангай аймгийн ЗДТГ ХАЖБЗ
1.3.3	Хот, суурингуудын хөгжлийн ерөнхий төлөвлөлгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг жил бүрийн төлөвлөгөөнд тусган эрчимтэй хэрэгжүүлэх	2019-2028	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Аймгуудын ЗДТГ
1.3.4	Хархорин хотыг Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах конвенцийн шаардлагыг хангах түвшинд хүргэн хөгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2019-2028	Улсын төсөв Аймгийн төсөв	ЗТБХБЯ Аймгуудын ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ
<b>1.4. Хот, суурины зам тээвэр, дэд бүтцийг хөгжүүлэх</b>				
1.4.1	Бүсийн хот сууринуудыг зам тээвэр, дэд бүтцээр бүрэн хангах	2019-2028	Улсын төсөв Аймгийн төсөв Хувийн хөрөнгө оруулалт	ЗТБХБЯ Аймгуудын ЗДТГ
1.4.2	Олон улсын нисэх онгоцны буудал барьж байгуулах.	2019-2022	Улсын төсөв	БОАЖЯ, АЖБЗ
1.4.3	Байгаль, экологид сөрөг нөлөөгүй эрчим хүчний эх үүсвэр, ялангуяа сэргээгдэх эрчим хүчийг өргөнөөр ашиглах.	2019-2028	Улсын төсөв Хувийн хөрөнгө	ЗТБХБЯ, БОАЖЯ,

			оруулалт	ХАЖБЗ, Хувийн хэвшил
1.4.4	Хот, суурины замын тэмдэг, тэмдэглэгээний болон гудамжны хаягийн стандарт, шуудангийн кодын системийг бүрэн хэрэгжүүлэх	2019-2021	Аймгийн төсөв Сумын төсөв	ЗТБХБЯ, Аймаг, сумдын ЗДТГ
<b>2. Аялал жуулчлалын үйлчилгээ, бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх</b>				
<b>2.1. Хархорины бүсийн аялал жуулчлалын салбарын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох</b>				
2.1.1	<u>Хархорины бүс нутгийг тусгай статустай бүс нутаг болгох:</u> Хүн төрөлхтний хөгжилд оруулсан нүүдлийн соёлын үнэт өвийг хадгалсан, нүүдлийн соёл иргэншлийн байгальд ээлтэй оршихуйн мөн чанарыг ухааруулан тодотгосон, орчин үеийн нийгэмдээ зүй тогтолтой идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн, тогтвортой оршихуйн мөн чанарыг агуулсан, давтагдашгүй орчин байх бүс нутгийг бүрдүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх	2019-2020	Улсын төсөв	БСШУЯ БОАЖЯ, ЗТБХБЯ Аймгуудын ЗДТГ Сумын ЗДТГ ДӨ-ОХСДГХЗ
2.1.2	Бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх	2019-2028	Улсын төсөв Орон нутгийн төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ ДӨОХСДГХЗ
2.1.4	Хархорины аялал жуулчлалын бүс нутгийг дэлхийн нийтэд танилцуулахад чиглэсэн сурталчилгааны арга хэмжээг өргөн хүрээнд авч хэрэгжүүлэх.	2019-2028	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
2.1.5	Аялал жуулчлалын үйлчилгээний стандарт, чанарыг олон улсын түвшинд хүргэх.	2019-2028	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ
<b>2.2. Аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн сайжруулах</b>				
2.2.1	Хархорины бүсийн аялал жуулчлалын үндсэн маршрутыг шинэчлэн сайжруулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2019-2022	Улсын төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ
2.2.2	Хархорины бүсийн аялал жуулчлалын дэд бүсүүдийн доторх туслах маршрутуудыг шинэчлэн тогтоох, хэрэгжүүлэх ажлыг эхлэх	2019-2023	Улсын төсөв Орон нутгийн төсөв	БОАЖЯ, ХАЖБЗ, Хувийн хэвшил
<b>2.3.Түүх соёлын дурсгалт газрууд, байгалийн үзэсгэлэнт газруудийг сэргээн засварлах, тохижуулах</b>				
2.3.1	Эрдэнэзуу хийдийг хадгалж хамгаалах, сэргээн босгох, засаж тохижуулан хөгжүүлэх ажлыг цогцолбор төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2019-2028	Улсын төсөв–80% Хувийн хэвшил-20%	БСШУЯ ЗТБХБЯ Эрдэнэзуу сүм музейн захиргаа Хувийн хэвшил, ДӨ-ОХСДГХЗ



2.3.2	Хархорины бүсийн түүх, археологийн судалгаа хийж, түүх соёлын дурсгалуудын үнэ цэнэ, хугацааг тогтоох, малтлагуудыг үргэлжлүүлэн хийх	2019-2028	Улсын төсөв	БСШУЯ, Археологийн хүрээлэн, ДӨ-ОХСДГХЗ
2.3.3	Судалгаа шинжилгээний ажлын дүнд тулгуурлан түүх, соёлын бусад дурсгал, дурсгалт газрууд болон байгалийн үзэсгэлэнт газруудийг сэргээн засварлах, тохижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2019-2028	Улсын төсөв Орон нутгийн төсөв	БСШУЯ, ЗТБХБЯ Хувийн хэвшил, ДӨ-ОХСДГХЗ
<b>2.4. Түүх, соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, тодорхой сэдэвт хүрээлэн, цогцолбор байгуулах, үзмэр, үзүүлбэр бий болгох</b>				
2.4.1	"Их нүүдэл" цогцолбор байгуулах	2019-2012	Улсын төсөв Хувийн хэвшил Гадаад болон олон улсын байгууллагын хөрөнгө	ЗТБХБЯ БОАЖЯ БСШУЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил ТББ
2.4.2	Өгэдэй хааны "Түмэн Амгалант Ордон"-г "Мөнгөн мод", бусад дурсгалт барилгуудын хамт Монголын архитектурын цогцолбор байдлаар бүтээн босгох	2012-2015	Улсын төсөв Хувийн хэвшил Гадаад болон олон улсын байгууллагын хөрөнгө	ЗТБХБЯ БОАЖЯ БСШУЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
2.4.3	Дунд палеолитын үеийн "Орхон-7" дурсгалт газарт музей байгуулах	2019-2021	Улсын төсөв	БСШУЯ ЗТБХБЯ АЖБЗ, Хувийн хэвшил
2.4.4	Дээд палеолитын үеийн "Мойлтын ам"-ны дурсгалт газарт музей байгуулах	2019-2020	Улсын төсөв	БСШУЯ ЗТБХБЯ АЖБЗ, Хувийн хэвшил
2.4.5	Хархорум хотын туурьд археологийн иж бүрэн малтлага хийж, тодорхой хэсгийг нь сэргээн засаж, ил музей болгох	2009-2016	Улсын төсөв Гадаад болон олон улсын байгууллагын хөрөнгө	БСШУЯ ЗТБХБЯ БОАЖЯ ХАЖБЗ, Хувийн хэвшил ДӨ-ОХСДГХЗ
2.4.6	Хар Балгасын туурьд археологийн малталт хийж, тодорхой хэсгийг нь сэргээн засаж ил музей болгох	2019- 2025	Улсын төсөв Гадаад болон олон улсын байгууллагын хөрөнгө	БСШУЯ ЗТБХБЯ БОАЖЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ

				Хувийн хэвшил
<b>3. Аялал жуулчлалыг дэмжих дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчны бааз байгуулах</b>				
<b>3.1. Аялагч, жуулчин, зочдыг хүлээн авах төв, зочид буудлын цогцолбор, олон улсын стандартад нийцсэн жуулчны бааз байгуулах</b>				
3.1.1	Хужиртын рашаан сувиллын ойролцоо өндөр зэрэглэлийн жуулчны бааз, сувиллын газар барьж байгуулах.	2019-2024	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	ЗТБХБЯ БОАЖЯ Хувийн хэвшил
3.1.2	ДӨ-ОХСДГазар бол хүн төрөлхтний удмын сан, соёлшин нийгэмших амьдралын үүслийн дэлхийн нэг унаган голомт болохыг бэлэгдсэн "Бөртэ чоно" аялал жуулчлалын цогцолбор байгуулах	2020-2028	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	БСШУЯ ЗТБХБЯ БОАЖЯ ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
3.1.3	Найман нуурын дээд ба доод хэсэгт өндөр зэрэглэлийн жуулчны бааз болон ердийн хөсгөөр үйлчилэх цэгийг өргөжүүлэх.	2019-2024	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	ЗТБХБЯ БОАЖЯ Хувийн хэвшил
3.1.4	Өгий нуурын ойролцоо өндөр зэрэглэлийн жуулчны бааз байгуулах.	2014- 2018	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	ЗТБХБЯ БОАЖЯ Хувийн хэвшил
<b>3.2. Аялал жуулчлалын үндсэн маршрутын дагуух замуудыг хатуу хучилттай болгох, туслах маршрутын дагуух замуудыг сайжруулах</b>				
3.2.1	Хужирт, Бат-Өлзий сумын төвийн хооронд 45 км хатуу хучилттай зам тавих.	2019-2021	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ,
3.2.2	Бат-Өлзий→Улаан Цутгалан→Хүйсийн найман нуур чиглэлийн хатуу хучилттай зам тавих	2021-2022	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ,
3.2.3	Улаан цутгалан→Төвхөн хийд→Хархорин чиглэлийн хатуу хучилттай зам тавих	2019-2023	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ,
3.2.4	Төвхөн →Хотонт чиглэлийн хатуу хучилттай зам тавих	2023-2026	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ,
3.3.5	Өгийннуур→Хотонт чиглэлийн хатуу хучилттай зам тавих	2026-2028	Улсын төсөв	ЗТБХБЯ, БОАЖЯ,
<b>3.3. Аялал жуулчлалын хослох бүтээгдэхүүн, үйлчилгээг бүх талаар дэмжин хөгжүүлэх</b>				
3.3.1	Гар урлал, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, жуулчдад зориулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сумдын төвүүдэд эрчимтэй хөгжүүлэх	2019-2018	Улсын төсөв–20% Хувийн хэвшил-80%	Аймгуудын ЗДТГ ХАЖБЗ, Хувийн хэвшил
3.3.2	Жуулчдад зориулсан үндсэн үйлчилгээг Хархорин суманд төвлөрүүлэн, бусад сумын төвүүдэд жуулчдад зориулсан үйлчилгээг хөгжүүлэх	2019-2028	Хувийн хөрөнгө оруулалт	ХАЖБЗ, Сумдын ЗДТГ, Хувийн хэвшил


3.3.3	Хархорины бүсийг Хашаат, Хотонт сумдын аж ахуйн хүнсний ногоо, мах, сүү цагаан идээ, өндөг, тахиа гахайны мах болон бусад хүнсний бүтээгдэхүүнээр хангах	2019-2028	Хувийн хөрөнгө оруулалт	Сумын ЗДТГ ХАЖБЗ, Хувийн хэвшил
<b>4. Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих</b>				
<b>4.1. Дэлхийн Өв - Орхоны Хөндийн Соёлын Дурсгалт Газрын нутаг дэвсгэрт дэглэм, шаардлагыг нь чанад баримтлан бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх.</b>				
4.1.1	Хархорины бүс ба ОХСДГ зэргийн хамгаалалтын шаардлагыг хангасан, дэлхийн жишигт хүрсэн үйлчилгээ, бүтээгдэхүүнтэй үндэсний онцлогтой жуулчны бааз, зочид буудлын үйлчилгээний газруудыг байгуулах, аялал жуулчлал эрхлэх үйл ажиллагаанд тавих шаардлагыг нь чанад баримтлаж хэвшүүлэх	2019-2028	Улсын төсөв	БСШУЯ, БОАЖЯ ХАЖБЗ, ДӨ-ОХБДГХЗ Хувийн хэвшил
4.1.2	Аялал жуулчлалаас гарах сөрөг нөлөөллийг багасгах, бүс нутгийн ачаалалд тохирсон аялагч, жуулчдыг хүлээн авах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх	2019-2028	Улсын төсөв	БОАЖЯ ХАЖБЗ, ДӨ-ОХБДГХЗ Хувийн хэвшил
<b>4.2. Хүрээлэн буй орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээх тогтолцоог бэхжүүлэх</b>				
4.2.1	Хот, суурингуудад мод тарих, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн нэмж барьж байгуулах	2019-2028	Орон нутгийн төсөв Хувийн хэвшил	АЖБЗ, Сумын ЗДТГ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.2	Хашаат, Хотонт, Хархорин сумдын нутаг дэвсгэрт цөлжилт, хөрсний элэгдэл, хөрсний бохирдлыг бууруулахад чиглэсэн хөтөлбөрийг үргэжлүүлэн хэрэгжүүлэх.	2019-2028	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, Хувийн хэвшил
4.2.3	Хархорины бүс нутагт үйлдвэрлэлийн зориулалтаар газар тариалан эрхлэх, газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмалын хайгуул явуулах, олборлолт хийх, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үйл ажиллагааг бүрэн зогсоох	2019-2020	Улсын төсөв	ЭБЭХЯ БОАЖЯ, ДӨ-ОХБДГХЗ ОХБЦГХЗ ХАЖБЗ, Хувийн хэвшил
4.2.4	Жижиг нуур, цөөрөм, булаг шанд, гол горхийг хамгаалах. Усны ундрагыг бүрэн хамгаалалтад авах.	2019-2022	Улсын төсөв-50% Хувийн хэвшил-50%	БОАЖЯ, ХАЖБЗ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.5	Орхон гол болон түүний цутгалууд, Тамирын гол ба түүний цутгалуудын түвшинг хадгалах, ундаргыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.	2019-2028	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ЗТБХБЯ ХАЖБЗ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил

4.2.6	Хархорины бүсийн биологийн төрөл зүйл, нэн ховор амьтан ургамалын зүйл бүрдлийн судалгаа хийх, хамгаалалт ба нөхөн сэргээлтийн иж бүрэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.	2009-2018	Улсын төсөв-60% Хувийн хэвшил-40%	БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХБДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.7	Элсний нүүдэл, хөрсний элэгдэл, цөлжилтийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах. Шороон шуургыг бууруулах. Ногоон байгууламж, ойн зурвас, цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлэх.	2019-2028	Орон нутгийн төсөв Хувийн хэвшил	ХАЖБЗ, Сумын ЗДТГ, ДӨ-ОХБДГХЗ ОХБЦГХЗ Хувийн хэвшил
4.2.8	Ойн санг хамгаалах, модны тайралтыг хязгаарлах, ойг нөхөн сэргээх арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлэх.	2019-2028	Улсын төсөв-40% Хувийн хэвшил-40% Орон нутгийн төсөв-20%	БОАЖЯ, ХАЖБЗ, Сумын ЗДТГ, ОХБЦГХЗ Хувийн хэвшил
<b>4.3. Түүх, соёлын дурсгалуудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, зарим түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүсийг тогтоон баталгаажуулах</b>				
4.3.1	Түүх, соёлын дурсгалуудыг нутгийн иргэдээс бүрдүүлсэн байнгын гэрээт харуултай болгох	2019-2028	Улсын төсөв Орон нутгийн төсөв	БСШУЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
4.3.2	Хархорины бүсийн түүх, соёл болон археологийн иж бүрэн судалгаан дээр үндэслэн бусад шаардлагатай түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хамгаалалтын бүсүүдийг шинээр тогтоон баталгаажуулах	2019-2028	Улсын төсөв	БСШУЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил
<b>4.4. Нүүдлийн соёлын үнэт зүйлсийг хадгалан хамгаалж, нүүдлийн соёлын зан үйлийг сэргээх, түүнийг хадгалахад онцгой анхаарч, нутгийн иргэдийн хэвшил болгох</b>				
4.4.1	Хархорины бүсэд байрлаж буй нүүдлийн уламжлалт соёл, арга технологи, амьдрах арга ухаан, ахуй соёл зэрэг биет бус өвийг хадгалж хамгаалан, тэдгээрийг нутгийн иргэдийн амьдралд хэвшил болгох	2019-2028	Улсын төсөв Хувийн хэвшил	БСШУЯ БОАЖЯ, ХАЖБЗ, ДӨ-ОХСДГХЗ Хувийн хэвшил

## 2.11. Хавсралт зургууд

- Зураг 1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
- Зураг 2. Хангайн бүсийн бүлэг суурингийн тогтолцоо
- Зураг 3. Архангай, Өвөрхангай аймгуудын бүлэг суурингийн тогтолцоо
- Зураг 4. Хархорины аялал жуулчлалын бүсийн бүлэг суурингийн тогтолцоо
- Зураг 5. Хархорины аялал жуулчлалын бүсийн жуулчдыг татах чадвар бүхий нөөц, зорих газрууд
- Зураг 6. Хархорины аялал жуулчлалын бүсийн түүх, соёлын аялал жуулчлалын маршрут. 2008-2018 он
- Зураг 7. Хархорины аялал жуулчлалын бүсийн түүх, соёлын аялал жуулчлалын маршрут. 2019-2028 он
- Зураг 8. Хархорины аялал жуулчлалын бүсийн байгалийн аялал жуулчлалын бүсийн маршрут. 2008-2018 он
- Зураг 9. Хархорины аялал жуулчлалын бүсийн байгалийн аялал жуулчлалын бүсийн маршрут. 2019-2028 он
- Зураг 10. Хархорины аялал жуулчлалын бүсийн байгаль-экологийн хамгаалалтын хил (санал)
- Зураг 11. Хархорины аялал жуулчлалын бүс
- Зураг 12. Хархорины аялал жуулчлалын дэд бүсүүд
- Зураг 13. Дэлхийн Өв - ОХСДГ
- Зураг 14. Тусгай хамгаалалттай газар нутаг
- Зураг 15. Онцгой хамгаалалтын бүс
- Зураг 16. Хархорины аялал жуулчлалын бүсийн цөм Хархорин хот, дагуул хот суурингууд, таталцлын хүрээ

Зураг 1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал



Зураг 2. Хангайн бүсийн бүлэг суурингийн тогтолцоо



Зураг 3. Архангай, Өвөрхангай аймгуудын бүлэг суурингийн тогтолцоо






Зураг 4. Хархорины аялал жуулчлалын бүсийн бүлэг суурингийн тогтолцоо




Зураг 5. Хархорины аялал жуулчлалын бүсийн жуулчдыг татах чадвар бүхий нөөц, зорих газрууд




Зураг 6. Хархорины аялал жуулчлалын бүсийн түүх, соёлын аялал жуулчлалын маршрут. 2008-2018 он


**ХАРХОРИНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
БҮСИЙН ТҮҮХ, СОЁЛЫН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТ. 2008-2018 ОН**



Зураг 7. Хархорины аялал жуулчлалын бүсийн түүх, соёлын аялал жуулчлалын маршрут. 2019-2028 он




Зураг 8. Хархорины аялал жуулчлалын бүсийн байгалийн аялал жуулчлалын бүсийн маршрут. 2008-2018 он




Зураг 9. Хархорины аялал жуулчлалын бүсийн байгалийн аялал жуулчлалын бүсийн маршрут. 2019-2028 он


**ХАРХОРИНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
БҮСИЙН БАЙГАЛИЙН АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТ. 2019-2028 ОН.**



Зураг 10. Хархорины аялал жуулчлалын бүсийн байгаль-экологийн хамгаалалтын хил (санал)




Зураг 11. Хархорины аялал жуулчлалын бүс







Зураг 12. Хархорины аялал жуулчлалын дэд бүсүүд



Зураг 13. Дэлхийн Өв – ОХСДГ




Зураг 14. Тусгай хамгаалалттай газар нутаг





Зураг 16. Хархорины аялал жуулчлалын бүсийн цөм Хархорин хот, дагуул хот суурингууд, таталцлын хүрээ



## ГУРАВ. ХАВСРАЛТ

### 3.1. Судалгаа, үнэлгээ

#### 3.1.1. Дэлхийн хандлага

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага WTO-ийн 2007 онд гаргасан тайланд тусгагадсанаар дэлхийн аялагчид аяллын шинэ атрактивүүдийг хайж байгаа тухай дурьдаад энэ хэрэгцээг нь орон бүрийн өвөрмөц соёлууд ихээхэн хангаж буй талаар дурьджээ.

Энэ нь Монгол гэх мэт өвөрмөц соёл бүхий улс орнууд сонирхол татахуйц зорих газруудын тоонд багтах боломжтойг харуулж байна.


#### 3.1.2. Салбарын бүтэц

Аялал жуулчлалын салбарын ерөнхий бүтэцийг бүдүүвч хэлбэрээр зургалбал доорх схем үүснэ.



Дээрх схемээс аялал жуулчлалын салбар нь хэд хэдэн өөр салбартай нягт уялдаатай нь тодорхой харагдана. Тухайлбал олон улсын агаарын болон төмөр замын тээвэр зуучлал, зорих газар бүхий улс орны тээврийн үйлчилгээ, зочид буудал, хоол, амралт зугаалга, дэлгүүр гээд үйлчилгээний бүхий л салбартай хослон хөгждөг байна.

Аялал жуулчлалын салбарын оролцогчдыг тоймлон үзвэл дараах дүр зураг бий болно.



Салбарын бүтцэд дэд хэсгүүдээс үзүүлэх нөлөөллийг сайжруулах, эерэгжүүлэх замаар салбарыг хөгжүүлэх талаархи баримтлал гарах учиртай.

- **Тур операторууд:** Хөтөлбөрт хамрагдаж байгаа зорих газрууд, татах чадвар бүхий нөөцүүдийн талаархи мэдээллийг нэгтгэн операторуудын дунд нээлттэй хэлэлцүүлэг зарлаж сурталчилгааны тендер шалгаруулах. Энэ нь салбарын хөгжилтэй тэдний үйл ажиллагааг уялдуулах үндсэн арга зүй болох.
- Холбогдох төрийн байгууллагуудын оролцоотойгоор эрх зүйн орчинд шинэчлэл хийх. Тухайлбал татварын, байгаль орчны хамгаалалт, бүс нутаг дахь газрын асуудал, уул уурхайн олборлолт, нөхөн сэргээлт, бүсийн хот, суурин газруудын барилгажилт, хогны менежмент, ундны цэвэр ус, бүсийн дотоод зам, бүсэд байх нэг өрхийн маллах малын тоо толгой зэрэг асуудлуудыг нарийвчлан тусгасан бүсэд баримтлах дүрэм журмууд, холбогдох хууль эрх зүйн актуудыг боловсруулан гаргах.
- Тээврийн үйлчилгээний байгууллагуудтай хамтран дараах ажлуудыг шат дараатайгаар хийж хэрэгжүүлэх. Үүнд:
  - Олон улсын нислэг болон төмөр замын тээврийн үйлчилгээний байгууллагууд болон тур операторуудыг холбон тэдгээрийн мэдээлэл сурталчилгааг хооронд нь уялдуулах.
  - Бүсийн дотоод тээврийн үйлчилгээг зөвхөн тогтсон замаар хийдэг болох. Аялал жуулчлалын үндсэн замуудыг батлан тогтоох. Үүнийг тодорхой тооны постууд дээрх шалгалтаар хянадаг болох. Бүсийн хил хязгаарыг нарийн баримтлах.
  - Зөвхөн аялал жуулчлалын бүсийн дотоод үндсэн маршрутын дагуу авто тээврийн хэрэгсэлээр зорчих. Батлагдаагүй болон засмал замгүй газраар ердийн хөсгөөр зорчдог байх.

Дээрх асуудлуудыг шийдвэрлэснээр бүсийн экологийн эмзэг байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх, тэнцвэрийг алдагдуулахгүй байх боломжтой.

- Хэвлэл мэдээлэл: Монгол улсын тухай
- Үйлчилгээний байгууллагууд
- Үзвэр, үзүүлбэрүүд
- Зорих газрууд

### 3.1.3. Салбарын SWOT шинжилгээ

Хүснэгт 9.

Давуу тал	Сул тал
1. Зорих газаруудын хувьд харьцангуй шинэ, хангалттай тооны 2. Дэлхийд нүүдлийн соёлын өвийг цогцоор нь өдийг хүртэл хадгалж үлдсэн 3. Байгалийн 4 бүс бүслүүрийг дамжин аялах боломжтой өргөн уудам, хот суурингүй газар нутаг <ul style="list-style-type: none"> <li>- Авто аялал</li> <li>- Түүхийн аялал зохион байгуулах боломжууд</li> </ul>	1. Тур оператор компаниудын санхүүгийн чадамж сул энэ нь тэдний гадаад дахь мэдээлэл сурталчилгааны ажилд нөлөөлдөг. 2. Авиа компаниудын нислэгийн чиглэл, тоо цөөн 3. Нийслэл хотдоо үндэсний амралт зугаалгын бүсгүй, үйлчилгээний салбарын хөгжил сул 4. Улс орны дэд бүтцийн хөгжил сул 5. Зорих газруудад байрлах суурин газруудын хөгжил тааруу 6. Зорих газар дахь үзмэрийг хадгалах,

<b>Боломж</b>	<b>Аюул</b>
<p>1. Хөтөлбөрт хамрагдаж байгаа бүс нутаг нь “Дэлхийн-Өв”-д бүртгэгдсэнийг ашиглан мэдээлэл сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэн дэлхийн олон орны жуулчдад хандах боломжтой</p> <p>2. “Чингис хаан” нисэх буудлыг дамжин өнгөрүүлэх болон бусад олон улсын агаарын тээврийн компаниудын онгоц буулгах техникийн нөхцлийг бүрдүүлэн энэ талаархи гэрээ хэлцлүүдийг хийж хэрэгжүүлэх.</p> <p>3. Нүүдэлчдийн соёлын зан үйлүүдийг сурталчлах боломжтой. Энэ нь аялал жуулчлалын сүүлийн үеийн хандлага болох аялагч өөрөө оролцдог хэлбэрийг хангах бүрэн боломжтой. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гэр барих</li> <li>- Нүүдэл хийх</li> <li>- Айраг хийх</li> <li>- Хонь хяргах</li> <li>- Эсгий хийх г.м</li> </ul> <p>4. Нүүдэлчдийн баяр наадмуудыг жуулчдад зориулсан үзвэр, үзүүлбэр болгон хөгжүүлэх боломжтой</p>	<p>хамгаалах асуудал орхигдсон</p> <p>7. Салбарын мэрэгжлийн боловсон хүчний бэлтгэл, хангалт муу</p> <p>1. Хил залгаа БНХАУ бол Монгол улс руу дамжин жуулчлах томоохон орон юм. ӨМӨЗО-ны соёлын өвийн хувьд ижил төстэй байдал нь жуулчдыг хуваах талтай.</p> <p>2. Хөрш БНХАУ, ОХУ-уудын аялал жуулчлалын салбартаа оруулж буй хөрөнгө оруулалт болон томоохон атрактивүүдийг бүтээн босгож байгаа байдал.</p> <p>3. Монгол улсын хүнсний нөхцөл байдал импортоос хараат тул жуулчдын хүнсний аюулгүй байдалд муу нөлөөтэй</p>

### 3.1.4. Тур операторуудын үйл ажиллагааны талаарх шинжилгээ

Манай улсын аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг тур операторууд дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлдэг байна. Үүнд:

- Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх бүрдүүлэх, сурталчилах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулах
- Виз авахтай холбогдсон болон аялалын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх
- Онгоц, төмөр зам болон тээврийн хэрэгслээр зорчих билет /тийз/-ийн бүрдүүлэлт хийх
- Зочид буудал, жуулчны бааз, байр, үзвэрийн захиалга хийх

Үйл ажиллагаагаа эрхлэхдээ жуулчинтай байгуулсан гэрээний дагуу үйлчилдэг бөгөөд гэрээнд дараах ерөнхий зүйлс тусгагддаг байна. Үүнд:

- Талуудын албан ёсны нэр, хаяг, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, банкны дансны дугаар
- Жуулчдын бүрэлдэхүүн, аяллын хөтөлбөр, тэдгээртэй холбогдсон мэдээлэл
- Аялал жуулчлалын бүтээгдэхүүний чанар, үнэ, түүнийг төлөх журам



- Аяллын хугацаа, жуулчдыг угтах, үдэх журам, талуудын эрх үүрэг
- Жуулчдаас үйлчилгээний талаар гомдол гаргах, маргааныг хянан шийдвэрлэх журам
- Гэрээний үүргийг гүйцэтгэх, гэрээг цуцлах, өөрчлөх, хүчин төгөлдөр бус гэж тооцох зэргийг тусгадаг байна.

Одоогоор улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй тур оператор болон тур агент ангиллаар 285 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг байна.

Орон нутагт хийсэн судалгааны 2-р шат нь тухайн бүс нутаг дахь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, зорих газруудын татах чадвар, нөөц, аялал жуулчлалын дэд бүтцийг тодорхойлох зорилгоор хийгдсэн болно.

Тус судалгааг үндэслэн Хархорин хот орчмын бүс нутгийн аялал жуулчлалын маршрут, жуулчдын үйлчилгээ болон дэд бүтцийг төлөвлөх боломжтой болох юм.

Нөгөө талаас тур оператор компаниуд нь аяллын маршрут зохиохдоо жуулчны баазуудыг түшиглэн гаргаж байгаа нь аялал жуулчлалын олон төрлийн маршрут гаргах боломжгүй байгаагийн дээр бусад бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд ч эерэг нөлөө үзүүлж чадахгүй байгаа явдал юм.

Хархорин хот нь аялал жуулчлалын бүс нутгийн төв боловч одоогоор Хархорин хотод жуулчдад зориулсан үйлчилгээ бараг байхгүйн дээр тус хотод жуулчид саатахгүй байна. Хангайн нурууны бүс нутагт ирж буй бараг бүх жуулчин Хархорин хотоор дайран өнгөрдөг боловч тэнд буудаллан үйлчилгээ авч байгаа жуулчид бараг байхгүй байна гэж ойлгож болохоор байна.

Хархорин орчмын бүс нутагт зорих газар, аялал жуулчлалын нөөц, жуулчны баазууд зэргийг тусгайлан судалж үнэлгээ өгсөн болно. Үнэлгээ өгөхдөө дэд бүтэц, татах чадвар, алслалт зэргийг харгалзан үзлээ.

Зорих газар, татах чадвар бүхий нөөцүүдийг байгалийн үзэсгэлэнт газрууд болон түүхийн дурсгалт газрууд гэж тодорхойлон авч үзсэн болно. Мөн аялал жуулчлалын бүтээгдэхүүнд тодорхой үечлэлтэй зохион байгуулдаг үзвэр, үзүүлбэрүүдийг оруулсан байна.

### ***Зорих газар***

Зорих газар нь одоогоор жуулчдын сонирхлыг татдаг, жуулчид очиж байгаа газрууд болон түүнийг түшиглэн аялал жуулчлалын баазууд байрласан, зарим тохиолдолд төлбөртэй үйлчилгээ үзүүлж байгаа газруудыг авч үзсэн.

### ***Татах чадвар бүхийн аялал жуулчлалын нөөц***

Татах чадвар бүхий аялал жуулчлалын нөөцөд одоогоор жуулчид тэр бүр очдоггүй боловч сонирхол татахуйц байгалийн үзэсгэлэнт газрууд болон түүхийн дурсгалт газруудыг оруулсан.

### ***Жуулчны бааз***

Тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазуудыг судалсан болно. Жуулчны баазуудыг байршил болон хүчин чадал зэргээр нь харьцуулан судлахын зэрэгцээ жуулчдад үзүүлж байгаа нэмэлт үйлчилгээнүүдийг ч авч үзсэн.

Орон нутагт хийсэн хоёр дахь судалгааны тайлангийн зорилго нь Хархорин хотыг дайран өнгөрөх болон Орхоны хөндийн бүсийн аялал жуулчлалын маршрутыг нарийвчлан судлах, тур оператор компаниудтай хамтран ажиллах замаар боломжит шинэ маршрутыг боловсруулах гэж тодорхойлон судаллаа.

Хархорины аялал жуулчлалын бүсэд аялж байгаа жуулчид нь Хархорин хотыг дайран өнгөрөхдөө шаардлагатай түвшинд үйлчилгээ авч чадахгүй байна гэж үзэж болно.

Дээрх жуулчдын тоо болон авах үйлчилгээний чиглэлийг тодорхой болгосноор хот төлөвлөлтөд тусгах боломжтой болох юм.

Мөн тус бүс нутагт байгаа жуулчдын зорих газар болон, татах чадвар бүхий байгалийн үзэсгэлэнт газрууд, түүхийн дурсгалт газруудыг тодорхойлох, жуулчны баазуудын нийт хүчин чадлыг тооцсоноор Орхоны хөндийн бүс нутагт аялах жуулчид хүлээн авах өнөөгийн нийт хүчин чадлыг тодорхойлох, үр ашигтай маршрутыг боловсруулахад ач холбогдолтой юм.

### 3.1.5. Хархорины аялал жуулчлалын бүсийн жуулчдын зорих газруудын үнэлгээ

Хүснэгт 10.

Сум	Зорих газрууд	Татах чадвар	Жуулчдад зориулсан үйлчилгээ	Дэд бүтэц	Үндсэн маршрутад хамрагдах боломж	Бүтээгдэхүүний талаарх мэдээллийн хүртээмж
Хужирт	Хужиртын амралт сувиллын төв	5	5	5	3	3
Бат-Өлзий	Улаан цутгалан	5	4	3	4	4
	Төвхөн хийд	5	2	2	5	5
Хархорин	Эрдэнэзуу хийд	5	3	5	5	5
	Хархорум хотын туурь	4	1	5	5	3
Хотонт	Уйгарийн хар балгас	5	1	2	2	4
Өгийнуур	Өгий нуур	5	4	4	5	5
Хашаат	Хөшөө цайдам түүхийн дурсгал	4	3	5	5	3
Уянга	Хүйсийн найман нуур	5	4	3	4	4

### 3.1.6. Хархорины аялал жуулчлалын бүсийн татах чадвар бүхий нөөцүүдийн үнэлгээ

Хүснэгт 11.

Сум	Татах чадвар бүхий нөөцүүд	Татах чадвар	Жуулчдад зориулсан үйлчилгээ	Дэд бүтэц	Үндсэн маршрутад хамрагдах боломж	Бүтээгдэхүүний талаарх мэдээллийн хүртээмж
Хужирт	Хүрлийн үеийн дөрвөлжин булш	3	1	4	4	1
	Хүрлийн үеийн хөшөө	1	1	2	2	1
	Хөндлөн булгийн рашаан	3	1	2	3	1
	Хаалган дэнжийн бугат хясаа	3	3	3	4	1
	Үүртийн тохой	3	1	3	4	2
	Дулааны хуурай Сэрвэнгийн хүн чулуун увшхай	2	1	2	2	1
	Цагаан залаат зуслан	3	2	2	3	2
Бат-Өлзий	Цагаан голын хүрхрээ	3	3	3	4	3
	Хустын рашаан	3	1	3	4	1
	Тэмээн чулуу	3	1	2	3	1
	Өвөр агуйтын хиргисүүр	3	1	3	3	1
	Хойд агуйтын хиргисүүр	5	1	3	3	1
	Могойтын рашаан	4	2	2	4	2
	Хятруун	3	1	2	2	2
	Алаг толгой	2	1	2	2	1
	Хоргой хүрэм	3	1	2	2	2
	Орхоны бага хүрхрээ	3	1	2	3	2
Хархорин	Мэлхий чулуу	2	1	4	4	2
	Эрхтэн чулуу	3	1	4	4	2
	Шанхын хийд	2	1	4	2	2
	Бүүдэн хөшөө	2	1	3	2	1
	Орхон-7	2	1	3	3	1
	Хөшөөн дэнжийн дурсгал	2	1	3	3	1
	Бага элстэйн дурсгал	1	1	3	3	1
	Мухдагийн амны дурсгал	1	1	3	3	1
	Гүмбийн дэнж	2	1	3	3	1
	Ухны гацааны дурсгал	2	1	3	3	1
	Захын булгийн эртний хотын туурь	2	1	4	3	1
	Бага эрээний хүн чулуу	2	1	1	2	1
	Бумбатын хүн чулуу	2	1	1	3	1
Баянголын амны Уйгарын дурсгал	2	1	3	3	1	
Хотонт	Сумын төвийн бичигт хад	2	1	4	4	1
	Дойт толгойн ордны туурь	2	1	2	3	1

	Цагаан сүмн рашаан	3	3	2	2	3
Өгийнуур	Чилэнгийн балгас	2	1	4	4	1
	Улаан худаг	2	1	4	4	1

### 3.1.7. Хархорины аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа жуулчны баазуудын үзүүлэлт

Хүснэгт 12.

Сум	Жуулчны баазын нэр	Байршил	Гэрийн тоо	Орны тоо	Нэмэлт үйлчилгээ
Хужирт	Хужирт тур	Хужиртын рашаан сувиллын дэргэд	10	40	Морин аялал
	Талбиун	Хаалган дэнжийн бугат хясааны дэргэд	15	40	Байхгүй
Бат-Өлзий	Хашхан	Бага хүрхрээний дэргэд	15	45	байхгүй
	Сүүн далай	3-р баг	10	35	Байхгүй
	Төвхөн	4-р баг, Нарийны ам	20	50	Байхгүй
	Эксплорер Монгол	1-р баг, Орхоны хүрхрээ	15	45	Байхгүй
	Тэнгэрийн хишиг	Бага хүрхрээ	10	40	Байхгүй
	Мөнгөн хүрхрээ	Улаан цутгалангийн дэргэд	20	74	Морин аялал
Хар-хорин	Анар	Орхон голын дээд боолт	34	102	
	Хаан тайж	Орхон голын урд эрэгт	15	60	
	Хархорин тур	Усжуулах доод боолт	38	76	
	Номин	Орхон голын урд эрэгт	6	12	
	Мөнгөн мод	Сүүжийн адагт	30	60	
	Хубилай хаан	Сансар хорооны урд	16	30	
	Хангай тур	Онгоцны буудлын баруун хойно	12	34	
	Өргөө	Онгоцны буудын хойно	40	120	
	Өгөөдэй	Онгоцны буудлын урд	20	75	
	River side	Орхон голын эрэгт	17	51	
	Ханбаян	Онгоцны буудлын баруун талд	15	40	
	Dream Land	Орхон голын бургас	10	55	
	Вояж	Орхон голын урд эрэгт	16	40	
Хотонт	Их хаан Хубилай	Хотонт сумын төвөөс 50 км	20	60	
	Их Жаргалантай	Төвхөн хийдээс 20 км	10	45	
Өгий-нуур	Өгий тур	Өгий нуурын хойд эрэг	10	40	
	Хатан Өгий	Өгий нуурын урд эрэг	14	50	
	Өгий далай	Өгий нуурын зүүн эрэг	12	48	Завиар аялуулах
	Өгий ээж	Өгий нуурын зүүн эрэг	18	50	
Хашаат	Цайдам	Цайдам бригад, Чулуут булан	29	84	
<b>Нийт дүн</b>			<b>497</b>	<b>1501</b>	

**3.1.8. Бүтээгдэхүүний таталцах байдлын шинжилгээ**

- Бүтээгдэхүүний таталцах байдлын анализ
  - Таталцах бүтээгдэхүүнүүдийн төрөл, ангилал, хоорондын зайн өгөгдлөөр таталцах боломж бүхий хоёр бүтээгдэхүүний таталцлын хүчийг үнэлэх.
  - Бүтээгдэхүүнүүдийн хоорондын таталцлын хүчийг ашиглаж нэг менежментэд оруулах боломжид анхан шатны дүгнэлт хийх.
- Татах чадвар бүхий нөөцийн бүтээгдэхүүнтэй таталцах байдалын анализ
  - Татах чадвар бүхий нөөцүүдийн бөөгнөрөл, ойролцоо байрших байдлыг нь ашиглан үндсэн болон дайран өнгөрөх маршрутын тодорхой цэг дээрх дэд өртөө үүсгэх боломжийг үнэлэх.

Таталцах чадварын томъёо:

$$(S_1 \cdot \delta_1) + (S_2 \cdot \delta_2) = \beta$$

$S_1$  – Зорих газарт байх бүтээгдэхүүн рүү ойролцоо байх жуулчны баазаас хүрч очих зайн коэффициент

$\delta_1$  – Баазын тохь тухын коэффициент

$S_2$  – Жуулчлалын маршрутын төв замаас хазайж очих зайн коэффициент

$\delta_2$  – Бүтээгдэхүүний татах чадварын коэффициент

$\beta$  – Татах чадварын илэрхийлэл

$S_1$  - Зорих газарт байх бүтээгдэхүүн рүү ойролцоо байх жуулчны баазаас хүрч очих зайн коэффициент

Хүснэгт 13.

Зай	100-300 м	300-500 м	500-700 м	700-900 м	1 км-ээс дээш
Харгалзах коэффициент	5	4	3	2	1

$S_2$  – Жуулчлалын маршрутын төв замаас хазайж очих зайн коэффициент

Хүснэгт 14.

Зай	1-3 км	3-5 км	5-7 км	7-9 км	10 км-ээс дээш
Харгалзах коэффициент	5	4	3	2	1

Хүснэгт 15.

№	Зорих газрууд	$S_1$	$\delta_1$	$S_2$	$\delta_2$	$\beta$
1	Хужиртын рашаан	5	5	5	5	50
2	Улаан цутгалан	5	4	1	5	25
3	Төвхөн хийд	1	4	5	5	29
4	Уйгарын хар балгас	3	1	1	5	8
5	Өгий нуур	5	4	5	5	45
6	Культегин, Билгэ хааны бичигт хөшөө	5	5	5	4	45
7	Эртний Хархорум хотын туурь	5	5	5	4	45
8	Эрдэнэ зуу хийд	5	5	5	5	50

$$\lambda = \beta + (S_3 \cdot \text{Харьцах коэффициент})$$

Хүснэгт 16. Харьцах коэффициент

	Түүх	Соёл	Эмчилгээ	Байгаль
Түүх	3			
Соёл	2	3		
Эмчилгээ	1	1	3	
Байгаль	2	2	2	3

$S_3$  – Зорих газар татах чадвар бүхий нөөц хоорондын зайн коэффициент

Хүснэгт 17.

Зай	5 хүртэл	5-15 км	15-25 км	25-35 км	35-с дээш
Харгалзах коэффициент	5	4	3	2	1

**Зорих газар болон түүний эргэн тойрон дахь татах чадвар бүхий нөөцүүд тэдгээрийн таталцалд хийсэн шинжилгээ**

Хүснэгт 18.

Зорих газар	Ойролцоо байх нөөцүүд	Бүтээгдэхүүнээс нөөц хүртлэх зай	Төрөл	$\lambda$	Тайлбар
Хужиртын рашаан /эмчилгээ/	Хүрэлийн үеийн дөрвөлжин булш /Шунхлай уулын урд энгэрт/	2 км	Түүх	55	Хүрлийн үеийн дөрвөлжин булш, Хүрлийн үеийн хөшөө, Хүн чулуун увшхай, Хаалган дэнжийн бугат хясаа нь Хужирт зорих газрыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд бүлэг сонирхолтой газар юм. Үүртийн тохой, Хөндлөн булгийн рашаан, Хужиртын рашаан нь нэг менежментэд орох боломжтой нөөцүүд болно. Хужирт атрактивийг гадаадын жуулчдад сурталчилах бол Бат-Өлзий сумын нутагт буй Хустын рашааныг мөн адил нэг менежментэд оруулах хэрэгтэй юм.
	Хүрэлийн үеийн хөшөө	7 км	Түүх	54	
	Хөндлөн булгийн рашаан	4 км	Эмч	65	
	Хаалган дэнжийн бугат хясаа	34 км	Бай	54	
	Үүртийн тохой	37 км	Эмч	53	
	Дулайн хуурай Сэрвэнгийн хүн чулуун увшхай	40 км	Соёл	50	
Улаан цутгалан /байгаль экологийн/	Цагаан голын хүрхэрээ	38 км	Бай	28	Цагаан голын хүрхэрээ, Хустын рашаан, Улаан цутгалан гурав нь нэг менежментэд орох өндөр боломжтой юм. Байгалийн үзэсгэлэнт байдлаараа дотоод гадаад жуулчдыг татах боломжтой. Тэмээн чулуу, Өвөр агуйт, Ар агуйтын хиригсүүрүүд нь нэгдэх боломжтой.
	Хустын рашаан	36 км	Эмч	27	
	Тэмээн чулуу	33 км	Түүх	27	
	Өвөр агуйтын хиригсүүр	25 км	Түүх	31	
	Ар агуйтын хиригсүүр	55 км	Түүх	27	
Уйгарын	Сумын төвийн	17 км	Түүх	17	

хар балгас /түүхийн/	бичигт хад				
	Дойтын туурь	15 км	Түүх	20	
Өгий нуур /байгаль экологийн/	Чилэнгийн балгас	3 км	Соёл	55	Өгий нуур орчмын нөөцүүд нь зорих газартайгаа таталцах чадвараар муу болно. Хоёр томоохон нөөц болох Ором гэгээнтний хийд болон Монголын нийслэлийн туурь зэрэг нь дотоодын жуулчдын хувьд татах чадвар агуулах боловч гадаадын жуулчдад сонирхолтой үзмэр болж чадахгүй юм.
	Улаан худаг	15 км	Түүх	51	
Эртний Хархорум хотын туурь /түүхийн/	Чингис хааны хар сүлдийн хадгалж байсан газар босгосон дурсгалын гэрэлт хөшөө	22 км	Түүх	54	Чингис хааны хар сүлдийг хадгалж байсан газар нь Монголчуудын хувьд сонирхолтой юм. Гадаад жуулчдын хувьд түүхэн талаасаа ач холбогдол багатай бөгөөд мөн тухайн газар босгосон ганц хөшөөнөөс өөр үзмэргүй юм.
Эрдэнэ зуу хийд /соёлын/	Шанхийн хийд	24 км	Соёл	59	Шанхийн хийд нь Төвхөн хийдтэй он тооллын хувьд нэг үед байгуулагдсанаараа онцлог боловч Төвхөн хийд шиг татах чадварыг агуулаагүй байна.

### Зорих газрууд болон таталцлын үнэлгээ

Хүснэгт 19

№	Зорих газрууд	β	Тайлбар
1	Хужиртын рашаан	50	Хужиртын рашаан нь дотоодын жуулчдын хувьд хөтөлбөрийн бүсэд орших томоохон атрактив юм. Гадаадын жуулчдыг татахын тулд үйлчилгээнийхээ зэрэглэлийг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай. 1926 оноос эрдэм шинжилгээний түвшинд судлаж эхлээд 1941 онд амралт сувиллын цогцолборыг барьж байгуулжээ. Жилд дундажаар 2000-2500 орчим амрагчид үйлчлүүлдэг. Энэ нь барилга байгууламж болон Монгол төрхийг агуулсан орчин зэргээс эхлээд олон талаараа аялал жуулчлалын татах чадварыг нь нэмэгдүүлэх шаардалагтай.
2	Улаан цутгалан	25	Орхон голын нэг цутгал Улаан гол дээрх хүрхрээ нь тектоникийн хөдөлгөөний нөлөөгөөр хөндийд үүссэн хагарлын тогоонд 24 м өндрөөс унаж, хагарлын гольдролыг дагаж урсдаг бөгөөд дэлхийн бусад алдартай хүрхрээ, усны унацуудтай харьцуулбал гадаадын жуулчдын хувьд татах чадвар бага юм.
3	Төвхөн	29	Төвхөн хийд рүү зорьж очих дотоодын болон гадаадын жуулчдын сонирхлыг хийдийн байршил нь татдаг нь судалгаагаар тогтоогдсон байна. Хийдийн талаарх мэдээлэл сурталчилгааг өндөр түвшинд боловсруулан тур компаниудын нэгдсэн симпозиумаар хэлэлцүүлэх шаардлагатай. Энэ нь хийдийн соёлын болон түүхийн талаас нь ч мэдээллийн агууламжийг нь өндөржүүлэх үнэ цэнийг нь нэмэгдүүлэх ач холбогдолтой. Мөн байгалийн үзэсгэлэнт газар байрших тул энэ онцлогыг нь ч багтаах нь зүйтэй юм.

4	Уйгарын хар балгас	8	Орхоны хөндийд үе үед хүчирхэгжин өөрийн хот сууринг байгуулж байсан түүхт улсуудын нэг болох Уйгарын эртний хотын туурь хөтөлбөрт хамрагдаж байгаа Хотонт сумын нутагт, сумын төвөөс холгүй байршдаг. Хот МЭ 761 онд Уйгарын хаан Тейлогийн ордон нэртэйгээр сууриа тавьжээ. Хотын тогтоц түүний үлдэцээс үзвэл 5x10 км, хааны ордон нь 412x491 м хэмжээтэй байсан гэж тогтоожээ.
5	Өгий нуур	45	Өгий нуур нь байгалийн өвөрмөц тогтоцтой гэдгээрээ онцгой боловч нуур орчмын жуулчны баазууд нэгдсэн менежментэд ороогүй харин ч нуурийн ай савын экологийн тэнцвэрт муугаар нөлөөлж болохуйцаар (нуурыг тойрон) байршсан. Нуурын нэг томоохон нөөц бол 14 зүйлийн загас юм. Загас агнуур хөгжүүлэх боломжтой.
6	Культегин, Билгэ хааны бичигт хөшөө	45	Орхоны хөндийд байх зорих газруудаас одоогоор хамгийн сайн менежменттэй байгаа нь энэхүү газар болно. Түүхийн дурсгалыг хамгаалсан байгууламжтай. Зорьж очих замтай. Мөн зорих сигменттэй /Турк жуулчид/
7	Эртний Хархорум хотын туурь	45	Эртний Хархорум хотын туурийн хувьд бүрэн судлагдаагүй байгаа бөгөөд үе үеийн экспедиц малтлага хийсээр байна. Энэ нь тухайн түүхийн дурсгалын талаарх мэдээллийн санг өргөжүүлж байгаа сайн талтай боловч эд өлгийн зүйлс алдагдах гадагшаа хил даван гарч байгаа эсэх талаарх хяналт, мэдээлэл орон нутгийн хувьд болон төр засгийн түвшинд сул байна.
8	Эрдэнэ зуу хийд	50	Эрдэнэзуу хийд нь Монголын түүх соёл тухайлбал шарын шашны томоохон дурсгалт байгууламж юм. 1586 онд байгуулагдсан энэхүү байгууламжийн одоогийн менежмент нь түүхийн болон соёлын музей байдалтайгаар ажиллаж байгаа болно.

### Соёлын аялал жуулчлалын нөөцийн байдал

Хүснэгт 20.

Үзүүлэлт	Нөөц	Тайлбар, дүгнэлт
Байгаль газар зүйн сонирхлын бүс нутаг, түүний экологийн өвөрмөц бүрдлүүд	Бат-Өлзий сум: Орхоны хөндий, Могойтын рашаан, Улаан цутгалан, Хустын рашаан, Цагаан голын хүрхрээ, Орхон гол, Хоргой хүрэм, Хятрууны халуун рашаан, Цагаан хад, Хангайн овоо Хужирт сум: Гуа хайрхан, Шунхлай уул, Үүртийн тохой, Хаалган дэнж, Хужиртын рашаан, Хөндлөн булгийн рашаан, Гэндэнгийн ам Хархорин сум: Чулуун зэвсгийн үеийн суурин Өгийнуур сум: Өгий нуур Хотонт: Хотонт хайрхан, Цагаан суваргын рашаан, Өндөр сант хайрхан, Хашаат: Цагаанхад багийн Сэнжит хад,	Орхоны хөндийн сав газар нь Хангайн нурууны ар хэсгийн хамгийн үзэсгэлэнтэй газар байрладаг. Хархорины бүс нутагт нийт 30 орчим байгалийн үзэсгэлэнт тогтоц, газруудтай. Одоогийн байдлаар тур операторууд жуулчдад санал болгож, тэдэнд үзүүлж буй нэр бүхий арван газар байна. Хархорины бүс нутгийн байгалийн үзэсгэлэнт газруудын нөөцийн хэмжээ нь соёлын аялал жуулчлалын хавсрага байдлаар хөгжих, эсвэл энэхүү аялал жуулчлалын төрлийг идэвхижүүлэхэд хангалттай гэж дүгнэхээр байдаг. Цаашдаа соёлын аялал жуулчлалыг Хархорины бүс нутагт хөгжүүлэхэд байгалийн үзэсгэлэнт



		газруудын ашиглалт, хамгаалалтад тусад нь бодлого боловсруулан хөгжүүлэх асуудал тулгамдаад байна. Эдгээр байгалийн үзэсгэлэнт газрууд байршлын хувьд хоорондоо таруу байршилтай. Иймээс Орхоны хөндийн сав газарт аялал жуулчлалд зориулсан тусгай засмал зам, агаарын тээвэр, газрын тээвэр, холбооны өргөн сүлжээг барьж байгуулах шаардлагатай.
Тухайн улс, орон нутгийн үндэсний соёлыг хадгалан тээгч хүн ам	<u>Хархорин сум:</u> Нийт 190 мянган толгой малтай, 680 малчин өрх, 1450 малчинтай. <u>Хужирт сум:</u> Нийт 170 мянган толгой малтай, <u>Бат-Өлзий сум:</u> Нийт 116 мянган толгой малтай, 615 малчин өрх, 1550 малчинтай. <u>Хашаат сум:</u> 210 мянган толгой малтай, 719 малчин өрх, нийт 1554 малчинтай. <u>Хотонт сум:</u> 208 мянган толгой малтай, 1067 малчин өрх, нийт 1828 малчинтай. <u>Өгийнуур сум:</u> 158 мянган толгой малтай, 654 малчин өрх, нийт 1308 малчинтай.	Нүүдлийн соёлыг тээгч хүн болон малчин өрхийн тоо 3500 орчим, нийт малчин хүн амын тоо 6000 орчим байна. Одоогийн энэхүү нөөц нь соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тооны хувьд хангалттай боловч чанарын асуудал дээр сөрөг талууд ажиглагдаж буй юм. Нүүдлийн соёл бол өргөн агууламжтай бөгөөд хоорондоо харилцан адилгүй ястан, угсаатны нэгдэл хэлбэртэй учраас эдгээр 3500 малчин өрх нүүдлийн соёлыг бүрэн тээгчид гэж үзэж болохгүй. Нүүдлийн соёлыг сурталчлах аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд эхлээд бүс нутагт өөр өөр ястнуудыг суурьшуулах хэрэгтэй
Түүх, соёлын дурсгалт газрууд	Уйгарын хар балгас, Хөшөө цайдам, Эрдэнэзуу, Хархорум хотын туурь, Төвхөн хийд, Шанхын хийд, Дойт толгойн ордны туурь, Чилин хийд, Талын дөрвөлжингийн эртний хотын булш, Харбодонгорын эртний хотын туурь, Баянголын амны эртний хотын туурь, Мэлхий толгойн ордны туурь, Захын булгийн хэрэмний туурь, Ханджамцын суварга,	Түүхийн дурсгалт газруудын хувьд Монгол оронд нүүдэлчдийн төрт улс үүсэн бүрэлдсэнээс өнөөдрийг хүртэлх бүх үеийн нийслэл хотууд, дагуул хотуудын туурь Хархорины бүсэд байрладаг. Энэ байдал нь соёлын аялал жуулчлал хөгжихөд чухал нөлөөтэй, үндсэн давуу талыг бий болгодог.
Угсаатны өвөрмөц соёлын илрэлүүд (нутгийн аман аялгуу, бөө мөргөл гэх мэт язгуур соёлын элементүүд)	Уртын дуу, хөөмий; бөө мөргөл; зээ татах; ингэ хөөслөх, хонь тойглох; унага тамгалах; шинэ гэрийн найр, гүүний үрсний найр, олон ястны хурим найр; морь уургалах, бугуйлдах; тэмээ, морь, сарлагийн поло; эрийн гурван наадам; морин хуур; цам харайх ёслол; эсгий хийх; цагаан сар, мөсөн шагайны наадам, мөсний баяр; шагайн	Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нүүдлийн соёлын эдгээр өвөрмөц илэрлүүд хангалттай байгаа хэдий боловч нүүдлийн соёлыг тээгчид нь жинхэнэ уламжлалаа хадгалан үлдэж байгаа тал дээр эргэлзээтэй байна. Түүнчлэн эдгээр соёл, уламжлалыг гадны жуулчидад зориулсан үзүүлбэр, тоглолт, урьдаас төлөвлөгөөтэй, зохион

	харваа; цүү хаях наадгай; шагайн бүх төрлийн наадгай; гэр барих зан үйл; мал хөнгөлөх зан үйл; бөө мөргөлийн дэг ёс; дэмбээ наадгай; бүргэдийн ан; тэмээ түлхэх ан; овоо тахиx зан үйл; хонь ямаа, холбох; гэр мод хийх арга; сур элдэх; тушаа, чөдөр зангидах; домборын тоглолт; ардын бүжиг; чулуу таалцах наадгай; икэлийн тоглолт; ерөөл магтаал; тууль хайлах; нүүдэл хийх; мал хөнгөлөх ёсон, хонь мал хяргах; шашины зан үйл;	байгуулалттайгаар цугларалт, уралдаан, наадмыг зохион байгуулах тал дээр орон нутгийн иргэд, удирдлага болон тур оператор, жуулчны компани хоёрын хамтын ажиллагаа дутагдалтай. Нүүдлийн соёлыг сурталчлан таниулах бүх төрлийн үйл ажиллагаа болон малчдын аж амьдралын байдалтай танилцах аялал зэрэг нь хоорондоо ямар нэгэн хамааралгүйгээр зохион байгуулагддаг.
Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах газрууд	Хархорум хотын туурь, Уйгарын хар балгас, Дойт толгойн ордны туурь, Билгэ ба Культегиний гэрэлт хөшөө, Шанхын хийд, Ханджамцын суварга, Эрдэнэзуу хийд	Эдгээр түүхийн дурсгалт газрууд нь нүүдэлчдийн төр улсын түүхийг өгүүлэх асар үнэ цэнэтэй соёлын өв. Анхаарал татах нэг асуудал бол тэдгээр соёлын өвийг ашиглалт, хадгалалт, хамгаалалт юм. Нөхөн сэргээлт хийх дурсгалт газар маш цөөн байгаа бөгөөд бусдыг шууд хамгаалатад авах хэрэгтэй. Тэгээд дууриамал, жижиг болгосон загварыг нь барьж болно. Түүнчлэн тайлбар, таниулан сурталчлах байр болон тухай дурсгалтай холбоотой зурагт хуудас, ном, сэтгүүл, DVD зэргийн худалдааг хөгжүүлэх.
Язгуур урлагийн төвүүд	Язгуур урлагын тоглолт хийдэг жуулчны баазууд, Соёлын төвүүд	Язгуур урлагын төвүүдийн үйл ажиллагаа хангалттай байж чадахгүй байна. Мөн сумын төвийн соёлын төвүүд тогтмол үйл ажиллагаа явуулдаг, язгуур урлагын тоглолт явуулах хүчин чадалтай хэдий ч тур-операторууд аялагчдыг тэдний тоглолтыг үзүүлэхэд санаачилга гаргадаггүй. Орхоны хөндийд байрлаж байгаа зарим жуулчны баазууд язгуур урлагын тоглолт зохион байгуулж байгаа хэдий ч цөөн төрөлтэй, нүүдлийн соёлын язгуурын урлагыг бүрэн төгс таниулж чадахгүй байгаа.
Үндэсний технологи, гар урлалын төвүүд (уран дархан, баримал, сийлбэр, оёдол, хатгамал, эсгий болон арьсан урлал, хоол хүнс,	Бат-Өлзий сумын гэрийн мод хийдэг цехүүд, Бат-Өлзий сумын цагаан идээний цех, Хархорины гар урлалын худалдаа, үйлдвэрийн газрууд	үндэсний гар урлалд чухал тооцогдох гэр үйлдвэрлэл Хархоринны бүс ялангуяа Бат-өлзий сумын нутагт илүү сайн хөгжсөн. Гэхдээ соёлын аялал жуулчлалд ямар ч нөлөө үзүүлэхгүй байна. Түүнчлэн

орон гэрийн үйлдвэрлэл гэх мэт)		Хархорины бүсэд гар урлалын бусад төрлүүд сул хөгжсөн, олноор үйлдвэрлэн борлуулах систем бүрэлдээгүй.
Театр, концертын танхимууд	Хархорин хотын соёлын төв, Хужирт сумын соёлын төв, Бат-Өлзий сумын соёлын төв, Өгийнуур сумын соёлын төв, Хашаат сумын соёлын төв, Хотонт сумын соёлын төв	Соёлын төвүүдийн үйл ажиллагаа тогтмол биш. Гэхдээ аялал жуулчлалын маршрутад оруулж, тэдний бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлд бодлого боловсруулан хэрэгжүүлэх юм бол үйл ажиллагаа нь богино хугацаанд сэргэх боломжтой.
Соёлын амьдралд онцгой үйл явдал болсон газрууд	Усан цэргийн тохой, Хар сүлдийг хадгалж байсан газар,	Энэ талаарх судалгааг тусад нь хийх шаардлагатай.
Аялал жуулчлалын маршрут	<p><u>Маршрут-1:</u> Хархорин хот, Эрдэнэзуу, Уйгарын хар балгас, Дойт толгойн ордны туурь, Билгэ хааны гэрэлт хөшөө, Хархорин хот;</p> <p><u>Маршрут-2:</u> Хархорин хот, Төвхөн хийд, Уйгарын хар балгас, Дойт толгойн ордны туурь, Талын дөрвөлжингийн ордны туурь, Өгий нуур, Билгэ хааны гэрэлт хөшөө, Хархорин хот;</p> <p><u>Маршрут-3:</u> Хархорин сум, Дулааны хүн чулуу, Шунхлай уулын дөрвөлжин булш, Цуурмал хөшөө, Өвөр агуйт, Тэмээн чулуу, Орхоны эхийн хүч чулуу, Ар агуйт, Дөрвөлжингийн хиргисүүр, Бүүдэн хөшөө, Мойлтын амны хүннү суурин, Мэлхий чулуу, Хархорин хотын туурь;</p> <p><u>Маршрут-4:</u> Хархорин хот, Хужиртын рашаан, Хөндлөн булгийн рашаан, Хустын рашаан, Могойтын рашаан, Цагаан суврагын рашаан, Хятрууны рашаан, Хархорин хот;</p> <p><u>Маршрут-5:</u> Хархорин хот, Эрдэнэзуу, Шанхын хийд, Хужиртын рашаан, Үүртийн тохой, Цагаан голын хүрхрээ, Тэмээн чулуу, Могойтын рашаан, Цагаан хад, Улаан цутгалан, Ар агуйт, Төвхөн хийд, Хархорин хот</p>	
Шашны сүм хийд, хурал номын газрууд	Эрдэнэзуу хийд, Төвхөн хийд, Шанхын хийд, Ганданчойпил хийд	Шашин номын газрууд нь нүүдлийн соёлыг таниулахад чухал нөлөөлөл болохгүй хэдий ч жуулчдыг дорно дахины соёлыг сонирхоход нөлөөлөл болж чадна.
Булш, бунхан, хиргисүр, буган чулуун хөшөө, хадны сүг зураг зэрэг эртний соёлын дурсгалууд	<p><u>Бат-Өлзий сум:</u> Өвөр агуйтын хиригсүүр, Ар агуйтын хиригсүүр, Тэмээн чулууны буган хөшөө, Ширээт уулын буган хөшөө,</p> <p><u>Хужирт сум:</u> Шунхлай уулын хиригсүүр, Дулааны арын хуурай сэrvэнгийн хүч чулуун увшгай, Хаалган дэнжийн бугат хүсаа, Хүрлийн үеийн хөшөө, Бэрх уулын булшууд, Ар бөөрөгийн эртний булшууд, Майхан толгойн дөрвөлжин болон Хүннүгийн булш, Урд сэртэнгийн хадны сүг зураг,</p> <p><u>Хархорин:</u> Бүүдэн хөшөө, Унамал хүн чулуу, Мэлхий чулуун дурсгалууд, Эрхтэн</p>	<p>Орхоны хөндий бол чулуун зэвсгийн суурингаас эхлээд хүн чулуу хүртлэх бүх төрлийн булш хиргэсүүр, хадны сүг зураг, хүн чулуун хөшөө болон бусад түүх, археологийн чухал дурсгалуудтай.</p> <p>Орхоны хөндийн түүх, археологийн дурсгалуудын ашиглалт, хамгаалалтын байдал туйлын эрсдэлтэй нөхцөлд байна. Эртний нүүдэлчдийн төрт улсуудын нийслэл хот, томоохон суурингын дурсгалууд ямар нэгэн харуул, хамгаалалт байхгүй. Түүнээс гадна түүх, археологийн ямар үнэ цэнэтэй зүйл болохын тайлбарлан таниулах ойлгуулах</p>

	<p>чулуу, Мойлтын амны хуучин чулуун зэвсгийн үеийн суурин, Ухны гацаан дахь хуучин чулуун зэвсгийн суурин, Гүмбийн дэнжийн буган хөшөө, Хөшөөн дэнжийн хүч чулуу, Чингис хааны хар тугны дурсгалын хөшөө, Бага эрээний хүн чулуу, Баруун хүрээний анхны туурь, Хиргисүүртэй чулуун хөшөө, <u>Хотонт</u>: Бичигт хөшөө, хүн чулуу, буган хөшөө, Өгөөдэй хааны ордны туурь, <u>Хашаат</u>: Их номгон уулын хирэгсүүр, Их Номгон уулын хүн чулуун хөшөө, Бага Номгон уулын хүн чулуун хөшөө, <u>Өгийнуур</u>: Хэрмийн талын Хубилай хааны шар ордны туурь, Улаанхудаг</p>	<p>самбар, мэдээллийн цэг, тусгай тайлбарлагч байхгүй. Байршлын хувьд авч үзвэл орхоны хөндийн түүх, археологийн дурсгалыг үндсэн гурван бүсэд хувааж болно. Үүнд: <u>-Төв бүс</u>: Хархорин сум <u>-Өмнөд бүс</u>: Бат-Өлзий сум, Хужирт сум <u>-Хойд бүс</u>: Хашаат сум, Хотонт сум, Өгийнуур сум</p>
<p>Орчин үеийн холбоо, мэдээллийн сүлжээ</p>	<p><u>Хархорин сум</u>: Мобиком, Юнитель, Скайтель, Жи-Мобайль, Интернэт, хатуу хучилттай зам <u>Хашаат</u>: Мобиком, Жи-Мобайль, хатуу хучилттай зам <u>Хотонт</u>: Мобиком, Скайтель <u>Өгийнуур</u>: Мобиком, Жи-Мобайль, Интернэт <u>Хужирт</u>: Мобиком, Скайтель, <u>Бат-Өлзий</u>: Мобиком, Жи-Мобайль, Интернэт</p>	<p>Хархорины бүсэд холбооны шугам болон үүрэн телефоны сүлжээний хувьд хангалттай байна. Харин интернэтийн хүртээмжийн хувьд дутагдалтай.</p>
<p>Аялал жуулчлалын орчин үеийн стандартыг хангаж ажиллах чадвар бүхий хүний нөөц</p>	<p>Улсын хэмжээнд үндэсний аяллын зэрэглэлтэй 204 хөтөч тайлбарлагч ажилладаг.</p>	<p>Хархорины бүсэд улирлын чанартай ажилладаг жуулчны баазуудын хувьд мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай. Тур операторуудын хувьд зундаа яг хэдэн мэргэжлийн хөтөч тайлбарлагч ажиллаж байгаа талаар нарийвчилсан мэдээлэл олдоогүй.</p>
<p>Бүс нутаг болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр</li> <li>- Хархорин хотын ерөнхий төлөвлөгөө,</li> <li>- Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын дэд хөтөлбөр</li> <li>- Архангай аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө</li> <li>- Өвөрхангай аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл</li> <li>- Архангай аймгийн нийгэм эдийн засгийн тэргүүлэх</li> </ul>	<p>Хөгжлийн бодлого чиглэл түүн дотроо аялал жуулчлалын салбарын бодлогыг улс, Хангайн бүс, аймаг (Өвөрхангай, Архангай) гэсэн гурван түвшиндээ тодорхойлон гаргасан. Гэхдээ тэдгээр бодлогын баримт бичгийн биелэлт нь хангалтгүй байна.</p>

	чиглэл - Хангайн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэл	
Улс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн дэд бүтэц	Хархорин-Хөшөөцайдам чиглэлд 46 км, Хөшөөцайдам- Өгийнуур чиглэлд 10 км, Хархорин-Хужирт чиглэлд 36.8 км хатуу хучилттай замыг барихаар; Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 130 км хайрган замыг хатуу хучилттай болгох; Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлд 109 км хатуу хучилттай зам барьж эхлүүлэхээр 2007 оны зам гүүрийн ажил нь эхэлсэн. Дээрх замууд баригдаж дуусвал Орхоны хөндийн хувьд авто замын сүлжээтэй аль ч талаараа холбогдсон гэж үзэж болно.	Хархорины бүсийн доторх автозамын хувьд Хархорин Хужирт, Хужирт Бат-Өлзий, Хархорин, Хашаат, Хотонт, Өгийнуур чиглэлүүдэд хатуу хучилттай жуулчлалын зам бариж байгуулах нь хөрсний эвдрэл сүйтгэл, амьтны аймаг, ургамлын зүйлсийг хамгаалахад чухал төдийгүй жуулчдын тав тухыг хангахад тустай юм.

### 3.1.9. Дүгнэлт

Японы JICA байгууллагын 2003 онд хийсэн аялал жуулчлалын судалгаанд Орхоны хөндийн аялал жуулчлалын үйл ажиллагааны түвшинг А зэрэглэлд авсан байна. Энэ нь улсын хэмжээнд аялал жуулчлалын үйлчилгээ илүү хөгжсөн Улаанбаатар Тэрэлж, Говийн бүстэй ижил түвшинд хүрсэн гэсэн утга илэрхийлж байгаа болно. Гэвч аялал жуулчлалын үйлчилгээний нэг хэсэг болох жуулчны баазуудаар судалгаа явуулахад зохих түвшнээс доогуур байгаа нь ажиглагдлаа.

Орхоны хөндийд байрлах жуулчны баазууд нь Монгол гэрээр үйлчилдэг бөгөөд нэг гэрт 2-4 хүн хүлээн авдаг нийтлэг дүр төрх байна. Жуулчны баазуудын үзүүлж байгаа үйлчилгээ нь гэр буудал, хоолны үйлчилгээгээр хязгаарлагдаж байна. Цөөн жуулчны баазууд теннис, волейболын талбай, билльярдаар үйлчилдэг ч энэ жуулчдын хувьд тийм ч оновчтой үйлчилгээ болж чадахгүй.

Морин аялал, завь зэргээр үйлчилгээ үзүүлдэг гэх жуулчны баазууд байх боловч үйлчилгээний хувьд төрөлжөөгүй, нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан байх нь илүүтэй хөгжсөн байна.

Судалгаанд хамрагдаж байгаа 6 сумын нутагт нийт 28 жуулчны бааз 497 гэрээр үйлчилгээ үзүүлж нийт 1501 хүн нэг ээлжиндээ хүлээн авах хүчин чадалтай. Жуулчдад гэр буудлуудын орчин, хэв маяг нь нүүдлийн амьдралын талаар бодит төсөөлөл өгч чаддагаараа онцлогтой.

### 3.1.10. Хархорины аялал жуулчлалын бүсийн зорих газрууд, татах чадвар бүхий нөөцүүдийн үнэлгээний зургууд

**Чиглэл: Түүх, соёлын дурсгал**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Ар агуйтын хиригсүүр нь 13 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Ар агуйтын хиригсүүр нь 27 оноо авсан нь дунд зэргийн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Улаан цутгалан байгалийн үзэсгэлэнт газартай таталцах чадвар

**λ=27**

Улаан цутгалан зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Ар агуйтын хиригсүүр**

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Сумын төвийн зүүн талын жижиг уулын ар болон зүүн бэлээр хиригсүүр 3, дөрвөлжин булш 5, дугуй дараастай булш нэг бий. үүнээс зүүнтээ 100 м-т нэг хиригсүүр, 2 тахилын хашлага бий. GPS 108. Хүний үйлдлээс үүдэлтэй ухагдсан, тоногдсон байдалтай байгаа. Нутгийн иргэдийн хамгаалалтад оруулсан хэдий боловч байнгын айл Ар агуйтын аманд байдаггүй улмаас ингэж сүйтгэгдсэн гэдэг.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзийт сумын төвөөс хойд зүгт 35 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Ар агуйтын хиригсүүрийн цогцолбор нь хэмжээ агуулгын хувьд их, жуулчдын гол замын ойролцоо байрладаг, илүү сонирхол татахуйц давуу талтай юм.

Иймд зурагжуулалт, тэмдэглэлт, үзүүлэн таниулах хэсгүүдийг байгуулах замаар жуулчдын татах чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Бат-Өлзийт сумын нутагт байрлаж буй хиригсүүрээс хамгийн ур хийц сайтай нь гэж үзэж болно. Цаашдаа илүү жуулчдад зориулсан үйлчилгээг нь илүү сайжруулах шаардлагатай.

**Чиглэл:** Түүх, соёлын дурсгал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Бага эрээний хүн чулуу нь 7 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Бага эрээний хүн чулуу 40 оноо авсан нь дундаж үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=40**

Хархорин, Эрдэнэзууг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Бага эрээний хүн чулуу

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Ноёхон толгойгоос зүүн урагш 12 км зайтай Бага Эрээн уулын зүүн урд үзүүрт, Сарын голын баруун биед энэ дурсгал оршино. Хөх саарал өнгийн урт гонзгой занар чулууны нэг үзүүрт хүний нүүрийн дүрс гарган сийлснээс өөр дүрслэлгүй хүн чулуу хэвтээ байдалтай байдаг. Өндөр нь 132 см, өргөн нь 45 см, зузаан нь 22 см ажээ. Хөшөөны хойд талд зургаан метр зайд эрт цагт малтаж хонхойлсон нүхний ором бий. Уг хөшөөг босгож тавибал бороо цас орж тэнгэр муухайрдаг гэсэн домог яриа нутгийнхны дунд яригддаг. Энэ хүн чулууг 1989 онд судлан шинжлэн үзэхэд хийц загварыг үндэслэн түрэгийн үед холбог-дуулан үздэг.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төвөөс зүүн өмнө зүгт 30 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Багаа эрээний хүн чулууг жуулчдын дайран өнгөрөх үндсэн маршрутд хамруулан ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн тогтолцоог боловсронгуй, эдийн засгийн үр өгөөжтэй болгох шаард-лагатай.

Ингэснээр дунд хугацаанд жуулчдын дайран өнгөрч, үзэж сонирхох боломжтой газар болох боломжтой.

**Чиглэл: Түүх, соёлын дурсгал**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Баянгол-ын амны дурсгал нь 10 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр тус дурсгал нь 55 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин хотын туурь, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=55**

Хархорин хотын туурийг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Баянголын амны Уйгурын дурсгалт газар**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хархорины сумын нутаг, Баянголын амны Уйгурын дурсгал нэн сонирхолтой түүхийн баримтуудыг агуулсан дурсгал юм. Уйгарын үеийн язгууртны шарил болон түүний эдлэл хэрэглэл энэ газраас олдсон. Тус дурсгалд Уйгурын үеийн нүүдэлчдийн соёл, зан заншил болон бусад орны соёлтой ямар хэмжээнд соёлын солилцоонд орж байсныг харуулсан олон чухал дурсгалууд энэ газраас олдсон. Орхоны хөндийд байгаа өөр бусад хиригсүүрүүдэд төдийлөн тааралдаагүй өвөрмөц байдлаар язгууртныг оршуулсны дээр бунханы дотор ханыг уран нарийн хээгээр чимгэлсэн зэрэг Баянголын амны дурсгалыг үнэ цэнийг улам өндөр болгодог.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төвөөс баруун хойд зүгт 10 км-т байрладаг



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Баянголын амны Уйгурын дурсгал нь бүрэн хэмжээнд судлагдсан давуу тал дээр тулгуурлан ил музей, хамгаалалтын байгууламж, танилцуулгын самбар, байнгын харуул хамгаалалт, машины зогсоол, амрах байр, худалдаа, үйлчилгээний цэг, жуулчид зураг авах тавзан зэргийг хийж гүйцэтгэх шаардлагатай. Хэрвээ дээрх бүтээн байгуулалтуудыг хийснээр тус дурсгалт газар нь Хархорины бүсийн нэгэн томоохон жуулчдын зорих газар болох боломжтой.



**Чиглэл:** Түүх, соёлын дурсгал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Бумбатын өврийн хүн чулуу нь 8 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Бумбатын өврийн хүн чулуу 50 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=50**

Хархорин, Эрдэнэзууг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Бумбатын өврийн хүн чулуу

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Сарын голын зүүн эрэг Бумбат хэмээх хадтай толгойн өвөрт /Ноёхон толгойгоос урд зүгт 12 км зайтай/ буй хүн чулуун дэнжийг нутгийнхан Хөшөөн дэнж гэж нэрлэдэг. Энэ дурсгал газарт 170 гаруй см өндөр хоёр босоо чулуу нэг гозгор чулуу, газарт хэвтээ гурван урт чулуу, нэг хүн чулуутай. Боржингоор урласан уг хүн чулууны өндөр буюу урт нь 173 см, өргөн нь 40 см, зузаан нь 38 см.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төвөөс зүүн өмнө зүгт 20 км-т байрладаг.




**ЦААШДЫН БОЛОМЖ**

Бумбатын өврийн хүн чулууг жуулчдын дайран өнгөрөх үндсэн маршрутд хамруулан ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн тогтолцоог боловсронгуй, эдийн засгийн үр өгөөжтэй болгох шаардлагатай. Ингэснээр дунд хугацаанд жуулчдын дайран өнгөрч, үзэж сонирхох боломжтой газар болох боломжтой.

**Чиглэл: Түүх, соёлын дурсгал**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Чилэнгийн балгас нь 12 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр тус дурсгал нь 55 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Өгийнуур ба сумын төвтэй таталцах чадвар

**λ=55**

Өгийнуурыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Чилэнгийн балгас**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Орхон голын баруун эрэг, Өгийнуур сумын төвөөс зүүн хойш 5 км орчимд Уйгурын үеийн Чилэнгийн балгас бий.

Чилэнгийн балгас бол Өгийнуурын баруун хойд талд орших бөгөөд нуурын цутгал болон сэлгээ голуудын хооронд эргэн тойрон жижиг нуур, ус намгархаг газруудаар хүрээлэгдсэн үзэсгэлэнт цэгт оршдог.

**БАЙРШИЛ:**

Архангай аймаг, Өгийнуур сумын төвөөс зүүн тийш звгт 7 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Түүхийн үнэт дурсгал, байгалийн болон шинжлэх ухааны аялал жуулчлал гэсэн гурван төрлийн жуулчлал хөгжүүлэх нөөц бүхий газар бол Чилэнгийн балгас юм.

Ойрын хугацаанд түүх, археологийн чиглэлийн судалгаа хийх түүхийн хувьд ямар баримт сэлт байгааг тодруулах чиглэлд ажлуудыг хийх шаардлагатай.

Ингэсэн нөхцөлд шинжлэх ухааны аялал жуулчлалын хөгжилтэй уялдан түүхийн үнэ цэнэтэй давуу тал дээрээ тулгуурлан Өгийнуурыг бичил бүсийн том татах төв болох боломжтой.

**Чиглэл: TVVX СОЁЛЫН ГАЗАР**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчлалын нөөцийн үнэлгээгээр Дойт толгойн ордны туурь нь 9 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Дойт толгойн ордны туурь 27 оноо авсан нь дунд зэргийн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт ихээр шаардах сул талтай.

Уйгарын хар балгасатай таталцах чадвар

$\lambda=20$

Уйгарын харбалгасыг зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Дойт толгойн ордны туурь**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хар балгасаас баруун хойш 10 гаруй км-т Шорвог нуур, Хунт нуур, Дойт нуур, Цагаан нууруудын дунд орших толгойг Дойтын толгой гэнэ. Уг толгой дээр Дойтын туурь хэмээн нэрлэгдсэн дурсгал бий. Энд гол барилгын дөрвөн буланд барилгын суурь болох боржин чулуу, мөн голд нь нүх гаргасан баганын суурь чулуу хэд хэд бий. Нийтдээ 20 барилгын ор байгаа бөгөөд тоосго, дээврийн ваарны үлдэгдэл зэрэг нь Хархорумын өгэдэй хааны ордныхтой адил ажээ. Дойтын толгойн туурийг 1996 онд ЮНЕСКО-ийн “Эртний Хархорум хотын туурийг хамгаалах нь” төслийг хэрэгжүүлэхэд оролцсон Монгол, Японы археологичид Өгэдэй хааны “Гэгэ-чаган орд” мөн болов уу гэж үзсэн байна.

**БАЙРШИЛ:**

Архангай аймаг,  
Хотонт сумын төвөөс зүүн хойно 22 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Дойт толгойн ордны туурь байгалийн ба түүхийн дурсгал нэгэн зэрэг цогцолсон давуу талтай. Өнөөдр-ийн байдлаар сэргээн босголт, засварлалт, судалгаа шинжилгээ хийгээдгүйн дээр хатуу цэгийн баганан босгосон зэрэг сөрөг нөлөөлөл бий. Цаашдаа дойт толгойн ордны туурийн археологийн судалгаа, түүхийн чиглэлийн судалгааг нарийвчлан хийх хэрэгтэй. Жуулчдад зориулсан үйлчилгээ үзүүлдэг болгох шаардлагатай. Мөн хуучин байсан ордны зарим хэсгийг нь бүтээн босгох, иргэд жуулчдыг мэдээллээр бүрэн хангах зэрэг хийх ажлууд их байна.

**Чиглэл: Түүхийн дурсгалт газар**  
**Ангилал: Жуулчдын зорих газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Эрдэнэзуу хийдийн туурь нь 23 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр Эрдэнэзуу хийдийн туурь нь 50 оноо авсан нь харьцангуй ондор үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт шаардана.



**Нэр: ЭРДЭНЭЗУУ ХИЙДИЙН ТУУРЬ**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хархорин сумын төвд байрлаж буй 1586 онд барьж эхэлсэн. 108 суварга бүхий хэрмэн хашаатай. Бурхны шашны уран барилгын онцгой төрөл. Автай сайн хаан бурхны шашныг Монголд дэлгэрүүлэх зорилгоор байгуулсан.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төв



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Эрдэнэзуу хийдийн туурь одоогийн байдлаар Орхоны хөндийд жуулчид ихээр төвлөрсөн, бүс нутгийн аялал жуулчлалын маршрутад зайлшгүй дайран гардаг зангилаа юм. Тэр утгаараа жуулчдад үзүүлэх дайвар үйлчилгээг дээд зэргээр хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Өнөөдөр Эрдэнэзуу хийдийн хашаанд жуулчдад зориулсан өртөг нэмэгдүүлсэн үйлчилгээ маш бага байна. Маш бүдүүлэг, агуулгын хувьд ядмаг, цөөн хүний амьжиргаагаа залгуулах төдий л худалдаа, үйлчилгээ хөгжиж байгаа.

**Чиглэл: Түүх, соёлын дурсгал**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Эрхтэн чулуу нь 13 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Эрхтэн чулуу нь 50 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин хотын туурь, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=50**

Хархорин хотын туурийг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Эрхтэн чулуу**

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Эрхтэн чулуу нь шашин шүтлэг, сүсэг бишрэлийн дурсгал бөгөөд өнөөдрийн байдлаар дотоодын жуулчид илүү үзэж сонирхож байна. Урт хийцийн хувьд тийм ч гоц гойд зүйлгүй. Гэхдээ домог түүхтэй холбоотой, ёслол заншлын үнэт өв дурсгал тул хадгалалт хамгаалалтыг тусгай анхааран орон нутгийн хамгаалалтад авсан.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төвөөс зүүн урд зүгт 500 м-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Цаашдаа түүх домгийг илүү боловсронгуй болгож танилцуулах самбар, хадгалалт хамгаалалтыг илүү эрчимжүүлэх замаар гадны жуулчдын сонирхолыг татахад чиглэсэн ажлуудыг ихээр зохион байгуулах шаардлагатай. Үндсэн маршрутын замд ойрхон байрладаг давуу талаа ашиглан дайран өнгөрөх үзмэр байдлаар хөгжүүлэх хэрэгтэй. Хөрсний нуралтын асуудал ойр орчимд нь хүндрэлтэй байдлыг үүсгэх эрсдэл өндөр болж байгааг харгалзан хамгаалалтын далан босгох хэрэгцээтэй.

**Чиглэл:** Түүх соёлын дурсгалт, байгалийн үзэсгэлэт газар  
**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар

**Нэр:** Хаалган дэнжийн бугат хясаа



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хаалган дэнжийн бугат хясаа нь 14 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Хаалган дэнжийн багат хясаа нь 54 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хужиртын рашаан сувилалтай таталцах чадвар

**λ=54**

Хужирт зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хужирт сумын төвөөс баруун зүгт 38 км-т, 2-р багийн нутагт хаалган дэнжийн бугат хясаа гэдэг газар Орхон голын зүүн эргийн хананд буга, бусад ан амьтны цөөн тооны сүг зурагтай хаднууд байдаг. 2000 оны 9 дүгээр сард аймгийн бүртгэлд авсан. Мөн түүнчлэн 2001 оны 72 тоот тушаалаар аймгийн тусгай хамгаалалтад багтаасан. Одоо амтралт, жуулчлалын зориулалтаар ашиглагдаж буй юм.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хужирт сумын төвөөс баруун зүгт 38 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Хаалган дэнжийн бугат хясаа бол Хужирт сумын нутагт байрлах цөөн тооны байгалийн дурсгалт газруудын нэг бөгөөд түүх соёлын үнэт зүйл ба байгалийн үзэсгэлэн зэрэг хослосноороо онцлогтой. Одоогийн байдлаар жуулчдад зориулсан ямар нэгэн үйлчилгээ байхгүй бөгөөд зөвхөн байгалийн үзэсгэлэнт газар гэсэн нөөцийг ашиглан нэг жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь туйлын хангалтгүй бөгөөд цаашдаа жуулчдад зориулсан түүх соёл, байгалийн үзэсгэлэнг хослуулсан үйлчилгээ үзүүлэх чиглэлд бүтээн байгуулалт хийх шаардлагатай.

**Чиглэл:** Түүх соёлын дурсгалт газар

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хар чулуу хөшөө дурсгал нь 7 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Хар чулуу хөшөө дурсгал нь 55 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хужиртын рашаан сувилалтай таталцах чадвар

$$\lambda=54$$

Хужирт зорих газрыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Хар чулуун хөшөө

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хужирт сумын төвөөс хойш долоон км-т машин замын зүүн талд ганц хар чулуун хөшөө байрладаг. Дөрвөлжин булшгүй. Эргэн тойронд намхан дэрс ургасан, эгц босоо байрлалтай, босоо ширхэгтэй, хуудсаар цуурсан шинж байрлалтай хөшөө юм. Өндөр нь 143 см, өргөн нь 32 см, зузаан нь 18 см. Хөшөөн дээр бичиг, зураг мэтийн онцлог зүйлгүй, мал амьтэн шөргөөж, байгалийн нөлөөнд элэгдсэн. Хөшөө нь ямар нэг хүний булшин дээр босгосон болох нь ойлгомжтой боловч хөшөө чулууны гаднах шинж байдлаас харахад Хүрлийн үед хамаарах буган чулуун хөшөө бөгөөд жирийн дундаж зиндааны хүнд зориулсан булш гэж үздэг.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хужирт сумын төвөөс хойд зүгт долоон км-т байрладаг.




**ЦААШДЫН БОЛОМЖ**

Хужирт сумын нутагт байрладаг бус түүх, соёлын дурсгалт газруудтай харьцуулахад татах чадвар бага. Хужиртын рашаан сувилалд ойрхон байрладаг утгаараа зохистой менежмент хийснээр жуулчдын сонирхол татах газар болгох боломж бий. Энэхүү хар чулуун хөшөөг хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай. Аялал жуулчлалын нөөц газрын хувьд зөвхөн байршлын гэсэн давуу талаараа хамрагдаж буй гэдгийг тооцож бүтээн байгуулалтыг хийх тал дээр анхаарах хэрэгтэй.

**Чиглэл:** Рашаан сувилал

**Ангилал:** Жуулчдын зорих газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**  
Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хужирт-ын рашаан сувилал нь 21 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр Хужиртын рашаан сувлал 50 оноо авсан нь бас л хамгийн сайн үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлтүүд сайн байгаа газарт аялал жуулчлал бий болно.



**Нэр:** ХУЖИРТЫН РАШААН СУВИЛАЛ

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хангайн уулархаг мужид хvн ардын эрvvл мэндэд чухал ач тустай анагаах чадал бүхий халуун рашаан 40 гаруй байдаг. Тэдний нэг нь Хужиртын халуун рашаан юм. Эрт дээр цагаас Төв Азийн олон овог аймаг тvvний дотроос монголчууд байгалийн рашаан усыг ашиглаж, элдэв өвчин эмгэгийг сувилж ирсэн уламжлалтай. Хужиртын рашаан сувилал нь бөөр нуруу, ve моч, шар ус зэрэг элдэв бэртэнг гэмтэл, зvрх мэдрэлийн олон өвчнийг анагаах увидастай шавар эмчилгээг голлосон байдаг.

**Байршил:**  
Өвөрхангай аймаг,  
Хужирт сумын төв



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Одоо гагцхvv дотоодын зах зээлийн хэрэглэгчдэд вйлчилгээгээ хvргэж байна. Цаашдаа гадааддын жуулчдыг амруулахын тулд дээд зэрэглэлтэй зочид буудал, ресторан болон бусад жуулчдын вйлчилгээг бий болгох зайлшгvй шаардлагатай. Тvvнчлэн цэвэрлэх байгууламж, онгоцны буудал, засмал зам, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө гаргаж мөрдөх зэрэг олон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй. Орхоны бvс нутагт говь талаасаа орж ирэх замын зангилаа учраас аялал жуулчлалын дагалдсан вйлчилгээ сайн хөгжсөн байх нь илvv ашигтай.



**Чиглэл:** Түүх соёлын дурсгал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хүн чулуун увшхай нь 8 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Хүн чулуун увшхай нь 50 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хужиртын рашаан сувилалтай таталцах чадвар

**λ=50**

Хужирт зорих газрыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Хүн чулуун увшхай

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хүн чулуун увшхай Хужирт сумын төвөөс зүүн зүгт 40 км-т дулааны хуурай сэрвэнд байрлах бөгөөд 160 см өндөр, 86 см өргөн хэмжээтэй цээжин бие хүн чулуу. Хуурай сэрвэнгийн улаан хадны ханан хясааны урагш харсан хасаг тойрог хороонд байх бөгөөд увшхайн толгой хэсэг буюу нүд, ухархай, хөмсөг, чих, хамар, ам, эрүү, хацрыг тодорхой дүрслэсэн. Хүн чулууны биеийн доод хэсэг нь урд ууланд байдаг гэсэн домогтой. Нутгийн ард олон ихэд сүсэглэн тахидаг. Бор саарал өнгийн боржингоор хийгдсэн хүн чулуун увшхайн бүтээгдсэн он нь тодорхой бус боловч ерөнхий хийц байдал нь эзэнт гүрний үеийн Монголын хүн чулуун хөшөөтэй адилхан байх тул 13-р зууны үед хамааруулдаг боловч нарийн судлагдаагүй болно.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хужирт сумын төвөөс зүүн зүгт 40 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Хүн чулуун увшхай Хужирт сумын нутаг дэвсгэр дээр байгаа түүхийн болон шашин шүтлэг хослосон жуулчдыг татах нөөцийн нэг юм. Дэд бүтэц, тайлбар зурагжуулалт бүхий самбар, хог хаягдлын цэг зэргийг барьж байгуулах замаар дотоод, гадааддын аялагчдын зорих газар болгох нөөцтэй. Жуулчдад зориулсан үйлчилгээг хөгжүүлэх хэрэгтэй. Хүн чулуун хөшөөг эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах шаардлагатай.

**Чиглэл:** Рашаан сувилал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хөндлөн булгийн рашаан нь 10 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Хөндлөн булгийн рашаан 65 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хужиртын рашаан сувилалтай таталцах чадвар

**Λ=65**

Хужирт зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Хөндлөн булгийн хүйтэн рашаан

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хөндлөн булгийн хүйтэн рашаан Хужиртын рашаан сувилалд хамгийн ойрхон байрладаг. Жилийн дөрвөн улиралд тасралтгүй ундратай. Хүний ходоод, элэг, цөс зэрэг дотоод эртний үйл ажиллагааг тэнцвэржүүлэх эмчилгээний зориулалтаар ашигладаг. Нутгийн зарим иргэд хоол хүнсний унданд хэрэглэх нь бий. Рашааны ундрогын эх болон хүмүүсийн хэрэглээний ус авах цэг хоёрын хоорондын зай нь хэтэрхий бага байгаагаас бохирдол үүсэх магадлал өндөр байдаг.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хужирт сумын төвийн Зүүн өмнө зүгт байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Хөндлөн булгийн рашаан нь Монгол орны дэд бүтэц хамгийн сайн хөгжсөн халуун рашааны хажууд байрладаг давуу талаа ашиглан дотоод гадаадын жуулчдад үйлчлэх чиглэлээр хөгжих бололцоотой. Өнөөгийн байдлаар хөндлөн булгийн рашаан нь хадгалалт, хамгаалалт бараг байхгүй. Мөн тогтсон эзэмшигчгүй, орон нутгийн удирдлагын зүгээс ямар ч бодлого хэрэгжүүлэхгүй зэрэг дутагдал байна. Түүнчлэн рашааныг ашиглахад бүтээн байгуулалтын ажил ихээр шаардана. Рашааны ундрогын байдал, бүтэц найрлагад нарийвчилсан судалгаа хийж, урт хугацаанд тогтвортой ашиглах төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.

**Чиглэл: БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗАР, РАШААН СУВИЛАЛ**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хустын рашаан нь 12 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Хустын рашаан нь 27 оноо авсан нь дунд зэргийн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Улаан цутгалангийн хүрхрээтэй таталцах чадвар

**λ=27**

Улаан цутгаланг зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Хустын рашаан**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Бат-Өлзийт сумаас зүүн хойд зүгт 13 км-т Алаг толгой хайрханы зүүн өмнө байрладаг. Хуст нь хүйтэн рашааны төрөлд хамаарагдана. Өвөр талаас байгалийн үзэсгэлэнгээрээ илүү байдаг боловч замын хувьд хүндэрэлтэй. Эргэн тойрон арцаар хүрээлэгдсэн, хүрсэн чулууллаг дундаас урсан гарч байгаа гүний хүйтэн рашаан. Дотор эрхтэний үйл ажиллагааг сэргээн эмчилэх үйлчилгээтэй. Зун, намрын улиралд дотооддын амрагчид, жуулчид очиж өөрсдийн гэр, майхнаа барьж рашаан эмчилгээ хийдэг.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзийт сумын төвөөс зүүн зүгт 13 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Хустыг рашаан эмчилгээ, байгалийн үзэсгэлэнт газар, эрүүл агаарт амрах зэрэг чиглэлүүдийг хослуулах хэрэгтэй. Ойрчин тойрны газар зохион байгуулалтыг сайжруулах, хог хаягдлыг зөв зохион байгуулах, дотоодын амрагчдын буудаллах газрыг зааж өгөх, рашааны хэрэглээнд зорим тогтоох, усанд ямар нэгэн зүйлс хийхгүй байх, орчны бохирдлыг нөлөөлөгч ямар нэгэн үйлдлийг таслан зогсоох зэрэг олон хийгдэх шаардлагатай. Дотоод гадааддын жуулчдад зориулсан томоохон цогцолборуудыг байгуулах, энэ нь эргээд рашаан усны ундрагад сөрөг нөлөө үзүүлэхгүй, орчны тогтвортой нөхцөлийг бүрдүүлэгч байх ёстой.

**Чиглэл:** Рашаан эмчилгээ, сувилал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Хятрууны рашаан нь 10 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Хятрууны рашаан нь 45 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Улаан цутгалантай таталцах чадвар

**λ=45**

Улаан цутгаланг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Хятрууны рашаан

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Бат-Өлзий сумын нутаг Хятрууны амны эх зүүн урд хярд далайн түвшнээс дээш 2500 м өндөр өтгөн шинэс, хуш, хусан ойн дээд хилд оршино. Өндөр нурууны дээд хилд нэгэн халзад нүцгэрэн ил гарсан дунд зэрэг ширхэгтэй цайвар боржин хадан дотроос ориглон гарах олон тооны бүлээн халуун булагууд нийлж модон дундуур хятрууны амруу урсана. Далайн түвшнээс дээш нилээд өндөр байрлах тул сэвэлзсэн салхи ихтэй 7-р сард амандаа бороо орж байхад рашаан дээрээ цас орж байдаг байгалийн өвөрмөц тогтоц бүхий эмчилгээний өндөр ач холбогдолтой рашаан юм. 1945 онд оросын эрдэмтэд найрлага чанарыг тогтоосон. Хятрууны рашааны хамгийн халуун булаг нь 36 градус байдаг бол хамгийн хүйтэн нь 2 градус байдаг байна.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзийт сумын төвөөс баруун зүгт 30 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Хятрууны рашаан байгалийн үзэсгэлэнт газар байрладаг эмчилгээний өндөр ач холбогдолтой рашаан. Одоогийн байдлаар орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллага бага хэмжээний бүтээн байгуулалт хийсэн. Цаашдаа Хархорины бүс нутагт халуун рашаан эмчилгээний томоохон төв болгохын тулд байгаль орчины үнэлгээнд тулгууралсан томоохон хэмжээний бүтээн байгуулалт хийх нь хэрэгтэй. Гэхдээ Хятрууны рашаан нь Хангайн нурууны хамгийн чухал хэсэгт байрладаг учраас олон хүний төвлөрлийг урт хугацаанд байлгаж болохгүй.

**Чиглэл:** Түүхийн дурсгалт газар  
**Ангилал:** Жуулчдын зорих газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Хархорум хотын туурь нь 12 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр Хотын туурь нь 45 оноо авсан нь харьцангуй ондр үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт шаардана.



**Нэр:** ХАРХОРУМ ХОТЫН ТУУРЬ

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Эртний Хархорин хотын туурийн хувьд одоогоор ч бүрэн судлагдаагүй үе үеийн экспедиц малтлага хийсээр байна. Энэ нь тухайн түүхийн дурсгалын талаарх мэдээллийн санг өрөгжүүлж байгаа сайн талтай боловч эд өлгийн зүйлс алдагдах гадагшаа хил даван гарч байгаа эсэх талаарх мэдээлэл орон нутгийн хувьд ч төр засгийн түвшинд ч хяналт султай муу талтай байна.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг,  
Хархорин сумын төв




**ЦААШДЫН БОЛОМЖ**

Монголын эзэнт гүрний алдарт нийслэл хотын өнөөгийн дүр төрх нь жуулчдын сонирхолыг ихэд татдаг. Гэхдээ ирсэн аялагчид сэтгэл дундуур буцдаг. Учир нь түүх нийслэлийг илэрхийлсэн ямарч байгууламж, барилга байхгүй, мэдээлэл танилцуулгагүй байна. Жуулчлалын гол зангилаа цэг, дагалдах үйлчилгээ төвлөрсөн суурингийн хажууд байрладаг боловч өнөөдөр ямар менежментгүй, зөвхөн нэр төдий байгаа нь цаашдаа олон зүйлийг хийхийг шаардах боллоо. Тухайлбал хуучин нийслэлийг санагдуулсан томоохон байгууламж барих, археологийн олдворуудаар музей байгуулах, хамгаалалт, газрын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэдээлэл, сурталчилгааны нэгдсэн системийг бүрдүүлэх гэх мэт олон ажлуудыг хийх шаардлагатай.

**Чиглэл:** Түүхийн дурсгалт газар  
**Ангилал:** Жуулчдын зорих газар

**Нэр:** БИЛГЭ ХААН, ТОНЬКУКИЙН ЦОГЦОЛБОР



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Цогцолбор нь 20 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр Цогцолобор нь 45 оноо авсан нь харьцангуй ондор үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт бага шаардана.



**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хархорин хотоос зүүн хойт зүгт 45 км зайтай, Орхон голын баруун эрэгт байрлана. Энэ нь Зүүн Түрэг улсын төрийн нэрт зүтгэлтэн Билгэ хаан (683-734) болон Культегин (Түрэгийн цэргийн жанжин, Билгэ хааны дүү, 684-731) нарын дурсгалд зориулан босгосон хоёр цогцолбороос бүрдээнэ. Эдгээр дурсгалууд Төв Азид манай эриний VI-VIII зуунд ноёрхож байсан Түрэгийн эзэнт гүрний хамгийн чухалд тооцогддог. Энэ дурсгал дээр бичигдсэн Түрэгийн руни бичээс Төв азийн түүх, соёлын судалгаанд хосгүй үнэтэй мэдээллийг хадгалж байдаг.

**БАЙРШИЛ:**

Архангай аймаг,  
Хашаат сум  
Орхон голын баруун эрэгт, Хархорин сумаас зүүн хойш 45 км-т оршино



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Билгэ хаан, Культегин нарын дурсгалд зориулсан цогцолбор нь Орхоны хөндийн аялал жуулчлалд цаашдаа томоохон байр суурь эзлэх цогцолбор бөгөөд үзмэрүүдийг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, олон нийтд сурталчлах тал дээр жишиг болохуйц байгууламж юм.

**Чиглэл: Түүх, соёлын дурсгал**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Мэлхий ба мэлхий толгой нь 13 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Мэлхий ба мэлхий толгой нь 50 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин хотын туурь, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=50**

Хархорин хотын туурийг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Мэлхий, мэлхий толгой**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хархорин сумын төвийн урд орших Маамуу толгойн (Мэлхийт толгой) оройд 106x78 хэмжээтэй эртний нэгэн хотын туурь бий. Энд дөрвөлжин хэлбэрийн шавар хананы үлдэгдэл бий. Өргөн хананы дотор хоёр жижиг ханатай бөгөөд одоо үлдэгдэл шороон далан газрын хөрснөөс овойн харагдаж байна. Уг шороон далангийн зүүн хойд захад боржин чулуугаар урласан нэг мэлхий чулуу бий.

Хархорум хотын туурь, мэлхийн толгойн орой, Хархорин сумын төвөөс баруун зүгт 10 км-т байрлах эдгээр гурван мэлхий нь урт хийцийн хувьд их нарийн бөгөөд түүхийн хувьд хоорондоо нягт уялдаатай зэрэг нь түүх соёлын аялагчдын сонирхолыг татах бололцоотой.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төвөөс урд зүгт 500 м-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Мэлхий толгойн ордны туурь ба мэлхий чулуун дурсгал нь жуулчдын үндсэн маршрутд хамгийн ойр байрладаг давуу талдаа түшиглэн жуулчдын зорих газар болон хөгжих боломжтой.

Ордны туурийг сэргээн засварлах, хуучин ордныг дууриалгасан үзмэр бүтээх, машины зогсоол, танилцуулах самбар хийх, жуулчны улиралд байнгын тайлбарлагчийг ажиллуулах зэрэг бүтээн байгуулалт хийх хэрэгтэй.

Бэлэг дурсгалын худалдааны одоогийн байгаа лангууг доош нь буулгах, толгойн орчмыг цэвэрлэх зэрэг олон ажил хийх шаардлагатай.

**Чиглэл:** Рашаан, байгалийн үзэсгэлэн

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Могойтын рашаан нь 14 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Могойтын рашаан нь 30 оноо авсан нь өндөр зэргийн үзвэлтэй байна. Ийм үзвэлтэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Улаан цутгалан байгалийн үзэсгэлэнт газартай таталцах чадвар

$\lambda=30$

Улаан цутгалан зорих газрыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Могойтын рашаан

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Могойтын рашаан бол Хангай нурууны зүүн хойд хэсэгт байрлаж байгаа томоохон халуун рашааны нэг бөгөөд эргэн тойрон ойд модоор хүрээлэгдсэн байгалийн үзэсгэлэн төгс бүрдсэн газарт байрладаг. Үе мөчний бүх төрлийн өвчинд тустай. Өнөөдрийн байдлаар дотоодын эмчлүүлэгчид, аялагчид эмчилгээ ачлалын зорилгоор очдог.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзийт сумын төвөөс баруун зүгт 7 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Цаашдаа Могойтын рашааныг иж бүрэн хэмжээнд хөгжүүлэх хэрэгтэй. Одоогийн байдлаар дэд бүтэц, гэрэл цахилгаангүй байгаа. Амрагчдыг олноор нь хүлээн авах хүчин чадалтай амралтын газар бас байхгүй. Тогтсон зан үйл, нэгдсэн зохион байгуулалт байхгүй, рашааны хамгаалалт сул зэрэг доголдол байгаа. Эдгээр сул талаа арилгаж цаашдаа цэвэр агаар, онгон байгаль, халуун рашаандаа тулгуурлан амралт зугаалга, аялал жуулчлал, эмчилгээний том төв болон хөгжих ирээдүйтэй.



**Чиглэл:** Түүх, соёлын дурсгал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Орхон-7 нь 10 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Орхон-7 нь 55 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин хотын туурь, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=50**

Хархорин хотын туурийг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Дунд палеолитын үеийн "Орхон-7" дурсгалт газар

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хархорин сумын төвөөс баруун урагш 7 км Ухны гацаа хэмээх газарт уг дурсгал байна. Орхон-7 чулуун зэвсгийн суурин нь монголын палеолитын үеийн томоохон дурсгалуудын нэг юм. 1985 онд Монгол зөвлөлтийн эрдэмтэд нээсэн малтлагийн явцад 10000 гаруй чулуун зэвсгийн дурсгал гарсан 11 соёлт давхарага гарсан нийт 10 дахь давхрага нь хамгийн эртний үед холбогдоно. Он цагын хувьд 62,5 мянган жилийн өмнөх үеийнх гэж тогтоогдсон. Үүний баруун урд талд дөрвөлжин хүрээтэй, төв хэсэгтээ дугуй дараастай хиргисүүр нэг бий.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хархорин сумын төвөөс баруун зүгт 4 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Орхон-7 бол Хархорины бүсийн аялал жуулчлалын нэн чухал татах чадвар бүхий нөөц юм. Иймд тус дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох болон хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг хангахтай холбоотой бүтээн байгуулалтуудыг хийх шаардлагатай. Хархорин сумын төвтэй ойрхон байрладаг, дэд бүтцийн хүндрэл багатай зэрэг давуу талуудад дээр үндэслэн

**Чиглэл:** Түүх, соёлын дурсгал

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдыг татах чадварын үнэлгээгээр Шанхын хийд нь 11 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Шанхын хийд нь 50 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хархорин хотын туурь, Эрдэнэзуутай таталцах чадвар

**λ=50**

Хархорин хотын туурийг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Шанхын хийд

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Энэ хүрээ одоогийн Шанх багийн төвд байдаг. 1654 онд Номын их хүрээ Орхон голын хөндийгөөс Хэнтий уулын өвөр тийш нүүхэд Өндөр Гэгээн Занабазар төрсөн дүү сайван Билбидоржид Номын их хүрээний үлдсэн хэсэг, мөн түүхий эх сурвалж бичиг баримт, түүх дурсгалын гол зүйлүүдийг үлдээж нүүсэн байна. Баруун талд үлдсэн хэсгийг олны дотор Баруун хүрээ хэмээн нэрлэх болжээ. Шанх уулын өвөр талд бууриших болсноос Шанхын хүрээ гэж мөн нэрлэнэ. Үүний учир үүссэн түүх нь Номын хүрээ буюу богдын хүрээний гарал үүсэлтэй холбогдоно.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг,  
Хархорин сумын төвөөс зүүн урд зүгт 22 м-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Шанхын хийд нь Хархорины бүсийн түүх, соёлын аялал жуулчлалын томоохон зорих газар болон хөгжих боломжтой. Үүний тулд сэргээн засварлалт, хамгаалалт, мэдээлэл сурталчилгаа хийх шаардлагатай. Эдгээр бүтээн байгуулалтаас гадна шанхын хийдийн судалгаа, эрдэм шинжилгээнд чухал ач холбогдол өгч, түүхчид, эрдэмтдийн анхаарлыг хандуулах замаар Шанхын хийдийн мэдээлэл, сурталчилгааг чанарын өөр түвшинд хүргэх хэрэгтэй.

**Чиглэл:** Түүх соёлын дурсгалт газар  
**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Шунхлай уулын дурсгалууд нь 13 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Шунхлай уулын дурсгал нь 55 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт шаардана.

Хужиртын рашаан сувилалтай таталцах чадвар

**λ=55**

Хужирт зорих газрыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Шунхлай уулын дөрвөлжин булш, хиригсүүр

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хужирт сумын төвийн баруун хойд талд байх хойноос урагш дэллэж орсон уулыг Шунхлай уул гэх ба уг уулын баруун урдаас зүүн хойд бэл хүртэл нийтдээ 45 дөрвөлжин булш, 20 орчим дугуй дараастай булш, 30 орчим хиргисүүр бий. Энд буй дөрвөлжин булшнаас зарим нэгийг малтаж судалсан байдаг бөгөөд тун саяхан нэг булшийг дооноглон малтаж тоносон байна.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хужирт сумын төв, Шунхлайн уулын эргэн тойронд



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Шунхлай уулын эргэн тойрны булш, хиригсүүрүүд нь хоорондоо асар ойрхон боловч тооны хувьд олон юм. Түүнчлэн дотоод, гадаадын жуулчдын томоохон зорих газрын нэг болох Хужиртын рашаан сувилалын ойролцоо байдаг. Орхоны хөндийд байрлаж байгаа адил төрлийн түүх соёлын дурсгалуудыг бүрэн төлөөлөлж болж чадахуйц бөгөөд малтлаг хийгдэн судлагдсан зэрэг давуу талтай. Гэхдээ өнөөдрийн байдлаар бусад түүх, соёлын дурсгалуудын адилаар ямар ч менежмент, хадгалалт хамгаалалтгүй байгаа. Цаашдаа эдгээр давуу талаа ашиглан зөв менежмент хэрэгжүүлснээр жуулчдын сонирхолыг татсан газар болох бүрэн боломжтой.

**Чиглэл: TVVX СОЁЛЫН ГАЗАР**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Тэмээн чулууны амны дурсгал нь 10 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Тэмээн чулууны амны дурсгал нь 27 оноо авсан нь дунд зэргийн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Улаан цутгалангийн хврхрээтэй таталцах чадвар

$$\lambda = 27$$

Улаан цутгаланг зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Тэмээн чулууний амны**

**дөрвөлжин булш**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Орхон голын баруун тал, Цагаан голын цутгалаас 1 км-т Тэмээн чулууны ам хэмээх газарт дөрвөлжин булшны бүлэг дурсгал бий. Энд нийтдээ 30 орчим дөрвөлжин булш бий бөгөөд үүнээс цөөн хэдийг малтан судалсан билээ. Эдгээр дөрвөлжин булшийг үйлдэхдээ зарим нэг булшинд нийт таван буган чулуун хөшөөг ашигласан байдаг. Дөрвөлжин булшнуудын урд захруу буй нэг булшны баруун хойш харсан өндөр хашлаганы хананд 14 хүнийг гар гараасаа хөтлөцсөн байдалтайгаар улаан зоосоор дүрсэлсэн нь нэлээд сонирхолтой юм. Үүнээс өгсөхөд уулын бэлээр ганц нэгээр болон хэд хэдээрээ нийтдээ 14 дөрвөлжин булш, нэг хиргисүүр, дугуй дараастай булш 3 бий.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзийт сумын төвөөс зүүн зүгт 12 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Тэмээн чулууны амны бүлэг дурсгал бол Орхоны хөндийд байрлаж буй багц дурсгал (орон зайн хувьд ойролцоо)-уудын нэг юм. Түүнчлэн үндсэн маршрутын замд ойролцоо байдаг давуу талтай. Буган чулуун хөшөөг дөрвөлжин булшинд оролцуулан хийсэн илүү үнэ цэнэтэй түүхийн дурсгал болгож буй юм. Энд тайлбар мэдээллийн самбар, үзмэрийн танхим, тайлбарлагч, машины зогсоол, хог хаягдлын цэг зэрэг бүтээн байгуулалтуудыг барьж байгуулах шаардлагатай.

**Чиглэл: БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ ГАЗАР**

**Ангилал: Жуулчдыг татах чадвартай нөөц газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Цагаан голын хүрхрээ нь 16 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Цагаан голын хүрхрээ нь 28 оноо авсан нь дунд зэргийн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Улаан цутгалангийн хүрхрээтэй таталцах чадвар

**λ=28**

Улаан цутгаланг зорих газарыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр: Цагаан голын хүрхрээ**

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Бат-Өлзийт сумын төвөөс зүүн хойд зүгт 16 км-т байрладаг. Ойролцоогоор 2 метрийн өндөрөөс унадаг. Хустын гол, Цагаан гол, Орхоны голуудын уулзвар хэсэг байрлах ба хархираа ихтэй. Эргэн тойрныг харах цэлгэр уужим товцог өмнө талд байдаг. Хуучирч муудсан малын жижиг хороо, ил задгай асгасан хог ихтэй. Дотоодын амрагчид болон Хашхан баазд ирсэн гадаадын амрагчид үзэж сонирхдог. Хүрхэрээний доод талаас ажиглахад илүү тааламжтай бөгөөд зуны халуунд сэрүүхэн байдаг. Цагаа гол үер ихтэй тохиолдолд зөвхөн урд эрэг дээрээс нь үзэх боломжтой. Гол ус ихэнхдээ тунгалаг, загас ихтэй үедээ цутгалаа өгсөн засаг дээш үсрэх нь гоёмсог харагддаг байсан. Сүүлийн жилүүдэд засаг ховордсон.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Бат-Өлзийт сумын төвөөс зүүн зүгт 40 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Цагаан голын хүрхрээ бол байгалийн үзэсгэлэнт газар бөгөөд байрлалын хувьд Хужирт, Бат-Өлзийт сумдын нутгийн жуулчдыг татах чадвар бүхий нөөц болон зорих газруудын дунд оршдог. Жуулчдын гол маршрутын замд ойролцоо байрладаг давуу талтай. Гэхдээ ойр орчныг нь засаг сайжруулах шаардлагатай. Тухайлбал хүрээлэн буй орчныг хог, чулуу, мал сэг, ялгадасаас нь арилгах, хуучин барилга байшин, чулуун хороо зэргийг буулгах хэрэгтэй. Нөгөө талаас жуулчдад зориулсан үйлчилгээ, жуулчны баазуудын үйлчилгээг сайжруулах асуудал тулгамдаж байна.

**Чиглэл:** Байгалийн үзэсгэлэнт, соёл дурсгалт газар

**Ангилал:** Жуулчдын зорих газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**  
Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Төвхөн хийд нь 19 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр улаан цутгалан 29 оноо авсан нь өндөр үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.



**Нэр:** ТӨВХӨН ХИЙД

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Хархорин хотоос баруун зүгт 80 км, өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын төвөөс хойш 20 км, Орхон голын хойт талд, Архангай, Өвөрхангай аймгуудын зааг Төвхөн ширээт уулын оройд байрладаг. Анхдугаар богд өндөр Гэгээн Занабазар байгуулсан. Бясалгал үйлдээх, уран бүтээл туурвих газраа болгож байжээ. Алдартай бурхадуудаа энд цутгасан гэдэг.

**БАЙРШИЛ:**  
Өвөрхангай аймаг,  
Бат-Өлзийт сум



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Төвхөн хийд өнөөдрийн байдлаар дотоодын жуулчид, шарын шашны сүсэгтэн олны хөлд дарагдаад байна. Орчны байгальд өөрчлөлт орж, горхи булаг ширгэж байгаа. Ямар ч зохион байгуулалт, нэгдсэн удирдлага байхгүй. Төвхөн ширээ уулын бүхэлдээ хог хаягдал ихтэй болсон зэрэг жуулчлалаас үүдэлтэй сөрөг үр дагварын илэрэл ихтэй болсон. Иймд цаашдаа машины зогсоол, уул өөд өгсөж гарах зориулалтын шат хийх, мэдээллийн самбар, хогийн савыг олноор байрлуулах, аялагчдын аюулгүй байдлыг хангах, хоноглох, ил гал гаргах газруудыг зааг өгөх, хадаг хийморийн дарцаг олгох газруудыг зааж өгөх болон бусад нэмэлт үйлчилгээг сайтар хөгжүүлэх хэрэгтэй.

**Чиглэл:** Байгалийн үзэсгэлэт газар

**Ангилал:** Жуулчдын зорих газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Өгийнуур нь 14 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр Өгийнуур 45 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт бага шаардана.



**Нэр:** Өгийнуур

**ТӨВЧ ТАНИЛЦУУЛГА**

Нуурт Хөгшин Орхоны 1 салаа цутгаж Орхон голтой нийлдэг 25 км/кв талбайтай, 7.4 км урт, 8.3 км өргөн, эргийн шугамын урт 24.7 км урт, 15.3 м гүн, 147.9 сая м/куб эзэлхүүнтэй, 11-4-р сар хүртэл хөлддөг нуур. Нуурын ёроолд хүхэр, ус төрөгчөөр баялаг лаг шавартай. Эргийн дагуу элс, хайргатай ба гүехэн хэсгээр усны ургамал шигүү ургадаг. Усны эрдэсжилт 499.7-517.2 мг/л, химийн найрлагаараа гидрокорбанат сульфат ангийн натри, магни, кальцийн бүлэгт багтана. Уусмал устөрөгчийн хэмжээ 12.9 мг/л. Нуурт нүүдлийн шувууд элбэг, улаан нүдэн, цурхай, тул, зэвэг, алгана, гутаар, бух загас, мөнгөлөг хэлтэг зэрэг 14 зүйл загас амьдардаг.

**БАЙРШИЛ:**

Архангай аймаг,  
Өгийнуур сум  
сумаас зүүн хойш  
13 гаруй км-т оршино



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Өгийнуур бол өнөөдрийн Орхоны хөндийн аялал жуулчлал хамгийн сайн хөгжилтэй газруудын нэг төдийгүй цаашдаа асар их ирээдүйтэй. Гэхдээ өнөөдөр нууранд тулгамдсан, шийдвэрлэхээ цагаа хүлээж хуримтлагдсан олон асуудал бий. Тухайлбал нуурийн түвшин доошилж байна, нуур сэлгэхээ больсон, хөрсний талхалалт, элсний нүүдэл эрс нэмэгдсэн, загасны төрөл зүйл хомсдол, хүн малын тоо хэт олширсон, нэгдмэл зохион байгуулалтгүй зэрэг олон асуудал байна. Өгийнуурын орчимд цаашдаа аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нуурын тогтвортой байдлыг онцгой анхаарах хэрэгтэй. Орчимд байх суурин мал хүний тоо, жуулчны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын тоо зэргийг нарийн тогтоох тогтвортой байдлын иж бүрэн үнэлгээ, түүнд суурилсан ашиглалтын төлөвлөгөө гаргах.

**Чиглэл: Түүхийн дурсгалт газар**

**Ангилал: Жуулчдын зорих газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Уйгарын хар балгас нь 14 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр улаан цутгалан 8 оноо авсан нь харьцангуй бага үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт ихээр шаардана.



**Нэр: УЙГАРЫН ХАР БАЛГАС**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Археологийн малтлага судалгаа болон судар бичгийн мэдээгээр Хар балгас нь Уйгурын хаан төрийн өргөө, төрийн яам, гар үйлдвэр, худалдааны хороод, шашны сүм, бэхэлсэн цайз хэрмээс бүрдсэн урагш 25 км зайд үргэлжилсэн их хот байсан нь тогтоогджээ. Түүнээс гадна хааны ордонд холбогдох хааны бурхан шүтээн байсан бололтой сүмийн туурь байх ба түүний үүдэнд согд, руни, хятад бичээстэй гэрэлт хөшөөд байсан бөгөөд хагарч хугаран олон хэсэг болсноос одоо 10 гаруй хэсэг нь тэнд буй.

**БАЙРШИЛ:**

Архангай аймаг,  
Хотонт сум  
Орхон голын зүүн эрэгт, Хотонт сумаас зүүн хойш 10 гаруй км-т оршино



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Уйгарын хар балгас аялал жуулчлалын бүтээгдэхүүн болж чадаагүй боловч сонирхол татахуйц зорих газар. Хамгаалалтгүй, мэдээллийн самбаргүй, хөтөч тайлбарлагчгүй, жуулчидад зориулсан үйлчилгээ байхгүй зэрэг олон дутагдалтай. Цаашдаа эдгээр дутагдлуудаа арилгаж жуулчлалын гол маршрутын замд байдаг үндсэн давуу талаа ашиглан жуулчлалын томоохон цогцолбор болон хөгжих ирээдүйтэй. Түүхийн дурсгал талаас хосгүй үнэ цэнэтэй гэдгийг илтгэн харуулахуйц таниулах, мэдээлэх тал дээр анхаарах нөгөө талаас одоогийн байдлыг сайжруулах, нөхөн сэргээх, бүтээн байгуулалт хийх, хадгалалт хамгаалалтад онцгой анхаарал хандуулснаар аялал жуулчлалын татах хүчтэй бүхий төв болж чадна.



**Чиглэл: Байгалийн үзэсгэлэнт газар**

**Ангилал: Жуулчдын зорих газар**



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**  
Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Улаан цутгалан нь 20 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх вед татах чадвар ихтэй зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн татах чадварын үнэлгээгээр улаан цутгалан 25 оноо авсан нь бас л дундаж үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдын зорих газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой.



**Нэр: УЛААН ЦУТГАЛАН**

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Улаан голд үүссэн 24 м өндөр ханан эгц хүрмэн чулуун хавцал дундуур урсах бөгөөд энэ хавцал руу Хятрууны нуруунаас эх авсан Улаан гол буухдаа уг хүрхрээг үүсгэжээ. Орхон гол нь Хятрууны нуруунаас Хархорин хүртэлх 130 км газар галт уулын дэлбэрэлтээс үүссэн хүрмэн чулуун дундуур урсдаг. Энэ нь дөрөвдөгч галавын үед Хангайн нол нуруунаас эх авсан Цагаан азарга голын эхэнд галт уул дэлбэрсэнээс Орхоны хөндийг уруудан тогтсон хэдэн арван метр хүрмэн чулуун хучлага юм.

**Байршил:**  
Өвөрхангай аймаг,  
Бат-Өлзийт сум



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Улаан цутгалан бол Орхоны хөндийд буй байгалийн хамгийн үзэсгэлэнтэй газар. Жилдээ хамгийн олон жуулчид үзэж сонирхдог, төв ба хангайн бүсийн аялал жуулчлалын маршрутуудын заавал дайран өнгөрдөг. Хэдийгээр байгалийн өвөрмөц тогтоц боловч хүрээлэн буй орчны хамгаалалт сул, хог хаягдлын менежментгүй, нэмэлт үйлчилгээ, үзүүлбэр байхгүй зэрэг дутагдалтай. Цаашдаа байгалийн үзэсгэлэн ба бүтээн байгуулалт хослосон жуулчлалын цогцолбор байдлаар хөгжүүлэх боломжтой. Тухайлбал цутгалангийн орчмыг хаших, хүрхрээ үзэх тавцан хийх, дээш гарах, доошоо буухад зориулсан шат, олс зэрэг байгуулалт хийх.

**Чиглэл:** Түүхийн дурсгалт, байгалийн үзэсгэлэт газар

**Ангилал:** Жуулчдыг татах чадвартай нөөц газар



**ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ**

Жуулчдын зорих газрын үнэлгээгээр Үүртийн тохой нь 13 оноо авсан. Тус үнэлгээний нийт дүн 12-аас дээш байх үед татах чадвартай зорих газар гэсэн ангилалд хамруулдаг. Түүнчлэн таталцах чадварын үнэлгээгээр Үүртийн тохой нь 53 оноо авсан нь харьцангуй сайн үзүүлэлттэй байна. Ийм үзүүлэлттэй жуулчдыг татах чадвартай газарт аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ч бүтээн байгуулалт, сэргээн босголт шаардана.

Хужиртын рашаан сувилалтай таталцах чадвар

**λ=53**

Хужирт зорих газрыг маршрутдаа оруулсан аялагчдын хувьд нэгдмэл сонирхолтой газар юм.

**Нэр:** Үүртийн тохой

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Үүртийн тохой (хүүртийн тохой) Өвөрхангай аймгийн Хужирт сумын төвөөс буруун зүгт 40 км-т оршдог бөгөөд Бат-Өлзийт сумын хилийн зааг юм. Орхон гол, Цагаан голууд нийлсэн цутгалтай ойролцоо бөгөөд уулын сархиа руу гол түр орсон тохой юм. Тохойн өндөр нь 80 орчим метр 70-75 градусын налалт бүхий хавцалтай. Тохойн хэсэгт Орхон голын ус гүнзгий болох бөгөөд засаг элбэгтэй болдог. Зуны улиралд загасчдын очих тохиромжтой газруудын нэг болдог. Үүртийн тохойн доод хэсгээс хүйтэн болон гаазтай рашаан гардаг. Тохойн дээр болон доод аль талаас нь харсан байгалийн өвөрмөц сонин тогтоцыг ажиглаж болох бөгөөд дээд хэсгээс нь Орхоны хөндийн үзэсгэлт төрхийг харах бололцоотой.

**БАЙРШИЛ:**

Өвөрхангай аймаг, Хужирт сумын төвөөс баруун зүгт 40 км-т байрладаг.



**ЦААШДЫН БОЛОМЖ**

Үүртийн тохой нь байгалийн өвөрмөц тогтоц, орхоны хөндий аялал жуулчлалын гол маршрутын замд байдаг зэрэг давуу талуудаа ашиглан жуулчдыг татах газар болох боломжтой. Гэхдээ цаашдаа бага хэмжээний бүтээн байгуулалт шаардлагатай. Тухайлбал дээд гарах, доошоо буух шат, байгалийн үзэсгэлэнт тогтоцыг ажиглах цэг, майхан барих газрууд, хог хаягдлыг хийх цэг, засагчдад зориулсан талбай зэргийг барьж байгуулах хэрэгтэй. Түүнчлэн байгалиар аялах боломжийг олгох, ойролцоо өндөр зэрэглэлийн жуулчны бааз байгуулах шаардлагатай.